



ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ



ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН

**“ҮНДСЭН ХУУЛТ ЁСНЫ ТӨЛӨВШИЛ,
ЦААШДЫН ХАНДЛАГА”
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ**
(Илтгэлийн эмхтгэл)

Улаанбаатар хот
2012 он

**“ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ТӨЛӨВШИЛ,
ЦААШДЫН ХАНДЛАГА”**

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ
Улаанбаатар хот, 2012 оны 7 дугаар сарын 3

(Илтгэлийн эмхтгэл)

**“ENTWICKLUNGSFRAGEN
UND -TENDENZEN DES
VERFASSUNGSSTAATES”**

INTERNATIONALE WISSENSCHAFTLICHE KONFERENZ

Ulaanbaatar, 3.Juli 2012

(Vortragssammlung)

DDC
342.03
V-823

Эмхтгэсэн: Үндсэн хуулийн цэц
Ханнс-Зайделийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газар

Бичгийн орчуулга: /англи хэлнээс/ Д. Сарантуяа
/герман хэлнээс/ С. Мөнхжаргал
/орос хэлнээс/ Ё. Өнөрбаяр
А. Энхтуяа

Herausgegeben von: Verfassungsgericht der Mongolei
Vertretung der Hanns-Seidel-Stiftung
in der Mongolei

schriftliche Übersetzung: S. Munkhjargal (Deutsch)
D. Sarantuya (Englisch)
Yo. Unurbayar (Russisch)
A. Enkhtuya (Russisch)

ISBN: 978-99962-64-13-9

ГАРЧИГ

Өмнөх үг 8

Монгол Улсын Ерөнхийлөгч
Ц. Элбэгдоржийн мэндчилгээ 10

Монгол Улсын Их Хурлын дарга
Д. Дэмбэрэлийн мэндчилгээ 13

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн
Зүүн хойд азийн хэлтсийн Монголын асуудал
хариуцсан төлөөлөгч А. Бирлегийн мэндчилгээ 15

ИЛТГЭЛ

“Үндсэн хуулийн цэц ба үндсэн хуульт ёсны төлөвшил”
Илтгэгч: Доктор, профессор Н. Жанцан, Үндсэн хуулийн
цэцийн орлогч дарга, Монгол Улсын Гавьяат хуульч 27

“Үндсэн хуулийн хямрал”
Илтгэгч: Академич Ж. Амарсанаа, Үндсэн хуулийн
цэцийн дарга, Монгол Улсын Гавьяат хуульч 36

**“Үндсэн хуулийн шүүхт ёсны үзэл баримтлал:
Орос улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүн таслах
ажиллагааны практикийн хүрээнд асуудлыг тавих нь”**
Илтгэгч: Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор Н.С. Бондарь, ОХУ-ын Үндсэн хуулийн
шүүхийн шүүгч, ОХУ-ын шинжлэх ухааны Гавьяат
зүтгэлтэн, ОХУ-ын Гавьяат хуульч 46

- “Концепция судебного конституционализма: постановка проблемы в свете практики конституционного правосудия в России”**
Н.С.Бондарь, судья Конституционного Суда Российской Федерации, доктор юридических наук, профессор, Заслуженный деятель науки РФ, Заслуженный юрист РФ . . . 69
- “Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хэм хэмжээ тогтоох шинж чанар: ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн туршлага”**
Илтгэгч: Доктор В.А.Сивицкий, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газрын орлогч дарга 94
- “Нормативная природа решений органа конституционного правосудия: опыт Конституционного Суда Российской Федерации”**
В. А. Сивицкий, заместитель руководителя Секретариата Конституционного Суда Российской Федерации, кандидат юридических наук. . . 107
- “Үндсэн хуулийн ардчиллыг тогтоох явдал ба үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа, Солонгос улсын Үндсэн хуулийн шүүхийн туршлагаас”**
Илтгэгч: Хан Чул Парк, БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч 121
- “Establishment of Constitutional Democracy and Constitutional Adjudication-From the Perspectives of Korean Experience in Constitutional Adjudication”**
Han-Chul Park, Justice, Constitutional Court of Korea . . . 138
- “Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх нь”**
Илтгэгч: Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц. Сарантуяа, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын Гавьяат хуульч 152

**“Холбооны Үндсэн хуулийн шүүх ХБНГУ-ын
эрх зүйт төр ба ардчиллын баталгаа болох нь”**

Илтгэгч: Доктор Дитер Хёмиг, ХБНГУ-ын
Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгч асан 162

“Үндсэн хуулийн шүүх ба ардчилал: Туркийн ирээдүй”

Илтгэгч: Доктор, профессор Енгин Илдирим,
БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч 180

**“Constitutional Courts and Democratization:
a Turkish perspective”**

Prof.Dr. Engin Yildirim, Judge of the Constitutional
Court of Turkey 188

“Үндсэн хуулийн шүүх ба улс төр”

Илтгэгч: Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор Ч. Энхбаатар, Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн
Захиргааны сургуулийн захирал, Үндсэн хуулийн
цэцийн гишүүн асан, Цэцийн зөвлөх 195

INHALTSVERZEICHNIS

VORWORT **9**

Grußwort. Ts. Elbegdorj,
Staatspräsident der Mongolei 10

Grußwort. D. Demberel, Präsident des
Großen Staatskhural (Parlament) der Mongolei 13

Grußwort. A. Birle, Vertreter der Hanns-Seidel-Stiftung e.V.,
München, Referat Nordostasien 21

VORTRÄGE

“Verfassungsgericht und die Entwicklung des Verfassungsstaates”

Referent: Prof. Dr. N. Jantsan, stellvertretender Vorsitzender des
Verfassungsgerichts der Mongolei, Verdienter Jurist der Mongolei . . . 27

“Verfassungskrise”

Referent: Akademiker J. Amarsanaa,
Vorsitzender des Verfassungsgerichts der Mongolei,
Verdienter Jurist der Mongolei. 36

“Das gerichtliche Konzept des Verfassungsstaates: Formulierung des Problems im Lichte der Praxis der Verfassungsgerichtsbarkeit in Russland”

Referent: Prof. Dr.jur.habil. N. S. Bondar, Richter des
Verfassungsgerichts der Russischen Föderation, Verdienter
Wissenschaftler der RF, Verdienter Jurist der RF. 46

“Die rechtsschöpferische Eigenschaft der Entscheidungen der Verfassungsgerichtsbarkeit: die Erfahrung des Verfassungsgerichts der Russischen Föderation”

Referent: Dr. V. A. Sivitsky, stellvertretender Vorsitzender des
Sekretariats des Verfassungsgerichts der RF 94

“Etablierung der konstitutionellen Demokratie und Entscheidungsschöpfung durch das Verfassungsgericht, aus den Perspektiven der koreanischen Erfahrung”	
Referent: Han-Chul Park, Richter des Verfassungsgerichts der Republik Korea138
“Erhöhung der rechtlichen Effektivität der Entscheidungen des Verfassungsgerichts”	
Referentin: Prof. Dr. jur.habil. Ts. Sarantuya, Richterin des Verfassungsgerichts der Mongolei, Verdiente Juristin der Mongolei152
“Das Bundesverfassungsgericht als Garant von Rechtsstaatlichkeit und Demokratie in Deutschland”	
Referent: Dr. D. Hömig, Bundesverfassungsrichter a.D.171
“Das Verfassungsgericht und die Demokratie: Zukunft der Türkei”	
Referent: Prof. Dr. Engin Yildirim, Richter des Verfassungsgerichts der Republik Türkei188
“Verfassungsgericht und Politik”	
Referent: Prof. Dr. jur.habil. Ch. Enkhbaatar, Direktor der Verwaltungsschule der Management-Akademie, Berater des Verfassungsgerichts, Verfassungsrichter a.D.195

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ХБНГУ-ын Ханнс- Зайделийн сантай хамтран Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойд зориулж “Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2012 оны 7-р сарын 3-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан билээ.

Эрдэм шинжилгээний бага хуралд БНСУ, ОХУ, БНТУ болон ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, эрдэмтэн судлаачид оролцож үндсэн хуулийн хэрэгжилтийг хамгаалах өөрийн орны туршлагаас хуваалцан илтгэл хэлэлцүүлснээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүд болон үндэсний судлаачид үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудлаар байр сууриа илэрхийлснийг ном болгон хэвлүүлж нийтийн хүртээл болгож байна.

Ханнс-Зайделийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газар

VORWORT

Zu seinem 20. Jahrestag organisierte das Verfassungsgericht der Mongolei am 3. Juli 2012 in Ulaanbaatar in Zusammenarbeit mit der Hanns-Seidel-Stiftung eine internationale wissenschaftliche Konferenz mit dem Titel “Entwicklungsfragen und-tendenzen des Verfassungsstaates”.

An der Konferenz nahmen Richter der Verfassungsgerichte und Wissenschaftler aus der Republik Korea, der Russischen Föderation, der Republik Türkei, der Bundesrepublik Deutschland mit Vorträgen teil und tauschten Erfahrungen aus den eigenen Ländern im Bereich des Verfassungsschutzes aus. Außerdem nahmen die Richter des Verfassungsgerichts der Mongolei und nationalen Wissenschaftler Stellung zu aktuellen Problemen des Verfassungsrechts in der Mongolei. Die Beiträge der Konferenz werden hiermit in einem Sammelband veröffentlicht.

Vertretung der Hanns-Seidel-Stiftung
in der Mongolei

МЭНДЧИЛГЭЭ

*“Үндсэн хуулийн цэцийн
20 жилийн ойд”*

Монгол Улсын Үндсэн хуулийг хамгаалах, чандлан сахиулах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэг гүйцэтгэж буй Үндсэн хуулийн цэцийн гишүүд, ажилтан, албан хаагчид та бүхэнд Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойн чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсад ардчилсан, эрх зүйт төрийг бүрдүүлэх үндэс болсон 1992 оны шинэ Үндсэн хууль нь ардчилсан улс орнуудын адил үндсэн хуулийг хамгаалах, түүний биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий “Үндсэн хуулийн цэц” байгуулахаар зааж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг батлан Цэцийн анхны гишүүдийг томилж байснаас хойш эдүгээ 20 жил болж байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан чиг үүргээ нэр төртэй биелүүлж, ард түмний дунд итгэл хүндэтгэл хүлээсэн байгууллага болсныг тэмдэглэхэд таатай байна.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж, түүний үүрэг хариуцлага улам бүр өсөн нэмэгдсээр байна. Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, хохироосон хууль, аливаа шийдвэр батлахгүй байх нь ардчилсан төрийн үүрэг бөгөөд энэхүү үүргийн хэрэгжилтийг хангахад цэц онцгой үүрэгтэй. Үндсэн хуулийн шүүхэд иргэн бүр хандах эрхтэй байдаг нь Монгол Улсын үндсэн хуульт ёсны давуу тал юм.

Цэцэд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, агуулгын хувьд улам өргөжиж, түүний гаргаж буй шийдвэр нь эрх зүйт төрийн төлөвшилд тодорхой хувь нэмэр болж байна.

Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн нь үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байж Үндсэн хуулийн заалтыг чандлан биелүүлдэг гэдэгт итгэж байна. Бүрэн эрх, хараат бус бие даасан байдал, аливаа маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгаа нь хуулиар хангагдаж, иж бүрэн, оновчтой байвал Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хуулийг хамгаалах үйл хэрэгт ихээхэн ач холбогдолтой болохыг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн байгууллагын үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь хууль дээдлэх ёс хэмээн тунхагласан. Эрх зүйт төрийн оршин тогтнох үндэс болсон энэхүү тулгуур зарчим нийгмийн амьдралын бүх хүрээнд бүрэн утгаараа хэвшин тогтоход хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль дээдлэх манлайлал шийдвэрлэх үүрэгтэй. Эдгээр байгууллагын албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа Монгол Улсын бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, төрийн байгуулал, шүүх эрх мэдэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага зэргийг хамарсан тулгуур зохицуулалт бүхий Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэхэд Үндсэн хуулийн эрх зүйн онолын түвшинг улам өндөр түвшинд хүргэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Шүүх эрх мэдлийн шинэчлэл өрнөж буй энэ чухал үед өнөөгийн хурдацтай хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлагаас үүдэн үйл ажиллагаагаа шинэ шатанд гарган, боловсронгуй болгох шаардлага Үндсэн хуулийн цэцэд шүүхүүдийн нэгэн адил тавигдаж байна.

Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан, цэцийн хяналтад харьяалагдах албан тушаалтны онцлог нь зарим тохиолдолд аль нэг нам, эвслийн талыг барьсан гэх хардлагыг маргааны хоёр талд төрүүлж, зарим улс төрч, иргэдийн бухимдлыг бий болгодог нь нууц биш. Энэ бүхэнд Үндсэн хуулийн цэц голч, зарчимч,

хууль зүйн өндөр түвшинд байж, асуудлыг зөвхөн Үндсэн хуульд захирагдан шийдвэрлэж байх учиртай.

Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль хориод жилийн өмнө батлагдсан байна. Эдгээр хуулийг шүүхийн шинэчлэлийн хүрээнд өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Та бүхний Үндсэн хуулийг сахин хамгаалах хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үйл хэрэгт улам их амжилтыг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ

Улаанбаатар хот
2012 оны 7 дугаар сарын 3

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад Үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлэгч Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүд, ажилтан, албан хаагчид Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн гол ололтуудын нэг бол Үндсэн хуульд дээд хяналтыг тогтоож, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны үндэслэл, зарчмыг тогтоон баталгаажуулсан явдал билээ.

Үндсэн хуулийн цэц өөрийн үүсэл хөгжлийн 20 жилийг ардаа орхин төлөвшиж хөгжихдөө Үндсэн хуульт ёсыг дээдлэн ухамсарлуулах, Үндсэн хуулиар тогтоосон хэм хэмжээг чандлан сахиулж хамгаалах нэн хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үйл хэргийг нийт иргэний хийгээд холбогдох байгууллага, албан тушаалтны өргөн оролцоо, дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурал болон эх орондоо Үндсэн хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх, чандлан сахиулах үүрэгтэй Үндсэн хуулийн цэцийн харилцааг улам төгөлдөржүүлэх, харилцан хүндэтгэлтэй хандах явдал Үндсэн хуульд тавих хяналт амжилттай хэрэгжих үндэс мөн. Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн үндсийг улам боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал анхаарал тавих болно.

Ардчиллын үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад Үндсэн хуулийн цэцийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Монгол төрийн тогтолцоонд засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч үндсэн байгууллагуудын тэнцвэртэй байдлыг хангах, тэдний үндсэн хуулийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зэрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага бий.

Үндсэн хуулийн цэцийн цаашдын үйл ажиллагаа Монгол Улсад Үндсэн хуульт ёс бэхжиж, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ёс зүйтэй, хууль дээдэлдэг төр төлөвшин хөгжих үйл хэрэгт урьдын адил үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАМДИНГИЙН ДЭМБЭРЭЛ

Улаанбаатар хот
2012 оны 7 дугаар сарын 2

МЭНДЧИЛГЭЭ

I. Оршил

Үндсэн хуулийн цэцийн эрхэм дарга аа,
ОХУ, Солонгос, Турк улсын эрхэм төлөөлөгчид өө,
бага хурлын эрхэм оролцогчид оо,

та бүхний өмнө Ханнс-Зайделийн санг төлөөлж мэндчилгээ дэвшүүлэх завшаан тохиож байгаа нь миний хувьд нэр төрийн хэрэг юм.

Монгол, Германы харилцаа урт удаан жилийн түүхтэй билээ. Сүүлийн жилүүдэд хоёр орны харилцаа зөвхөн улс төрийн салбарт төдийгүй эдийн засаг, соёлын салбарт өргөжин тэлсээр байна. Улс төрийн харилцаа өргөжин тэлж буйн баталгаа нь өнгөрөгч онд ХБНГУ-ын канцлер Ангела Меркелийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлал, миний өмнө мэндчилгээ дэвшүүлсэн эрхэмсэг ноён ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн энэ оны 3-р сард ХБНГУ-д хийсэн айлчлал юм. Монгол Улс бол ХБНГУ-ын чухал түнш орон билээ.

Ялангуяа эрх зүй, шүүх эрх мэдлийн чиглэлд олон жилийн турш үр дүнтэй, тогтвортой хамтын ажиллагаа хөгжсөөр ирсэн.

II. Үндсэн хэсэг

2.1 Ханнс-Зайделийн сангийн Монголтой явуулж буй хамтын ажиллагаа

Ханнс-Зайделийн сан эрх зүйт төрийн хөгжлийг дэмжих, ардчилсан тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Монгол Улстай 1995 оноос хойш тасралтгүй хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны зорилго нь шилжилтийн үедээ байгаа Монгол Улсыг орчин үеийн ардчилсан эрх зүйт төртэй, захиргааны оновчтой тогтолцоотой улс болход нь дэмжлэг үзүүлэх явдал юм. Уг ажлыг сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх,

шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжих гэх мэт арга механизмаар хэрэгжүүлж байна. Төслийн үндсэн чиглэл нь нийтийн болон эрүүгийн эрх зүй болно.

Төслийн хүрээнд эрдэмтэд, хуульчидтай эрх зүйн чиглэлээр санал солилцох, хуульч, захиргааны ажилтнууд, шүүгчдэд зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, эрх зүй, захиргааны чиглэлээр харьцуулсан судалгаа явуулах гэх мэт арга хэмжээг зохион байгуулж байна. Телевиз, радио, сонин сэтгүүлээр дамжуулан хуулийн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ өмгөөлөгчийн тусламжтайгаар иргэдэд үнэгүй эрх зүйн зөвлөгөө өгөх замаар эрх зүй, захиргааны чиглэлээр иргэдийн ухамсрыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна. Нийгэмд хөлөө олоход нь туслах зорилгоор хорих ангид ял эдэлж буй насанд хүрээгүй иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, мэргэжил олгох сургалтууд зохион байгуулж байна. 2009 оноос Захиргааны хариуцлагын тухай хуулийг боловсронгуй болгох, нийтийн эрх зүйн чиглэлээр хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар Бавари муж улсын Засгийн газартай тогтвортой хамтын ажиллагааг эхлүүлсэн. 2001 онд тус сангийн үүсгэн байгуулсан "Эрх зүйн боловсрол" академи Улаанбаатар хотод болон хөдөө орон нутагт хуульчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг тасралтгүй явуулсаар байна.

2.2 Холбооны Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол

1990-ээд онд Монгол Улсад улс төрийн эргэлт гарч 1992 онд шинэ ардчилсан үндсэн хуулиа батлан ардчилал, эрх мэдлийн хуваарилалт, хүний үндсэн эрхийг дээдлэх зарчмыг үндэс сууриа болгосон орчин үеийн үндсэн хуульт ёс бүхий дэлхийн улсуудын эгнээнд шилжиж үндсэн хуульт төрийн титэм нь болсон үндсэн хуулийн шүүхийг байгуулсан билээ. Энэ алхмыг хийснээр Монгол Улс дэлхийн дэвшилтэт улсуудтай мөр зэрэгцэх болсон боловч 1989/1990-ээд онд улс төрийн өөрчлөлт

шинэчлэлт хийсэн хуучин социалист орнуудын үндсэн хуулийн шүүхийн талаарх үзэл санаа нэлээд хэлбэлзэлтэй байсан нь Монголд ч нөлөөлсөн.

Эрх зүйт төр дэхь Үндсэн хуулийн шүүхийн ач холбогдлыг үнэлж баршгүй. ХБНГУ өнөөдөр маш нэр нөлөөтэй Үндсэн хуулийн шүүхтэй бөгөөд тэрээр өөрийн статусын төлөө урт удаан хугацаанд тэмцэж байж энэ түвшинд хүрсэн юм. Төрөөс гаргаж буй хуульчилсан актуудын үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа улс төрийн орон зайд ихээхэн нөлөө үзүүлдэг. Энэ нь зарим тохиолдолд мэдрэгдэхүйц ажиглагддаг. Тухайлбал улс төрийн эрх мэдэлтнүүдэд зорилгодоо хүрэх замд нь саад учруулж байгаагаар мэдрэгддэг тул тэдэнд тэр бүр таатай санагддаггүй. Эрх мэдэлд эрх олгох бус харин эрхийг эрх мэдэлтэй болгох зарчимтай төрийн хувьд бие даасан хараат бус шүүгчид л эрх мэдлийн хэрэгжилтэнд хяналт тавьж чадна. Улс төрийнхөн Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг тэсвэрлэх ёстой. Учир нь энэхүү хяналт Үндсэн хуулийн хэм хэмжээний дагуу тавигдаж буй хяналт юм. Үндсэн хуулийн шүүх өөрийн улс төртэй байж болохгүй. Харин уг шүүх нь төрийн эрх мэдэл Үндсэн хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа эсэхийг, өөрөөр хэлбэл иргэдийн эрх, эрх чөлөө хамгаалагдаж байгаа эсэхийг хянадаг¹.

Холбооны ҮХШ-ийн дарга асан профессор, доктор Ханс-Юрген Папир-ийн үгнээс иш татмаар байна. Тэрээр: „Орчин үеийн үндсэн хуульт төр нь эдгээр хамгаалалтын механизмуудын давшингуй хөгжил дээр суурилдаг. Энэ нь мөн төрийн эрх мэдэл өөрийнх нь эрхэнд халдахаас хамгаалуулах хувь хүний хэрэгцээ, өөрөөр хэлбэл хүний болон иргэний эрх чөлөөнд төр халдахаас, төрийн хамгаалалтын эрх мэдэл нь дарангуйлалын эрх мэдэл болж хувирахаас хамгаалах баталгаа болох тухай асуулдал юм²“ гэсэн.

¹ 2.2-д дурдсан санаануудыг Бавари муж улсын Захиргааны сургуулийн дарга асан, доктор Юрген Харбихаас авсан болно.

² Папир, Ханс-Юрген: “Төрөөс эрх чөлөө, аюулгүй байдлыг тэнцвэртэйгээр хангах нь”, Die Welt сэтгүүлийн 2008 оны 6-р сарын 1-ний дугаар. <http://www.welt.de/politik/article2055921/Wie-der-Staat-Freiheit-und-Sicherheit-vereint.html>

Өнөө үед германы ард түмний эрх зүйн ухамсар, итгэл үнэмшил ихээхэн дээшилсэн. Холбооны Үндсэн хуулийн шүүх нь ард иргэдийн дунд хамгийн их нэр хүндтэй шүүх. Иргэд төрийн бусад байгууллагад итгэхээс илүү тус шүүхэд итгэдэг нь тэдний үндсэн эрхийг төрийн байгууллагууд зөрчихөөс хамгаалах цорын ганц баталгаа болдогтой нь холбоотой.³

„Би Карлсруе хүртэл явна шүү“ гэдэг хэлц үг ч бий болсон. Иргэн бүрт Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандаж түүгээр дамжуулан үндсэн эрхээ хамгаалуулах эрх нь нээлттэй байдаг.⁴

III. Хамтын ажиллагааны цаашдын төлөв ба талархал

Үндсэн хуулийн шүүхийн ач холбогдол нэн өндөрт тавигддаг тул Ханнс-Зайделийн сангийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцтэй хамтран ажиллаж тус шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь маш эрхэм хүндтэй үүрэг хариуцлага билээ.

Хамтын ажиллагааны эхний жилүүдэд яриа хэлэлцээ өрнүүлэх, олон улсын бага хурал зохион байгуулах, ном хэвлэл нийтлүүлэх зэргээр Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг дэмжиж байв. Өнөөдрийн өндөрлөгөөс эргэн харахад урт удаан хугацаанд ихээхэн амжилттай хамтран ажиллаж иржээ.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц болон ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн хооронд олон тооны харилцан айлчлал зохион байгуулсан. Үе үеийн Үндсэн хуулийн цэцийн дарга нар болох доктор профессор Г.Совд, доктор профессор Н.Жанцан, доктор профессор Ж.Бямбадорж нар ХБНГУ-д айлчилж тухайн үед Холбооны Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгч

³ Пётцш, Хорст: ХБНГУ дахь ардчилал. 4 дахь хэвлэл., Бонн: ХБНГУ-ын Улс төрийн боловсролын төв, 2005, Х. 15-119

⁴ Мацанке, Корнелиа: “Карлсруэ дахь Холбооны Үндсэн хуулийн шүүх 60 насныхаа ойг тэмдэглэж байна”. <http://suite101.de/article/das-bundesverfassungsgericht-in-karlsruhe-feiert-60-geburtstag-a124016>

байсан доктор, профессор Ютта Лимбах, доктор профессор Ханс-Юрген Папир нартай санал солилцож байсан бол Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид ч Монгол Улсад айлчилж байсан. Үүнд жишээ нь ноён профессор, доктор Рудольф Меллингхоф, доктор Ханс-Иоахим Иенч нарын айлчлалыг дурдаж болно. Эдгээр харилцан айлчлалууд Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжилд бага ч атугай хувь нэмэр оруулсан байх гэж найдаж байна. Мөн Москва дахь Ханнс-Зайделийн сангийн төлөөлөгчийн газраас 2009 онд хэвлүүлсэн „Эрх зүйт төр ба төрийн бүтэц зохион байгуулалт“ нэртэй эмхэтгэлд профессор доктор Ханс-Юрген Папирийн бүтээл орсон бөгөөд хамтран зохиогчоор оролцсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг герман хэлэнд дахин шинээр хөрвүүлж байна. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль германы хуульчдад хүртээмжтэй болох юм.

Ирэх жилүүдэд Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын ахлах зөвлөх болон шинжээч нарт зориулсан сургалтыг ХБНГУ-д болон Монголд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэ дашрамд манай сангийн Монголын төсөлд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж он удаан жил хамтран ажиллаж буй германы нэртэй эрдэмтэн профессор доктор Хайнрих Шоллер, доктор Юрген Харбих, эрүүгийн эрх зүйн чиглэлд хамтран ажиллаж байгаа профессор доктор Бернд Шюнеман нарт гүнээ талархаж буйгаа илэрхийлье. Мөн төслийг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө эцэж цуцалтгүй, тогтвортой ажиллаж буй профессор, доктор Ц.Сарантуяад талархаж байна. Түүний хичээл зүтгэлгүйгээр манай хамтын ажиллагаа амжилттай бөгөөд тасралтгүй явагдахгүй байлаа.

Монгол Улсад ардчилсан хувьсгал гарснаас хойш эрх зүйн тогтолцоог шинэчлэхэд Монгол Улстай хамтран ажилласан анхны түншүүдийн нэг нь Ханнс-Зайделийн

сан билээ. Тус сан энэ замыг амжилттай туулахад нь цаашдаа ч Монгол улсыг үнэнчээр даган дэмжсээр байх болно. Хэрэв Монгол Улс энэхүү хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийг хүсвэл, уг хамтын ажиллагаа хэрэгцээтэй гэж үзсээр байсан нөхцөлд Ханнс-Зайделийн сан эрх зүйн шинэчлэлтийг явуулахад өөрийн чадлын хэрээр дэмжлэг үзүүлж ажиллах болно.

Энэ дашрамд тус сангийн тэргүүн профессор, доктор Ханс Цэетмайерийн халуун мэндийг уламжлая. Тэрээр өнгөрсөн оны 10-р сард тус улсад айлчилсан болно. Мөн тус сангийн ерөнхий захирал Др. Петр Виттерауф, Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Кристиан Хегемер, Зүүн хойд Азийн хэлтсийн дарга Вилли Ланге болон дээр нэр дурдсан германы нэрт эрдэмтэд, судлаачдын халуун мэндийг уламжилж байна.

Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойг тэмдэглэхээр дэлхийн бусад орноос ч зочид төлөөлөгчид ирээд байна. Ирээдүйн зорилгынхоо төлөө хамт алхацгаая. Ханнс-Зайделийн сангийн нэрийн өмнөөс Монгол Улс, тус улсын Үндсэн хуулийн цэцэд өнөөдрийг хүртэл итгэл төгс хамтран ажиллаж ирсэнд гүнээ талархаж ирэх арвануудад амжилттай ажиллахыг хүсэн ерөөе.

Анхаарал хандуулсанд баярлалаа!

ХБНГУ-ЫН ХАННС-ЗАЙДЕЛИЙН
САНГИЙН ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХЭЛТСИЙН
МОНГОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨЛӨӨЛӨГЧ
АЛЕКСАНДР БИРЛЕ

BEGRÜßUNG

Sehr geehrter Herr Verfassungsgerichtspräsident, sehr geehrte Gäste aus der Russischen Föderation, Korea und der Türkei, sehr geehrte Anwesende, es ist mir eine große Freude und Ehre, heute als Vertreter der Hanns-Seidel-Stiftung zu Ihnen sprechen zu können.

Zwischen der Mongolei und Deutschland werden seit Langem sehr gute Beziehungen gepflegt. In letzter Zeit erfolgte nicht nur eine Intensivierung der Beziehungen auf politischem Gebiet, unterstrichen durch die Besuche von Bundeskanzlerin Angela Merkel im letzten Jahr in der Mongolei und durch den Staatsbesuch von Staatspräsident Elbegdorj, im März dieses Jahres in Deutschland. Auch die wirtschaftliche und kulturelle Zusammenarbeit gedeiht, die Mongolei ist ein wichtiges Partnerland Deutschlands.

Insbesondere auf dem Gebiet des Rechts und der Justiz wird seit vielen Jahren eine sehr gute und nachhaltige Zusammenarbeit gepflegt.

II. Hauptteil

2.1 Die Zusammenarbeit der HSS mit der Mongolei

Die Hanns-Seidel-Stiftung begleitet dabei die Mongolei seit 1993 bei der Entwicklung von Rechtsstaatlichkeit und dem Aufbau demokratischer Strukturen. Ziel der Zusammenarbeit ist die Unterstützung der Mongolei bei der Transformation zu einem modernen demokratischen Rechtsstaat und beim Aufbau eines qualifizierten und effizienten Verwaltungssystems. Dies erfolgt durch Beratung, Bildungsmaßnahmen und die Bereitstellung einer notwendigen ergänzenden Ausstattung. Schwerpunkt des Projektes ist der Bereich Öffentliches Recht und Strafrecht.

Als Maßnahmen dienen hier unter anderem der Meinungsaustausch mit Wissenschaftlern und Juristen im Rechtsbereich, Fortbildungskurse für Juristen, Beamte und Richter sowie vergleichende Forschung in unterschiedlichen

Rechts- und Verwaltungsbereichen. Über fachbezogene, öffentlichkeitswirksame Rechtsberatungen im TV, Radio, den Printmedien und kostenlosen Beratungen für Bürger soll das öffentliche Bewusstsein für die Bereiche Recht und Verwaltung gestärkt werden. Für straffällig gewordene Jugendliche werden Rechtsveranstaltungen und Berufs begleitende Maßnahmen zur besseren Reintegration angeboten. 2009 wurde in Zusammenarbeit mit der Bayerischen Staatsregierung die nachhaltige Unterstützung im Bereich des Ordnungswidrigkeitengesetzes und der Rechtsbereinigung im Bereich Öffentliches Recht begonnen. Mittels der 2001 durch die Hanns-Seidel-Stiftung gegründeten Akademie „Rechtsbildung“ werden kontinuierlich Fortbildungsveranstaltungen in Ulaanbaatar und in den Provinzen durchgeführt.

2.2 Die Bedeutung des Bundesverfassungsgerichts in einem Rechtsstaat

Mit dem politischen Umbruch 1990 und der Verfassung von 1992, in der sich die Mongolei zu Demokratie, Gewaltenteilung und Grundrechten bekennt, hat sich die Mongolei in die Gruppe der modernen Verfassungsstaaten eingereiht und als Krönung der verfassungsstaatlichen Entwicklung das in der Verfassung vorgesehene Verfassungsgericht errichtet. Die Mongolei befindet sich damit in guter Gesellschaft, erlebte doch die Idee der Verfassungsgerichtsbarkeit in den ehemals sozialistischen Ländern nach dem politischen Umbruch 1989/1990 eine weithin sichtbare Konjunktur.

Die Bedeutung des Verfassungsgerichts in einem Rechtsstaat kann gar nicht hoch genug eingeschätzt werden. Deutschland hat mittlerweile ein enorm starkes Bundesverfassungsgericht, das aber auch sehr lange um seinen Status kämpfen musste. Ein Verfassungsgericht, das staatliche Hoheitsakte, also auch Gesetzgebungsakte des Parlaments, am Maßstab der Verfassung überprüft, wirkt mit seinen Entscheidungen - manches Mal sehr spürbar - in den politischen Raum hinein. Das geschieht nicht immer zur Freude der hohen Politik, die sich in der Verfolgung

ihrer Ziele durch die verfassungsgerichtliche Kontrolle gehemmt sieht. Ein Staat, in dem nicht das Recht der Macht, sondern die Macht des Rechts gelten soll, verlangt, dass unabhängige Richter die Machtausübung kontrollieren. Die Politik muss diese Kontrolle ertragen. Denn die Kontrolle ist nur eine Kontrolle am Maßstab des Rechts, des Verfassungsrechts. Dem Verfassungsgericht ist es verwehrt, eigene Politik zu betreiben. Das Gericht soll aber die Gewähr bieten, dass staatliche Macht in den Grenzen der Verfassung, also des Rechts, ausgeübt und damit die Freiheit des Bürgers geschützt wird.¹

Lassen Sie mich hierzu den vormaligen Präsidenten des Bundesverfassungsgerichts, Prof. Dr. Dr. h. c. Hans-Jürgen Papier, zitieren:

„Der moderne Verfassungsstaat beruht auf einer eindrucksvollen Fortentwicklung dieser Sicherungszwecke des Staates. Es geht nunmehr auch um das Bedürfnis des Einzelnen nach Sicherheit gegenüber staatlichen Eingriffen, also um die Gewährleistung der Menschen- und Bürgerrechte als Freiheitsrechte gegen den Staat, der von der staatlichen Schutzmacht zur Unterdrückungsmacht zu werden drohte.“²

Wir Deutschen verfügen mittlerweile über ein sehr ausgeprägtes öffentliches Rechtsbewusstsein bzw. Rechtsüberzeugung. Das Bundesverfassungsgericht ist das Staatsorgan mit dem größten Ansehen unter der Bevölkerung. Die Bürger bringen dem Gericht mehr Vertrauen entgegen als den meisten anderen staatlichen Institutionen, da sie sich des Bundesverfassungsgerichts als Garant für die Durchsetzung der Grundrechte des Einzelnen gegenüber dem Staat bewusst sind.³

„Ich gehe bis nach Karlsruhe“ ist mittlerweile zum geflügelten Wort geworden. Jeder Bürger hat das Recht, das Bundesverfassungsgericht mit Sitz in Karlsruhe anzurufen und

¹ Anregungen zu den Ausführungen unter 2.2 erhielt ich von Dr. h. c. Jürgen Harbich, Vorstand der Bayerischen Verwaltungsschule a.D.

² Papier, Hans-Jürgen: „Wie der Staat Freiheit und Sicherheit vereint“. In: Die Welt. 1. Juni 2008. <http://www.welt.de/politik/article2055921/Wie-der-Staat-Freiheit-und-Sicherheit-vereint.html>

³ Pöttsch, Horst: Die deutsche Demokratie. 4. aktualisierte Aufl., Bonn: Bundeszentrale für politische Bildung 2005, S. 15-119.

seine Grundrechte durch das Bundesverfassungsgericht sichern zu lassen.⁴

III. Ausblick auf die weitere Zusammenarbeit und Danksagung

Wegen der hohen Bedeutung der Verfassungsgerichtsbarkeit sieht es die Hanns-Seidel-Stiftung als ehrenvolle Aufgabe an, mit dem Verfassungsgericht der Mongolei zusammenzuarbeiten und die Arbeit dieses Gerichts zu unterstützen.

Die Zusammenarbeit mit dem Verfassungsgericht bestand in den ersten Jahren darin, Gespräche zu führen und internationale Konferenzen zu veranstalten und über Vorträge und Publikationen die Verfassungsgerichtsbarkeit zu stärken. Mittlerweile können wir auf eine langjährige und erfolgreiche Zusammenarbeit im Bereich des Verfassungsrechts zurückblicken.

In den vergangenen Jahren konnten zahlreiche Begegnungen des mongolischen Verfassungsgerichts mit dem Bundesverfassungsgericht realisiert werden. Sowohl Delegationsbesuche im Bundesverfassungsgericht wie etwa der Meinungsaustausch der ehemaligen Präsidenten des Verfassungsgerichts der Mongolei, Prof. Dr. Sovd, Prof. Dr. Jantsan und Prof. Dr. Byambadorj, mit der Präsidentin bzw. dem Präsidenten des Bundesverfassungsgerichts, Prof. Dr. Jutta Limbach und Prof. Dr. Dr. h. c. Hans-Jürgen Papier, als auch Fachaufenthalte von Bundesverfassungsrichtern in der Mongolei, beispielsweise von Prof. Dr. h. c. Rudolf Mellinghoff und Dr. Hans-Joachim Jentsch, lieferten wichtige Impulse für die Anwendung und weitere Entwicklung des mongolischen Verfassungsrechts. Es gibt aber auch die Form der Fachveröffentlichungen, bei der sich 2009 als Mitautor an einem von der Hanns-Seidel-Stiftung in Moskau veröffentlichten Sammelband zum Thema „Rechtsstaat und Staatsaufbau“ u.a. Prof. Dr. Dr. h. c. Hans-Jürgen Papier mit einem Fachaufsatz beteiligte.

⁴ Matzanke, Kornelia: „Das Bundesverfassungsgericht in Karlsruhe feiert 60. Geburtstag“. <http://suite101.de/article/das-bundesverfassungsgericht-in-karlsruhe-feiert-60-geburtstag-a124016>

Anlässlich des 20-jährigen Bestehens der mongolischen Verfassungsgerichtsbarkeit ist derzeit eine Neuübersetzung der mongolischen Verfassung und Veröffentlichung in deutscher Sprache in Arbeit, um die Verfassung der Mongolei einem größeren Kreis deutscher Juristen zugänglich zu machen.

In den kommenden Jahren sind gemeinsam organisierte Bildungsveranstaltungen für die leitenden Berater und Gutachter der Kanzlei des Verfassungsgerichts in Deutschland und der Mongolei geplant.

An dieser Stelle möchte ich stellvertretend für unsere im Projekt Mongolei tätigen Experten Prof. Dr. Jur. Dr. h. c. Heinrich Scholler und Dr. h. c. Jürgen Harbich sowie für den Bereich Strafrecht Prof. Dr. iur. habil. Dr. h. c. Bernd Schünemann besonders hervorheben und für Ihre langjährige Mitwirkung danken. Weiterhin gebührt mein Dank unserer Projektleiterin Frau Prof. Dr. Tserenbaltav Sarantuya, ohne deren unermüdlichen Engagement und deren Standhaftigkeit diese erfolgreiche und kontinuierliche Partnerschaft wohl nicht möglich gewesen wäre.

Die Hanns-Seidel-Stiftung war einer der ersten Partner der Mongolei bei der Reform des Rechtssystems nach der Wende und wird die Mongolei auch weiterhin auf ihrem Weg begleiten. Solange es von der Mongolei gewünscht und von Nutzen ist, wird die Hanns-Seidel-Stiftung Ihr Land von Kräften bei ihren Reformbemühungen unterstützen.

Ich darf Ihnen an dieser Stelle auch die besten Glückwünsche unseres Vorsitzenden, Prof. Dr. h. c. mult. Hans Zehetmair, der ihr Land im Oktober letzten Jahres besuchte, unseres Hauptgeschäftsführers, Dr. Peter Witterauf, des Leiters der Abteilung für Internationale Zusammenarbeit, Christian J. Hegemer, sowie des Leiters des Referats Nordostasien, Willi Lange, übermitteln, ebenso die Grüße unserer bereits erwähnten deutschen Rechtsexperten.

Wir sind heute aus unterschiedlichen Ländern hier zusammen gekommen, um das 20-jährige Bestehen der mongolischen Verfassungsgerichtsbarkeit zu begehen. Lassen Sie uns die zukünftigen Aufgaben gemeinsam angehen. Im

Namen der Hanns-Seidel-Stiftung danke ich der Mongolei und dem Verfassungsgericht sehr herzlich für die vertrauensvolle Zusammenarbeit in all diesen Jahren und wünsche Ihnen auch in den nächsten Jahrzehnten viel Erfolg.

Vielen Dank für Ihre Aufmerksamkeit!

A. Birlе, Vertreter der Hanns-Seidel-Stiftung e.V.,
München, Referat Nordostasien

*Доктор, профессор Н. Жанцан,
Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга,
Монгол Улсын Гавьяат хуульч*

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БА ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ТӨЛӨВШИЛ

Эрхэм хүндэт Хатагтай, ноёд оо

Хүндэт зочид оо.

Юуны өмнө Та бүхэнд Монгол Улсад Үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойн халуун дотно мэндчилгээг дэвшүүлж байгааг минь хүлээн авна уу.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн нэг түүхэн гавьяа бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон Үндсэн хуулийн цэц буюу Үндсэн хуулийн шүүхийг бий болгож түүний бүрэн эрхийг хуульчлан тогтоосон явдал мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх хий хоосон орон зай дээр үүсээгүй. Юуны өмнө Үндэсний болон хүн төрөлхтний эрх зүйн соёлын ололтод тулгуурлаж үүссэн гэж үзэж болно. Үндсэн хуульт ёсны олон жилийн түүхтэй дэлхийн олон оронд Үндсэн хуулийн шүүх байгуулагдан ажиллаж ирсэн бөгөөд ялангуяа Үндсэн хуулийн шүүх байгуулагдах их шуурга Европын орнуудыг хамарсан түүхэн цаг үед манай Үндсэн хууль боловсрогдсон явдал төрийн энэ чухал институтын хүлээн зөвшөөрөгдөх нэг үндэс болсон байх магадлалтай.

Дэлхий дахинд Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан өнгөрсөн үеийн түүх бол энэ институтын зайлшгүй хэрэгцээтэй болохыг батлан харуулсан түүх юм. Үндсэн хуулийн шүүхийг өөр бусад ямар нэг байгууллагаар төлөөлүүлж болохгүй учраас дэлхийн ихэнх оронд түүний бүрэн эрх адил төстэй хуульчлагдсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх бол ардчиллын бүтээл болохын хувьд түүнийг манай оронд явагдсан

ардчилсан реформтой нас чацуу гэж хэлж болно. Хүн төрөлхтний хөгжилд даяаршил зарим бодит үр нөлөө үзүүлдэгийн нэг жишээ бол Үндсэн хуульт ёсонд хандах хандлага, хууль дээдлэх соёлыг түгээх эрхэм зорилго хэрэгжих үүднээс Үндсэн хуулийн хяналт дэлхий даяар хаяагаа тэлж буйд оршино. Үүнийг Үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн шүүхээр жишиг болгон тайлбарлаж болох юм.

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хууль хэрэгжих баталгаа болж буй агуулгаараа Монголын төрийн дархлааны суурь үндэс болдог.

Нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулиар баталгаажсан монгол төрийн байгууламж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн бүх үнэт зүйлийг хамгаалах, монгол нутаг даяар Үндсэн хуулиа дээдлэх боломжийг бий болгох эрхэм зорилго бүхий субъектийн хувьд монгол төрийн дархлаа болдог гэж хэлж болно.

Дэлхий дахинд Үндсэн хуулийн хяналтын шинэ эрин эхэлж байна. Үүнийг дэлхийн ихэнх орны Үндсэн хуулийн шүүх 30 хүрэхгүй настай байгаатай холбон тайлбарлаж болох юм. Европын ардчиллын стандартад Үндсэн хуулийн шүүхийн роль маш өндөрт тавигдаж байгаа бөгөөд эдүүгээ Европын ихэнх орны төрийн тогтолцоонд хүчтэй Үндсэн хуулийн шүүх хүндтэй бөгөөд чухал байр суурь эзэлж байна.

Гэхдээ Ази, Европын орнуудын Үндсэн хуулийн шүүхийн хувь заяа тэр бүр дардан замаар яваагүй. Хүчтэй ерөнхийлөгчийн засаглалын үед эрх мэдэл дарангуйлалын шинжийг агуулсан нөхцөлд Үндсэн хуулийн хяналт хэрэгжих боломжоо алддаг тохиолдлууд гардаг байна. Тухайлбал Казахстан Улсад Европын орнуудын жишгээр анх байгуулагдсан Үндсэн хуулийн шүүх хүчин чадал, эрх мэдлийн хувьд илтэд буурч Үндсэн хуулийн зөвлөл болон хувирсан бол Киргиз Улсын Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл хуваарилалтын зөрчилдөөний улмаас бүрэн хэмжээгээр татан буугдсан байна. Түүхэн

тодорхой нөхцөлд ардчиллаас ухарсан ухралт засагдах нь үнэн боловч түүний хор уршгийг эцэст нь ард түмэн амсдаг болохоор илэрхий алдаанаас сургамж авах нь чухал байдаг.

Үндсэн хуульт ёсны төлөвшлийн асуудал тодорхой цаг хугацаа шаардах амаргүй төвөгтэй асуудал боловч Монгол Улсын тухайд энэ асуудал тийм ч шинэ тулгамдуу зүйл биш гэж үзэх үндэстэй. Монгол төрийн олон мянган жилийн түүх, эзэнт гүрэн Чингис хааны үеэс улбаатай бичмэл хуулиуд, үе үеийн дагаж мөрдөж ирсэн Үндсэн хуулиуд тэдгээрийг дээдлэн биелүүлж ирсэн уламжлалт эрх зүйн соёл үүнийг гэрчлэх юм.

Гэхдээ 1992 онд батлагдсан Үндсэн хууль Монголын нийгэм, төрийн байгуулалтад онцгой шинэчлэл хийсэн учраас нийгмийн эрх зүйн ухамсар, Үндсэн хуульт ёсны төлөвшилд шинэ хандлага бий болсон гэж үзэх нь онол арга зүйн хувьд илүү зохимжтой бөгөөд Үндсэн хуульт ёсны төлөвшилд төрийн зүгээс тусгайлан анхаарах шаардлагыг бий болгож байгаа юм.

Дэлхий дахинаа Үндсэн хуульт ёсны төлөвшилд Үндсэн хуулийн шүүхийн роль нэн өндөрт тавигдаж байгаа бөгөөд нэг талаас төрийн эрх барих байгууллага, эрх мэдэлтнүүдийн хууль дээдлэх ёсны хэмжүүр гэж үзэх талтай.

Үндсэн хуулийн шүүх ялангуяа түүний шийдвэр эрх баригч бүхэнд таалагдах нь тийм ч элбэг биш боловч ардчиллын тулгуур эрх ашгийг хамгаалагч хэн бүхний эрх ашигт нийцэж байгаад түүний мөн чанар оршиж байгаа юм.

Үндсэн хууль бол эрх зүйн дээд хүчин чадалтай акт төдийгүй улс төрийн чиг баримжааг тодорхойлсон баримт бичиг. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий Үндсэн хуулийн шүүх бол улс төрөөс хараат бус ажиллах ёстой болохоос улс төрд хамааралгүй байгууллага биш. Яагаад гэвэл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр бол улс төрийн

хүрээнд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг эрх зүйн акт юм. Тухайлбал, Үндсэн хуулийн шүүх улс төрийн намуудын зөвшилцлийн үндсэн дээр батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн тодорхой заалтуудыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн утгаар нь хүчингүй болгож байна. Улс төрд үүнээс хүчтэй нөлөө үзүүлэх байгууллага өнөөгийн засаглалын төвшинд байхгүй. Үндсэн хуулийн шүүх улс төрийн намуудаас ялгаатай нь Үндсэн хуулийг улс төрийн нүдээр биш мэргэжлийн өндөр төвшинд хуулийн нүдээр харж, тайлбарладагт орших юм. Улс төрчид өөрсдийн санаанд үл нийцсэн шийдвэрээ хамгаалахын тулд Үндсэн хуулийн шүүх буруу шийдвэр гаргалаа, захиалга биелүүлж байна гэх мэтээр довтолох явдал цөөнгүй тохиолдох боловч энэ нь Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээний хүрээнд анхаарлаа хандуулаад байх хэмжээний сэдэв болж чаддаггүй билээ.

Үндсэн хуулийн зөрчил нь хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоогчдын зүгээс санаатай, санамсар болгоомжгүй, Үндсэн хуулийг ойлгох ойлголтын зөрүүгээс зэрэг олон шалтгаантай боловч түүний эцсийн үр дүн нь Үндсэн хуулийн зөрчил байдаг болохоор алдааг нь зайлшгүй засагдах нөхцөлийг баталгаажуулах нь ардчиллын төгс шинж болдог.

Түүнчлэн парламентын засаглалтай орнуудад ч хэмжээгүй эрх мэдэл хүсэх, хяналтаас ангид байх, Үндсэн хуулиас давсан эрх мэдэл авах хүсэл эрмэлзэл шийдвэр гаргагчдын төвшинд байсаар байдаг нь нууц биш юм.

Үндсэн хуулийн хяналт яригдах бүр төрийн эрх мэдэл хуваарилал байнга хөндөгддөг нь санамсаргүй зүйл огт биш. Эрх мэдэл хуваарилалтын эх сурвалж нь аль ч оронд Үндсэн хууль байдаг. Гэтэл Үндсэн хуулиар олгосон эрх мэдлийг өргөтгөх эсхүл бусдын эрх мэдлээс танах, хүрээ хэмжээнээс халих аль аль нь Үндсэн хуулийн хяналтанд өртөх учиртай. Хэрвээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдийг анхааралтай судалбал Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдэл

хуваарилалтын хүрээнээс хальсан, эрх мэдэл нэмж авсан цөөнгүй шийдвэр хүчингүй болсоныг олж харж болно. Үүнийг Монгол Улсад Үндсэн хуулийн хяналт бодитой хэрэгжиж буйн нотолгоо гэж үзэж болно.

Үндсэн хуулийн цэцийн харъяалан шийдвэрлэх хэрэг, маргааны талаар цэгцтэй зөв ойлголт олон түмний дунд эхэн үедээ байсангүй. Үндсэн хуулийн цэц ажиллаж ирсэн өнгөрсөн хугацаанд Цэцийн талаарх ойлголт мэдлэгийн хүрээ илтэд сайжирч, хүрээгээ тэлж Цэцэд хандаж гаргах өргөдөл маргааны тоо ч жилээс жилд өссөөр байна. Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн аливаа өргөдөл, гомдол, хүсэлтийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс гаргаж байгаа бүх шийдвэрүүд Үндсэн хуульт ёсны төлөвшилд бодитой нөлөөгөө үзүүлсээр байна. Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байгаа шийдвэр төдийгүй, Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэж үзсэн шийдвэр ч нийгмийн танин мэдэхүүд төдийгүй хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд өндөр ач холбогдол үзүүлж байна гэж хэлж болно. Энэ утгаар нь авч үзвэл Үндсэн хуулийн цэц нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс гаргаж байгаа шийдвэрийг хянахын зэрэгцээ нөгөө талаас тэдний шийдвэрт Үндсэн хуулийн нэрийн өмнөөс тайлбар өгч байгаа явдал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийг аливаа нөлөөнд автагдахгүй гагцхүү Үндсэн хуульд хатуу чанд захирагдан хамгаалж байх тийм хариуцлагатай эрхэм үүрэг гагцхүү Үндсэн хуулийн цэцэд л оногдсон юм. Үндсэн хуулийн цэц энэ үүргээ нэр төртэй биелүүлж чадах аваас Монголын төр, нийгмийн тогтолцоог тогтвортой байлгах, Монгол оронд Үндсэн хуулиар нэгэнт тогтсон ардчилсан тогтолцоог хамгаалах эрхэм үүргээ биелүүлж байгаа нь тэр билээ.

Үндсэн хуулийн аливаа заалт эрх зүйн үүднээс хоёрдмол биш нэг л агуулгатай байдаг гэсэн утгаараа шүүх засаглал нэгдмэл байж, аливаа хэрэг, маргааныг нэг байр суурь, нэг зарчмаар шүүж байх ёстой. Энэ ч

утгаараа Монгол улсын Үндсэн хуулийн шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ аль нэг нам, эвсэл улс төрийн хүчин төрийн эрхэд байгаагаас үл хамааран Үндсэн хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ дагуу асуудлыг шийдвэрлэж ирсэн.

Үндсэн хуулийн цэц хараат бусаар ажиллах бүхий л боломжийг бий болгох түүнд улс төр, эдийн засгийн ямар ч дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрнээ хангах явдал нь Үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэх үйл явцын нэгээхэн хэсэг гэж үзэж болно.

Үндсэн хуулийн шүүхийн хүчин чадал нь түүний шийдвэрийн биелэлтээр хэмжигддэг. Эрх зүйн соёл өндөр хөгжсөн орнуудад Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр биелэхгүй байх тухай ойлголт байхгүй бөгөөд энэ ч утгаараа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг Үндсэн хуультай эн чацуу хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээ гэж үздэг.

Үндсэн хуульт ёс, Үндсэн хуулийг дээдлэх болон хуулийг сахин биелүүлэх, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг хангах шаардлагаас урган Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлыг Үндсэн хуулиар баталгаажуулан тодорхойлсон байдаг билээ. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4, Жаран долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэ талаар тодорхой заасан байна.

Эдгээр заалтаас үзэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хүчин чадлыг илэрхийлсэн гол шинжүүд тодорхой харагддаг.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь:

1. Заавал биелэгдэх
2. Давж заалдахгүй буюу эцсийн байх
3. Гармагцаа хүчин төгөлдөр үйлчлэх зэрэг гол шинжүүдтэй болно.

Дээрх дурдсан 3 шинж нь Цэцийн шийдвэрийн хүчин чадлыг тодорхойлоод зогсохгүй Цэц бол шүүх эрх мэдлийн

хэрэгжүүлэгч байгууллага гэдгийн нэг үндсэн нотолгоо болдог. Мөн түүнчлэн Цэцийн шийдвэр нь хуулийн адил хүчин чадалтайг эдгээр шинж давхар илэрхийлж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болох тухай заасан нь санамсаргүй зүйл биш бөгөөд Цэцийн шийдвэрийн дээд хүчин чадлыг тодорхойлж байгаа явдал юм. Ер нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь тухайн асуудлаар цаашид нийтээр дагаж мөрдөх, удаан хугацаанд үйлчлэх, жишиг тогтоох хандлагатай байдгаараа бусад байгууллагын шийдвэрүүдээс онцлог бөгөөд тэр хэрээрээ нийгэмд нөлөөлөл ихтэй, иргэд болон албан тушаалтнуудын хууль дээдлэх чиг хандлагыг өөрчилж чадахуйц байдгаараа онцлог юм.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах нь шүүгчдээс зөвхөн мэргэжлийн ур чадвар шаардаад зогсохгүй нилээд тохиолдолд иргэний эр зоригийн шалгуур болдог. Тийм ч учраас Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн улс, төр эдийн засгийн баталгаа, хараат бус байдлыг нарийн чамбай хуульчилж өгөх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиар Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг хуульчилан тогтоосон боловч түүнийг хараахан төгс гэж үзэх боломжгүй юм.

Үндсэн хуулийн хяналт бол Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн Үндсэн хууль амьд үйлчлэх эрх зүйн баталгаа юм. Ийм учраас Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх онцгой субъект болох Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ, чадавхийг Үндсэн хуулийн хүрээнд зөв ойлгож хэрэгжүүлэх явдал Монгол Улсын Үндэсний эрх ашгийн салшгүй хэсэг гэж үзэх ёстой. Үндсэн хуулийн шүүхийн нэг үндсэн чиг үүрэг нь үндэсний эрх зүйн тогтолцоонд Үндсэн хуульт ёсыг тогтооход орших бөгөөд энэ нь түүний шийдвэр, шийдвэрийн хэрэгжилтээс үлэмж хамааралтай юм. Хууль тогтоогчоос Үндсэн хуулийн шүүх өөрийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө хөөцөлддөг

механизмыг хуульчилан тогтоогоогүй бөгөөд энэ нь дэлхийн олонх орнуудын хууль дээдлэх эрх зүйн соёлоос улбаатай гэж үзэж болно. Хэрвээ Үндсэн хуулийн хяналтыг хүлээн зөвшөөрч байгаа бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гармагцаа хэрэгжих нь эрх зүйн соёлын энгийн цагаан толгой бөгөөд ийм эрх зүйн соёлын төвшинг манай Үндсэн хууль хүлээн зөвшөөрсөн байдаг.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо чухал рольтой болох тул түүнд ямагт хүндэтгэлтэй хандах ёстой. Үндсэн хуулийн шүүхэд хандаж буй иргэний гомдлыг хэзээ ч тухайн хувь хүний эрх ашиг гэж ойлгож болохгүй түүний цаана адил төстэй олон олон иргэдийн эрх ашиг байгаа гэж ойлгох нь илүү зохистой. Монгол Улсын Үндсэн хуулиар Үндсэн хуулийн хяналтын хүрээнд иргэдэд олгосон эрх хэмжээнд давуу тал байдаг. Энэ нь иргэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн асуудлаар зөвхөн өөрийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзсэн аль ч асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх хэмжээ нээлттэй байдаг оршино. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийг хамгаалахад иргэн бүхэн оролцох боломж нээлттэй бөгөөд мэдээж Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх эрх хэмжээний хүрээнд уг өргөдөл, мэдээлэл, гомдол гарсан байх учиртай.

Монгол Улсад Үндсэн хуульд ёсны төлөвшил жам ёсны дагуу явагдаж байгаа боловч түүний амин сүнс болох хууль дээдлэх ёс албан тушаалтан, эрх мэдэлтний төвшинд удаашралтай хангалтгүй байгаагаас улбаалан нийт иргэдийн хүрээнд ч төдийлөн сайн хэрэгжихгүй байна.

Ардчилсан Үндсэн хуулийн үр дагавар бол шударга шүүхтэй байх, шударга шүүхтэй байхын үр дагавар нь зөвхөн хуульд захирагдсан хараат бус шударга шийдвэр гаргаж чаддаг, гарсан шийдвэр нь ягштал хэрэгждэг байхад оршино.

Өнөөдрийн монголын нийгэмд улс төрийн намууд шүүх засаглалд өөрсдийн нөлөө дарамтыг бий болгохыг

хичээх хандлага хүчтэй ажиглагдаж эхэллээ. Энэ бол жинхэнэ утгаараа Үндсэн хуульт ёсны төлөвшилд хамгийн хортой үзэгдэл төдийгүй, Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хараат бус шүүхийн тогтолцоог булшилж буй асуудал гэж үзэх ёстой. Монгол Улсад Үндсэн хуулиар дархлаажсан эрх зүйт төрийн тогтолцоог төлөвшүүлэхэд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдээс эхлээд бүх шатны шүүхийн шүүгчдийн оруулах хувь нэмэр чухал болохыг онцгойлон тэмдэглэж байна.

Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн эрх хэмжээг боловсронгуй болгоход чиглэсэн хангалттай олон асуудал бидний өмнө байна. Юуны өмнө Үндсэн хуулийн хяналтыг тасралтгүй амьд байлгах, Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулах, түүнчлэн Үндсэн хуулийн эрх зүйн онолын төвшинг дээшлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Хэрвээ Үндсэн хуулиа дэлхийн төвшинд боловсрогдсон гэж үзвэл түүнийг хэрэгжүүлж буй, хамгаалж буй субъектүүдийн эрх хэмжээ, эрх зүйн соёл, мэдлэг боловсрол ч мөн тэр төвшинд байхыг өсөн урагшилж буй нийгмийн хэрэгцээ шаардаж байгаа юм.

Нөхөд өө!

Монголын нийгэмд ардчилсан эрх зүйт төр оршин тогтнох үндэс суурийг хуульчлан баталгаажуулсан Монгол Улсын Үндсэн хуулиа хэрхэн дээдлэн хүндэлж, дагаж мөрдөхөөс Монголын нийгмийн өнөөгийн хөгжил, дэвшил болон иргэдийн эрх, эрх чөлөө түүний баталгаатай хэрэгжих бодит нөхцөл үлэмж хамааралтай билээ. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үйл хэрэг шударга үнэний дэнс болж улам батжин бэхжинэ гэдэгт итгэл дүүрэн байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

*Академич Ж. Амарсанаа
Үндсэн хуулийн цэцийн дарга,
Монгол Улсын Гавьяат хуульч*

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯМРАЛ

Сүүлийн үед манайд хямралын талаар зарим судлаачид бичих болсон байна. Академич П.Очирбат дэлхийн эдийн засгийн хямрал ба эрдэс баялгийн салбарын хөгжлийн талаар (П.Очирбат. Хүүгээ номтой хүн болгоорой. УБ.2012 он 239-241 дэх тал), эдийн засгийн шинжлэх ухааны доктор Б.Баттөмөр санхүү, эдийн засгийн хямралын үүсэл, хүчин зүйл, менежментийн талаар (Үндэсний шуудан 2012 оны 1 дүгээр сарын 31. №026) бичсэн байна. Доктор Б.Чимид эрх зүйн хямрал, Үндсэн хуульт ёсны хямралын талаар (хэдийгээр хямрал гэдэг нэр томъёог шууд авч хэрэглээгүй ч) олон бүтээлдээ бичсэн байна.

Хөдөлмөрийн баатар, доктор Б.Чимид: “Эрх зүйн үгүйсгэл бол нийгмийн эрх зүйн ухамсарт илэрдэг үзэл бодлын нэн хорлонтой урсгал юм. Албан ёсны буюу эрх зүйн ухамсрын дээд түвшний үгүйсгэлд засаг, төрийн дээд, төв байгууллага өөрийн шийдвэр, үйл ажиллагаагаараа Үндсэн хуулийн алив нэг үндэслэл, заалтыг үл тоомсорлон дур зоргоор зөрчин гажуудуулдаг явдал хамаарна. Үүнээс дутуугүй аюултай үгүйсгэл нь Үндсэн хуулийн аль нэг заалтыг дургүйцэн үзэж, үгүйсгэн зөрчиж байгаа төдий бус, харин уг хуулийг бүхэлд нь, өөрөөр хэлбэл түүгээр бэхжүүлсэн ардчиллын үнэт зүйлс, үзэл баримтлал, оршин буй засаг төрийн байгууллыг нийтэд нь үзэн ядаж, үгүйсгэн устгах зорилготой нь амьдрал дээр тодорсоор байна. Засаг төрийн эрх мэдлийг эзлэн авахын тулд юу ч хийхээс буцахгүй болсон хэсэг бүлгийн тэр гүтгэлгийн нэн тэргүүний зорилго нь Монгол Улсын ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн хорин жилийн үнэнхүү ололтыг үгүйсгэхийн сацуу шинэтгэлийн замд тохиолдсон

элдэв бэрхшээл, эрх баригчдын ноцтой алдаа, завхралыг (шударгаар шүүмжлэн эв эеэр хамтран залруулахын тулд биш) элдвээр дөвийлгөн хөөрөгдөж Үндсэн хуульт байгууллыг үзэн ядсан өшөө хорсол төрүүлэх замаар олон түмнийг араасаа хуурмаглан дагуулахыг чармайж байгаад оршино. Түүний зорилго нь засгийн эрхэд гарах !!” гэсэн байна. (“Ардчилсан Үндсэн хууль-20”. УБ. 2012 он. 14-16 дахь тал)

Үндсэн хуулийн хямрал бол Үндсэн хуульт байгуулал, улс төрийн тогтолцоонд хамгийн их аюул занал учруулдаг зөрчлийн хурц хэлбэр юм.

Үндсэн хуулийн хямрал нь нийгмийн оюун санаа, эдийн засаг, улс төрийн хүрээг хамарсан, Үндсэн хуулийн тогтолцоог бүхэлд нь тогтворгүй байдалд оруулдаг зөрчлийн онцгой хүнд хэлбэр мөн. Үндсэн хуулийн хямралын үед Үндсэн хууль, түүний бодит хэрэгжилтийн хооронд үлэмж зааг гарч, тэдгээрийн хоорондын тэнцвэрт байдал алдагдаж, улмаар Үндсэн хуульд зарчмын өөрчлөлт оруулахгүйгээр Үндсэн хууль хэвийн үйлчлэх боломжгүй болдог байна.

Үндсэн хуулийн хямралаас гарах нэг гарц нь Үндсэн хууль, түүний хэрэгжилтийн уялдааг хангахад нийцүүлэн Үндсэн хуульд дорвитой өөрчлөлт оруулах замаар Үндсэн хуулийн шинэ тогтолцоог бий болгож, нийгмийг задрал, бутралаас гаргаж, Үндсэн хуулийн бодит дэг журмыг тогтоох явдал гэж зарим судлаач үзэж байна.

Улс төр, эдийн засгийн хямрал олон жил үргэлжилж, хямрал нь туйлдаа хүрч, зэвсэгт бослого, иргэний дайнд тулж байгаа орнуудын хувьд энэ нь зөв гарц болж харагдаж байна.

Энэ нь өнөөгийн Арабын ертөнцөд тод харагдаж байна. Түүнчлэн Украин, Гүрж, Казахстан, Киргиз, Белорус зэрэг посткоммунист орнуудын Үндсэн хуульт ёсны хөгжлийн замд ч улс төрийн маргааны сэдэв болсоор байна.

Ерөөс эрх зүйн тогтолцоонд хувьсгалт өөрчлөлт хийхэд хүргэх хямрал нь өөрийн үүслийн хувьд янз бүр байна. Энэ нь дараах хэдэн учир шалтгаанаар тодорхойлогдож байна. Нэгдүгээрт, эрх зүйн уламжлалт тогтолцоо нь нийгмийн шинэ бодит үзэгдэлтэй улам бүр үл тохирох асуудал (тухайлбал үүнд XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед эрх зүйг төрөлжүүлэн хуульчлах үр дүнтэй үйл явц нь уламжлалт эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөх болсон үйл явцыг жишээ болгон хэлж болох юм). Хоёрдугаарт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ гадаадын илүү боловсронгуй хуулийг шууд зээлдэн хэрэглэх (Үүнд Францын иргэний хууль тогтоомжийг Латин Америкийн орнууд хэрэглэсэн жишээг дурдаж болно). Гуравдугаарт, улс төрийн хувьсгалын эцсийн үр дүн болж нийгэм, эдийн засгийн нөхцөл өөрчлөгдөх (эрх зүйн шинэ тогтолцоог бий болгосон Франц, Оросын хувьсгал). Дөрөвдүгээрт, эрх зүйг бодит хэрэглүүр болгон ашиглаж, нийгмийг эрс өөрчилсөн улс төрийн манлайлагчдын үйл ажиллагаа (Японы Мэйжийн хувьсгал, Туркийн Танзимат¹). Тавдугаарт, Ялсан улсын тулган хүлээлгэсэн эрх зүйн тогтолцоо (Дэлхийн II дайны дараа дорнод Европын орнуудад тогтсон Зөвлөлтийн эрх зүйн тогтолцоо, Зүүн Өмнөд Ази, Африкийн орнуудад тогтсон Францын эрх зүйн тогтолцоо).

Түүхэн үйл явцыг харвал үндсэн хуулийн хямрал нь тогтолцооны болон дотоодын шинжтэй гарч байжээ. Тогтолцооных гэдэг нь нийгмийн байгуулал, эрх зүйн тогтолцоог эрс хувьсган өөрчлөхөд хүргэсэн нийгмийн том хувьсгалын үеийн үндсэн хуулийн хямрал (Франц, Орос, Хятад, Иран, Мексикийн хувьсгалын үндсэн хуулийн хямрал). Дотоодын шинжтэй Үндсэн хуулийн хямралд IV Бүгд Найрамдах улсаас V Бүгд Найрамдах улсад шилжсэн генерал Ш.де Голлийн авторитар дэглэм, орчин үед гэвэл Италид үргэлжилж байгаа Үндсэн хуулийн хямралыг хамааруулан хэлж болно.

¹ Танзимат-Түрэг: Өөрчлөн байгуулалт. Төр, шашныг тусгаарлан түшмэл ёсыг дэлгэрүүлэх замаар нийгмээ орчин үед нийцүүлэн өөрчлөхөд чиглэн Османы эзэнт улсад хэрэгжүүлсэн цуврал шинэтгэл (1839-1876).

Үндсэн хуулийн хямрал нь ихэнх төлөв улс төрийн хямралын үр дагавар болж гарч ирдэг байна. Харин улс төрийн хямрал нь эдийн засгийн хямралтай багагүй холбоотой байдгийг түүхэн үйл явц харуулж байна.

Эдийн засгийн хямрал нь тодорхой мөчлөгтэйгээр давтагдах зүй тогтолтой болохыг нь XIX зуунаас хүлээн зөвшөөрөх болжээ. 1820-иод оны сүүлчээс эхлэн эдийн засгийн хямрал арав орчим жилийн мөчлөгтэйгээр давтагдаж байжээ. Үндсэн хуулийн хямралаас ялгаатай нь эдийн засгийн хямрал дэлхийг хамарсан хэлбэртэй ч байж, бүс нутгийн хэмжээнд зарим орныг хамарсан хэлбэр ч илэрч байжээ. Гэхдээ улс төрийн хямралаа дагаад 1990-ээд онд Төв Европт, 2000 оны дунд үеэс Арабын ертөнцөд Үндсэн хуулийн хямрал болов.

Үндсэн хуулийн хямрал бүр өөрийн цаг хугацаа, орон зайн хязгаартай байна. Эрх зүй даяаршихын хэрээр Үндсэн хуулийн хямралын хил хязгаар асар хурдан өргөсөн тэлж Үндсэн хуульт ёсны хямралд өртөхгүй улс, бүс нутаг үлдэхээ байжээ.

Гадаад орны оролцоотой болон оролцоогүй төрийн эргэлт, бослого, зэвсэгт тэмцэл нь үндсэндээ Үндсэн хуулийн эсрэг, хүч хэрэглэсэн, улс төрийн эрхийг авах оролдлого юм. Үндсэн хуулийн хүрээнд, түүгээр ч үл барам Үндсэн хуулийн хэм хэмжээг нийгэм, улс төрийн шинэ агуулгаар баяжуулсан эргэлт ч гарч байна. Түүнчлэн зарим орны Үндсэн хуульт ёсны хөгжлийн явцаас ажиглахад гадаад, дотоодын аюулаас Үндсэн хуульт байгууллаа хамгаалах зорилгоор эргэлт хийх үзэгдэл ч байна.

Үндсэн хуульт ёс хэрэгжиж байхад түүний үйлчлэлийг зогсоох, нэг ёсондоо хэрэгжүүлэхгүй байх нэг арга зам нь онц байдал тогтоох явдал гэдгийг дэлхий дахины сүүлийн жилүүдийн улс төрийн амьдрал харуулж байна. Онц байдлын институт бол эрх зүйн хувьд Үндсэн хуулийг хамгаалах, Үндсэн хуульт байгууллыг аливаа доргилтоос сэргийлэх (Франц), эсвэл бүр эсрэгээр Үндсэн

хуулийн хэм хэмжээг үл хэрэглэх, Үндсэн хуулийг халах (Испани) хэрэгсэл юм. Онц байдал бол Үндсэн хуульт ёсны хэрэгжилтийн чухал үзүүлэлт юм. 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа хожимдож тогтоосон, цаг үеэ олоогүй онц байдлын нөхцөл нь Үндсэн хуулийн бодит хэрэгжилттэй ямар уялдаатай байсныг тусгайлан судлах нь ирээдүйд сургамж болох юм.

Үндсэн хуулийн хурц хямралын үед зөрчилдөөнийг зохицуулахад улс төр, эрх зүйн арга хэрэгслийн алийг нь илүүтэй ашиглах асуудал тулгарахад хэрвээ хууль зүйн дагуу оновчтой, зөв хэрэглэж чадвал онц байдлын механизм Үндсэн хуульт ёсыг хамгаалахад бас ч чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн хямралын үед онц байдал тогтоох нь Үндсэн хуулийн нэг баталгаа мөн.

Сүүлийн үед Үндсэн хуулийн хямрал руу түлхэж байгаа хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, посткоммунист тогтолцооноос ардчилал руу шилжих шилжилтийн бэрхшээл (жишээ нь төрийн эргэлтийн дараа Киргизэд Үндсэн хуулийн шүүхийг татан буулгасан), Үндсэн хуулийг төгөлдөржүүлж, сайжруулах оролдлого болон уламжлалт хуучны үзэл хоорондох зөрчил, Үндсэн хуулийг “баруунжуулах”, “Христосчилох үзэл” ба лалын шашны хоорондох зөрчил, засгийн эрхийг авахын төлөө олигархийн тэмцэл, олон нийтийн зүгээс биш, эрх баригчдын зүгээс өөрсдийн таашаалд нийцүүлэн Үндсэн хуулийг өөрчлөх санаархал, оролдлого, мөн дэлхийн, бүс нутгийн, тухайн орны улс төр, санхүү, эдийн засаг, эрчим хүчний зэрэг хямрал Үндсэн хуулийн хямралын суурь болж байна. Үндэстнийг, намыг, удирдагчийг шүтэх үзэл ч Үндсэн хуулийн хямралыг өдөөж байна.

Дэлхийн энэ хандлага Монгол Улсыг тойроогүй юм.

Хэдийгээр социалист хэв загварт хамаарах ч 1920, 1940, 1960 оны Үндсэн хууль нь өөр өөрийн түүхэн хөгжлийг дамжжээ. Энэ гурван Үндсэн хууль нь хэлмэгдүүлэл, харгислал, нэг намын дарангуйлал, эдийн засгийн хямрал зэрэг олон үйл явцад хамааралтай ба

тус бүрийнхээ хөгжлийн явцад Үндсэн хуулийн хямралд өртөж байжээ.

1992 онд Монгол Улс ард нийтээрээ хэлэлцүүлж дөрөв дэх Үндсэн хуулиа баталсан. 1992-2000 он бол эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн хямралт үе байв. 2000 онд МАХН, МҮАН, МСДН хуйвалдааны хэлбэрээр “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт”-ийг батлав. Энэ баримт бичиг нь ядаж “хууль” гэсэн нэршилгүй. Үндсэн хуулийн бус аргаар оруулсан эл өөрчлөлт монголд жинхэнэ Үндсэн хуулийн хямралын эхийг тавьсан бөгөөд одоо нэгэнт эрч хүчээ аваад 12 жилийг ардаа үджээ. Тэр үед ямар өөрчлөлт оруулсныг хүснэгтлэн харьцуулж үзье.

(Б.Чимид. Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. УБ. 2008 он. 192-210 дахь тал)

Д/д	1992 оны Үндсэн хуулийн аль заалтыг хэрхэн өөрчилсөн	Уг эхийн найруулга (1992 он)	Нэмэлт өөрчлөлтийн найруулга (2000)
1	Хорин долдугаар зүйлийн 2-йг өөрчлөн найруулсан.	Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.	Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.
2	Хорин долдугаар зүйлийн 6-г өөрчлөн найруулсан.	Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.	“Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж өөрчлөн найруулсан. “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ” гэж нэмсэн.
3	Хорин есдүгээр зүйлийн 1-ийг өөрчлөн найруулсан	Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.	Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. 6 үг нэмсэн.

4	Гучин гуравдугаар зүйлийн 1.2-ийг өөрчлөн найруулсан	<p>Ерөнхийлөгч: 2) “Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах” <i>(тодруулсан хэсэг буюу 8 үгтэй заалтыг сураггүй алга болгосон)</i></p>	<p>Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах.</p>
5	Хорин дөрөвдүгээр зүйлийн 1-д нэмэлт оруулсан	<p>Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно.</p>	<p>Эхний хэсэг хэвээр. “Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их хурлын дэд даргыг сонгоно” гэж нэмсэн.</p>
6	Гучин есдүгээр зүйлийн 2-т нэмэлт оруулсан	<p>Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p>	<p>Эхний хэсэг хэвээр. “Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ” гэсэн 2 дахь хэсэг нэмсэн.</p>
7	Хорин хоёрдугаар зүйлийн 2-т нэмэлт оруулсан	<p>2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.</p>	<p>2.2 дахь хэсэг хэвээр: “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тарах тухай шийдвэр гаргана” гэсэн дугааргүй хэсэг нэмсэн.</p>

Энэ өөрчлөлтийн урхаг нь юу вэ?

Ёс бус аргаар гар дүрснээс болж Үндсэн хууль өөрөө “амьд организмын” хувьд бүрэн хэрэгжих чадваргүй, “хөгжлийн бэрхшээлтэй”, “зэрэмдэг” баримт бичиг болжээ. Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал алдагдав. Төрийн эрх мэдлийг хуваарилах, нутгийн өөрөө удирдах ёс, хүний эрх, шүүхийн хяналт зэрэг чухал институт, зарчим суларч, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд хүрэв.

Доктор Б.Чимид толгойлсон ажлын хэсгээс боловсруулсан “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл”-ийг Улсын Их Хурал 2010 оны 12 дугаар сарын 23-нд баталсан нь Үндсэн хуульд яаруу сандруу, хөнгөн хийсвэрээр, судалгаа тооцоогүй, хийрхэл, хөөрлөөр нэмэлт, өөрчлөлт оруулахыг боломжийн хэмжээнд хааж хязгаарласан юм.

Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн заалтад яаран сандран зарим нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2011 оны 11 дүгээр сарын 30-нд баталж, дээрх хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.6 дахь заалт, 11.4, 11.5 дахь хэсгийг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэж, Улсын Их Хурлын сонгуулиас 6 сарын өмнө Үндсэн хуульд гар хүрэхийг санаархав. Хэдхэн хоногийн өмнө болсон Улсын Их Хурлын сонгуулиар байгуулах шинэ парламент энэ онд амжиж санаархлаа хэрэгжүүлэхийг үгүйсгэх аргагүй.

Удаан үргэлжилж байгаа Үндсэн хуулийн хямралын учиг, шалтгаан нь юу вэ?

Үүнийг дараахь хэдэн зүйлээр хураангуйлан тодорхойлж болно. Тухайлбал,

1. Үндсэн хуульд заасан хуулийг хугацаанд нь батлаагүй, төрийн байгууллагын бүтцийг зөв шийдээгүйгээс болж шилжилтийг хэт удаашруулж сунжруулж байна. Тэгсэн атлаа зарим нам шилжилтийн

үе дууслаа, үсрэнгүй хөгжлийн үе эхэллээ гэж үл бүтэх дүгнэлт хийж ард олныг төөрөгдүүлж байна.

2. Барууныг баримжаалсан шинэчлэгчид, уламжлалыг баримталсан эх орончдын зөрчлийг илэрхийлсэн ертөнцийг үзэх үзэлд ялгаа зааг их байна.

3. Засгийн газрыг нам, Улсын Их Хурлыг Засгийн газар ноёлох хандлагатайн гадна төв засаг, орон нутгийн хоорондын зөрчил (ажлын уялдаагүй, удирдах чиг баримжаа муу) багагүй байна.

4. Социалист системийн задрал, түүний оюун санаа, ахуйн нөлөө, тусгал байсаар байна.

5. Олон нийтийн улс төр, эрх зүйн ухамсар нь Үндсэн хуулийг ойлгох, хүлээн авах, хэрэгжүүлэх төвшинд хүрээгүй байна.

6. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, төрийн эдийн засгийн шинэтгэлийн тууштай биш байдал, цогц бодлогогүй үйл ажиллагаа хийгээд улс төр, бизнесийн хэтэрхий сүлэлдсэн байдал суурь шалтгаан болж байна.

7. Төрийн байгууллага, албан тушаалтан төдийгүй иргэдийн хувьд ч гэсэн Үндсэн хууль дээдлэх, хууль дээдлэх үзэл санаа, дадал, арга барил төлөвшөөгүй байна.

8. Улс төрийн бодлогод хувь хүний нөлөө, субъектив роль их байна.

9 Үндсэн хуулийн хямралын урьтал болох улс төрийн хямрал үргэлжилсэн хэвээр, байсаар байна.

Бид нэн даруй юу хийх ёстой вэ?

1. Нийгмийн амьдралын бүх салбарт Үндсэн хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх;

2. Хүний эрхийн баталгааг сайжруулах;

3. 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгож, Үндсэн хуулийн 1992 оны заалтыг сэргээн тогтоох;

4. Хууль, захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд ягштал нийцүүлэх;

5. Ерөнхийлөгчийн дэргэд Үндсэн хуулийн комисс байгуулж эрдэмтэн, судлаачдыг голлон оролцуулж, Үндсэн хуулийн хэрэгжилт үр дүнг бүхэлд нь судлан тооцож, шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, төсөөллийг боловсруулах...

Анхаарал хандуулсанд баярлалаа.

*Хууль зүйн шинжлэх ухааны
доктор, профессор Н.С. Бондарь,
ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч,
ОХУ-ын шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн,
ОХУ-ын Гавьяат хуульч*

**ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХТ ЁСНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ:
ОРОС УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ
АЖИЛЛАГААНЫ ПРАКТИКИЙН ХҮРЭЭНД
АСУУДЛЫГ ТАВИХ НЬ**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойд зориулсан Олон улсын симпозиумын хүрээнд *Үндсэн хуульт ёсыг хамгаалах* (тэр дундаа, *шүүхийн журмаар хамгаалах*) асуудлыг тавьж хэлэлцүүлж байгаа нь үндсэн хуулийн шүүх цаазын байгууллагуудыг төлөөлөн энэхүү форумд оролцож буй бүх улс орнуудад чухал ач холбогдолтой болох нь эргэлзээгүй юм.

Энэ нь орчин үед үндсэн хуульт ёс бүхэлдээ хямралд орж, түүний бүтэц чиг үүргийн гол шинжүүд төдийгүй үндсэн хуулийн ардчилсан зарчмын сонгомол институцийн үнэт зүйлсийг ч хамарч байгаатай холбоотой юм. Үүнийг дагаад, нэг талаас, үндсэн хуулийн түгээмэл зарчмууд, эрх зүйт ёс, ардчилал, хүний эрхийг дээдлэх ёсны үнэт зүйлс, нөгөө талаас, хүн төрөлхтөнд 21-р зуунд тулгарч буй дэлхий нийтийг хамарсан шинэ аюул заналхийллийн нөхцөлд төрийн бүрэн эрхт байдлыг хамгаалах, хувь хүн, нийгэм, төрийн аюулгүй байдлыг хангах бодит практик хоорондын зөрчилдөөн гүнзгийрсээр байна.

Орчин цагийн дэлхийн геополитик өөрчлөлтүүд нь улс төр, эдийн засгийн төдийгүй үндсэн хуулийн хэмжүүрээр хэмжигдэж; эдгээр нь үндсэн хуульт ёсны шинэ философи *г* бүтээх, орчин үеийн үндсэн хуульт ёсны ертөнцийг үзэх үзэл, ёс зүй-зан суртахууны, нийгэм-эдийн засгийн, улс төрийн үндсийг зарчмын шинэ хандлагаар боловсруулах шаардлагыг бодитоор тодорхойлж байна.

Үүний зэрэгцээ орчин үеийн үндсэн хуульт ёсыг танин мэдэхүйн нийтлэг зүй тогтолд үндэслэхээс гадна улс орны үндсэн хуулийн хөгжлийн түүхийн онцлогийг харгалзан үзэх шинэ шаардлагууд гарч, ялангуяа үндсэн хуулийн шүүх цаазын мэргэжлийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэх нь онцгой чухал асуудал юм.

1. Орчин үеийн үндсэн хуульт ёсыг үндсэн хуулийн шүүхийн журмаар хамгаалах арга зүйн үндэс: ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн практикт позитивизм ба байгалийн хууль зүйг хослуулах нь.

Түүхийн урьд өмнөх аль ч үе шатанд мэдэгдэж байгаагүй улс төр, нийгэм-эдийн засгийн, ёс зүй-зан суртахууны хурдацтай өөрчлөлт, төрийн болон нийгмийн амьдралын талаарх үндсэн хуулийн шинэчлэл (пост социализмын улс орнууд, тэр дундаа Орос улс үүнтэй тулгарсан) нь үндсэн хуульт ёсыг шинжлэн судлах арга зүйн зогсонги хүрээнээс гарч, эрх зүйн хэм хэмжээг нийгэм зүй, түүх, ёс зүй-зан суртахууны болон ертөнцийг үзэх философийн арга зүйтэй хослуулан үндсэн хуульт эрх зүйн төвөгтэй үзэгдлийг танин мэдэх шаардлагыг бодитоор тодорхойлж байна.

Чухамхүү эдгээр хандлагад тулгуурлан орчин үеийн дэлхий нийтийг хамарсан үндсэн хуульт ёсны дотоод холбоос, ерөнхий зүй тогтол, нийгэм соёлын онцлогийг илрүүлж, үнэлж дүгнэх боломжтой болно. Энэ нь тохиолдлын зүйл биш, учир нь, үндсэн хууль нь аливаа нийгмийн *нийгэм төрийн зөрчилдөөний үр дүн*, тэдгээрийг *таслан шийдвэрлэх хууль зүйн үндэс* нь болж, улмаар эрх мэдэл ба эрх чөлөө хоёрыг тэнцвэржүүлэх эрх зүйн арга хэрэгсэл болдгоороо *үндсэн хуулийн нийгэм-улс төрийн утга агуулгын гүн гүнзгий шинж* нь тодорхойлогдоно. Үүний хамт үндсэн хууль нь амьдралын бодит байдал, нийгмийн бодит нөхцлийн нэг хэсэг болохын зэрэгцээ түүхийн нэг хэсэг байдаг тул үндсэн хуулийг орчин үед дэлхийд тулгарч буй асуудлуудтай холбоотойгоор судлан шинжлэх арга зүйн гол асуудал нь түүнийг түүх-

соёлын талаас нь авч үзэх явдал юм¹. Соёл шинжлэлийн судалгааны арга нь үндсэн хуульт ёсны философийн орчин үеийн үзэл баримтлалын үндсэн аргуудын нэг болох учиртай. Хууль зүйн талаасаа зүй зохистой гэж үзэх аливаа үндэслэл шалтгаан нь үндэсний соёл зан суртахуун, нийгэм эрх зүйн үзэгдлийн үнэлэмжээс ангид байж чаддаггүй билээ.

Энэ өнцгөөс харвал, үндсэн хуульт тогтолцооны философийн өнөөгийн байдлыг, оросын хууль зүйн философич И.А.Ильины хэлснээр, арга зүйн авралын нэг ургальч үзэлд итгэл алдарч, арга зүйн олон ургальч үзлийн зарчмыг хүлээн зөвшөөрөх шилжилтийн үе² гэж тодорхойлж болох юм. Энэ нь ертөнцийг үзэх философийн олон ургальч үзлийг судалгааны онолын гол арга зүй болгож, ардчилсан төрт ёсны бүх тогтолцоог зохион байгуулах, чиг үүргийг тодорхойлоход эрх зүйн хэм хэмжээний нэн чухал (үндсэн хуулийн ач холбогдол бүхий) зарчим мөн хэмээн хүлээн зөвшөөрч баталгаажуулахыг бодитоор шаардаж байна.

Ингэж хандах нь шинжлэх ухааны арга зүйн хувьд ч, хавсарга шинжлэх ухааны хувьд ч ач холбогдолтой. Тухайн нийгмийн амьдралыг орчин үеийн үндсэн хуульт ёсны философийг хэрэгжүүлэх талбар, түүнийг хөгжүүлэх институцийн арга гэж үзэн жишвээс, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх (цаашид ОХУ-ын ҮХШ гэнэ)-ийн шийдвэр нь орчин үеийн үндсэн хуульт ёсны философийн материаллаг (онолын хэм хэмжээний) хэрэгжилт гэж үзэх нь чухал юм.

Хууль цаазын практик судлалын үндэслэл болох олон ургальч арга зүйн зарчим нь үндсэн хуулийн шүүн таслах түвшинд хамгийн ихээр туршигдаж, цэвэр шүүхийн үйл ажиллагаа төдийгүй хууль тогтоох уламжлалт үйл ажиллагаанаас нэлээдгүй ялгаатай үндсэн хуулийн шүүхийн хууль бүтээх ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй

¹ См.: Зорькин В.Д. Конституционно-правовое развитие России. М.: Норма, 2011.- С. 6.
² См.: Ильин И. А. Понятия права и силы (Опыт методологического анализа) // Ильин И. А. Собр. соч.: в 10 т. Т. 4. М., 1994.- С. 9-10.

нөхцлийг бүрдүүлж өгдөг билээ. Хууль тогтоогч нь хэм хэмжээ тогтоох суурь зарчимд тулгуурлаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээг өөрчлөгдөж буй нийгмийн нөхцөлд тохируулах үүрэгтэй бол үндсэн хуулийн шүүхийн хууль бүтээх үйл ажиллагаанд тодорхой үнэлэмж тогтоох хандлага нь давамгайлж, үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын хууль зүйн мөн чанарыг тодорхойлох, үл зөрчилдөх, дотоод зөвшилцөл, үйлчлэх нөлөөг хангаж өгдөг.

Түүнчлэн ОХУ-ын үндсэн хуулийн байгууллын үндэс, түүнд хамаарах эрх зүйт нийгмийн төр, ардчилал, бүгд найрамдах болон холбооны бүгд найрамдах төрийн хэлбэр, иргэн хувь хүний эрх, эрх чөлөө, улс төр эдийн засгийн олон ургальч үзэл зэрэг өндөр түвшний зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэх явдлыг хангах учиртай. Үүний дагуу, ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэр, тэдгээрт дурдсан эрх зүйн дүгнэлтүүдэд үндэслэн тодорхойлогдох позитив эрх зүйн тогтолцоо (хууль тогтоомж) нь түүхийн тодорхой нөхцөлд үндсэн хуулийн хэм хэмжээний талаарх ойлголтуудыг шүүхийн журмаар тайлбарлаж, тодорхой болгож байгаа ажиллагаа юм. Үүнээс урган, Үндсэн хуулийн шүүхийн хууль бүтээх ажиллагаа уламжлалт хууль боловсруулах ажиллагаатай харьцуулахад, олон ургальч арга зүйн зарчмыг хэрэгжүүлсний үр дүнд илүү хөдөлгөөнтэй, уян хатан болдог байна.

Ялангуяа «үндсэн хуульт ёс» гэх өргөн хүрээг хамрах ойлголтын чанараас харвал: агуулгын хувьд эрх зүйн үйл явдлуудыг хамруулахаас гадна хуулийн биш (үүний дотор хуулийн өмнөх, хуулийн дараах), тэр ч атугай “хуулиас гадуурх” нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын шинжтэй үзэгдлүүдийг хүртэл хамарч чаддаг. Ингэхдээ үндсэн хуульт ёсыг бүрдүүлэх нийгэм соёлын урьдчилсан нөхцөл, түүний дотоод шинж чанарууд (нийгэм, соёл судлал, ёс зүй-зан суртахууны г.м.)-ыг илэрхийлж, үндсэн хуульт ёсны институцын зохицуулах хэм хэмжээний дэд системийг тодорхойлж, улмаар түүний оршин тогтнох, хөгжих орчин нь болж, түүний үндэс суурь болох түүхийн тодорхой шинж

чанарт шийдвэрлэх нөлөө үзүүлдэг байна.

Ертөнцийг үзэх олон ургальч үзлийн хэмжээсийн дотор янз бүрийн үзэл санааны эхлэлүүд байдаг боловч олон ургальч үзлийн эрх зүйн хэм хэмжээний мөн чанар, орчин үеийн үндсэн хуульт ёсны ертөнцийг үзэх философи ухагдахуун нь *орчин үеийн төр-эрх зүйн тогтолцоон дахь үндсэн хуулийн орон зайд позитивизм ба байгалийн хууль гэсэн эрх зүйн ойлголтын хоёр төрлийг хэрэгжүүлэх явдал байдаг.*

Позитивизм ба байгалийн хууль гэх эрх зүйн ойлголтууд нь гүн ухаанд «Платоны шугам» ба «Аристотелийн шугам» гэдэгтэй ойролцоо үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд тус бүрдээ чухал ач холбогдолтой хоёр төрөл юм. Эрх зүйн философийн энэ хоёр чиглэлээр дамжин орчин үеийн үндсэн хуульт ёсны зарчмын маш чухал, арга зүйн ач холбогдол бүхий гносеологийн /мэдлэг зүйн/ зорилтуудыг хэрэгжүүлэх талаар энд яригдах учиртай.

Энэ утгаараа ОХУ-ын 1993 оны Үндсэн хуулийг ертөнцийг үзэх философийн олон ургальч үзлийн шинжтэй гэж тодорхойлж болно. Гэвч энэ нь Орос улсын үндсэн хуулийн хүрээнд ертөнцийг үзэх үзэл санаа холилдох буюу байгалийн эрх зүйн төрөл нь эрх зүйн позитивист ойлголттой өрсөлдөж байгаа асуудал биш³. Ингэж хандах нь байгалийн эрх зүйн болон позитивист эхлэлийг хооронд нь сөргөлдүүлж, тэдгээрийн харьцангуй бие даасан хууль зүйн үнэт зүйлс, тэгш байдал, эрх чөлөө, шударга ёс зэргийг хөндөхгүй боловч зэрэгцэн орших боломжийг нь үгүйсгэх юм. Үүний хамт, эртний гүн ухааны туршлагаас үндэслэн, философийн эсрэг эхлэлүүдийн хоорондын хурцадмал байдлын дундаас шинэ эерэг чанар бий болгох, эерэг үр дүнд хүргэх боломжит харилцааг үүсгэж

³ Такие оценки имеют место, когда, например, утверждается, что в России «конституционная концепция прав человека (и концепция должного закона) эклектически (выделено мною. – Н.Б.) соединяет непозитивистские представления о правовой свободе с позитивистскими представлениями о правах как законодательно санкционированных притязаниях» (См.: Четвернин В.А. Российская конституционная концепция правопонимания // Конституционное право: восточноевропейское обозрение. 2003. №4. С.32).

болдог. Энэ үүднээс ОХУ-ын Үндсэн хуулийг анхааралтай, урьдчилан дүгнэлт гаргахгүйгээр судалж үзвэл, өөрийн үзэл санааны хувьд байгалийн эрх зүй ба позитивизмын онолд ялгавартай хандах боловч тэдгээрийг хооронд нь сөргөлдүүлэхгүйгээр, эсрэг тэсрэг зөрчилдөөнд хүргэхгүйгээр, харин эрх зүйн хэрэглээг үр нөлөөтэй болгох зорилгоор тэдгээрийг харилцан зөвшилцөх, нийлэгжүүлэн ойлголцуулах байдлаар боловсруулахыг хичээсэн байна.

Үнэхээр, ОХУ-ын Үндсэн хууль нь байгалийн эрх зүйн онолын үзэл санааг ихэнхдээ хэрэгжүүлсэн байдаг. Үндсэн хуульд зааснаар, хувь хүн, түүний эрх, эрх чөлөө нь дээд үнэт зүйлс мөн (2-р зүйл); үүнийг хүн бүр төрсөн цагаасаа эдэлж, салгаж үл болох (17-р зүйл) ба дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчмыг ОХУ-д даган мөрдөж, баталгаажуулсан байдаг. Үүний хамт ОХУ-ын Үндсэн хуулиас харахад, байгалийн эрх зүйн эхлэл (Үндсэн хуулиас шууд урган гарсан)-ийг хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хуулиар зохицуулах асуудалтай сөргөлдүүлж хэрхэвч болохгүй. Харин хүний эрхийн эрх зүйг төрийн эрх зүйн журмаар тогтоох эрх хэмжээг холбооны хууль тогтоогчдод шууд олгосон (71-р зүйлийн «в») бол ОХУ-ын Үндсэн хуулийн 18-р зүйлд, *хуулийн утга агуулга, хэрэглэх хэмжээг түүнд тусгагдсан эрх, эрх чөлөөгөөр тодорхойлно* гэсэн шаардлагыг бэхжүүлж өгсөн нь эрх, эрх чөлөөний заалтад агуулагдах байгалийн эрх зүйн үндсийг позитив (төрөөс батлагдсан) хуулиудад бодитоор тусгаж, хууль хэрэглэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь чухал юм.

Ийнхүү Оросын орчин үеийн үндсэн хуульд ёсны ертөнцийг үзэх философийн системд байгалийн болон позитивист эрх зүйн үндсүүдийг *эрх зүйн хуулийн* үзэл санаанд нэгтгэж оруулжээ. Оросын үндсэн хуульд ёсны ертөнцийг үзэх философийн энэхүү хоёр үндсийг хооронд нь тохируулан зохицуулах, нэгдэж нийцүүлэх эрх зүйн зохион байгуулалтын гол механизм нь ОХУ-ын ҮХШ юм.

Үндсэн хуулийн шүүн таслан ажиллагааны уг зорилт нь практикийн хавсарга ач холбогдолтой төдийгүй үндсэн хуулийн шүүхээс хууль зүйн хяналт тавих хуулийн зүй тогтлыг бүрэлдүүлж, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд философийн онол сургаалийг ашиглан үндсэн хуулийн эрх зүйн зохих хандлагууд (үндэслэл шалтгаан)- ыг боловсруулах бодит шаардлага, боломж бололцоог гаргаж өгөх юм. Үндсэн хуульд ёсны философийг үндсэн хуулийн хяналтын хүрээнд авч үзвэл, тогтолцоо үүсгэх үндэс бүхий өргөн хүрээтэй утга агуулахаас гадна үндсэн хуулийн хяналтын өөрийн институцийн утгыг тодорхойлж, түүний чиг үүргийн шинж чанарт нөлөөлөхийн хамт үндсэн хуулийн шүүн таслах байгууллагын практик үйл ажиллагааг ч олон талаар чиглүүлж өгнө. Хууль ба эрх зүй хоёрын үзэл баримтлалд ялгавартай хандаж, Үндсэн хуультай харьцах тэдгээрийн харьцааг ил гаргаж, үүний үндсэн дээр эрх зүйн хуулийг боловсруулахыг эрмэлзэх нь хууль тогтоомжийн актуудын эрх зүйн агуулгыг тодорхойлох, тэдгээрийг Үндсэн хуульд нийцүүлэх, улмаар шүүх хяналтын энэхүү чиг үүргийг өөрийн институцтэй болгох асуудлыг тавихад шийдвэрлэх нөхцөл нь болох юм. Харин эсрэгээр, хууль эрх зүй хоёрыг адилтгах, хуулийг гагцхүү хууль тогтоогчийн хүсэл зоригтой холбон дотоод эрх зүйн үндэс гэх буюу хуулийн позитивизмын шинжтэй болгох нь үндсэн хуулийн хяналт тавих боломжийг зарчмын хувьд үгүйсгэж, уг онолоор “хууль тогтоогчийн байнга зөв байдаг” гэсэн туйлшралд хүрэх ба ийм нөхцөлд хууль тогтоогчийн ажиллагаа хууль ёсны эсэхийг үнэлж дүгнэх утгагүй болно.

Үндсэн хуулийн эрх зүйн онолд түшиглэн үндэсний хууль тогтоомжийн хэм хэмжээний талаарх маргааныг хянаж дүгнэх явцад *ОХУ-ын ҮХШ нь өөрийн практикт байгалийн эрх зүй ба позитивист үндсийг тэнцвэртэй хослуулахыг эрмэлзэж байдаг*. Эрх зүй нь өөрийн гарал үүсэл, утга агуулгын хувьд «хууль бүтээхээс гадна» буюу «хууль бүтээхээс өмнөх» шинжтэй байдгийг харгалзан ОХУ-ын ҮХШ нь эрх зүйн үзэл санааг (түүний өргөн утгаар

нь) зөвхөн хуульд бүрэн дүүрэн илэрхийлэх шаардлагатай хэмээж, хууль нь эрх зүйн тодорхой хэлбэр байдлыг хангах, түүнийг нэг мөр ойлгож хэрэглэх, эцсийн дүнд эрх зүйн амьдралд оролцогч бүх субъектуудын эрх тэгш байдлыг хангах үүрэгтэй гэж үздэг.

Ингэхдээ ОХУ-ын ҮХШ нь эрх зүй ба хууль хоёрыг эсрэг тавих бус, харин хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн эрх зүйн агуулгыг хангахын тулд үндсэн хуулийн эрх зүйн бүх боломж арга хэрэгслийг ашиглах хэрэгтэй гэж үздэг нь ОХУ-ын ҮХШ хуульд хэрхэн нандигнаж ханддагийн илэрхийлэл бизээ. *Үндсэн хуульд ёсыг хуулийн үнэн чанар* гэж үзэх зарчим чухамхүү үүнтэй холбоотой бөгөөд үндсэн хуулийн эрх зүйн тайлбар гаргах, үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны журмаар хуулийн эрх зүйн (үндсэн хуулийн) утгыг тогтоож, хууль хэрэглэх практикаас эрх зүйн бус буруу ойлголт тайлбаруудыг арилгах аргууд бий болж байна.

ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрийн тухайн хэм хэмжээний талаарх тайлбарыг л үндсэн хуульд ёсны гэж үзэх ба өөр ямарваа тайлбарыг үгүйсгэх тул үндсэн хуулийн бус тайлбарыг хэрэглэвэл тухайн хэм хэмжээг ОХУ-ын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэхтэй адил үр дагаварт хүргэх юм⁴.

Улс төр-эрх зүйн олон ургальч арга зүйд үндэслэснээр ОХУ-ын ҮХШ нь үндсэн хуульд ёсны бүх тогтолцоог хамгаалахаас гадна өөрчлөн шинэчлэх нөлөө үзүүлж, *үндсэн хуульд ёсны эрх зүйн хэм хэмжээнд онолын «амь оруулж»* байгаа нь ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрүүдийн хууль зүйн онцлог шинж чанартай нь холбоотой.

ОХУ-ын ҮХШ-ийн агуулга, шинж чанар, үр дүн зэргээр түүний хууль хэрэглэх үйл ажиллагаа дуусдаггүй. Харин бүр илүү төвөгтэй шинж чанартай болох нь манай орны хууль цааз судлалын хүрээнд улам тодорхой болж: үндсэн хуулийн шүүн таслах ажиллагаа нь хэрэг шүүн шийдвэрлэх

⁴ См.: Постановление КС РФ от 21 декабря 2011 г. № 30-П // СЗ РФ. 2012. № 2. Ст.398; Определение КС РФ от 11 ноября 2008 года №556-О-П // СЗ РФ. 2008. №48. Ст.5722.

явцдаа хууль хэрэглэх институцийн хэлбэрийг агуулж, эрх зүйн үр дагаврын шинжээрээ хэм хэмжээ тогтоох хуулийн практик, хууль бүтээх ажиллагаанд ойртож байна.

ОХУ-ын ҮХШ-ийн эдгээр төрлийн ажиллагааны үр дүнд *үндсэн хуулийн шүүхийн хэм хэмжээ тогтоосон шийдвэр* гэх хэм хэмжээний үндэс болсон онцгой төрлийг бүрэлдүүлж байна. Ингэхдээ хэм хэмжээ тогтоох явдлыг онол зүйн үндэстэй хослуулдаг гол онцлогтой. Мөн хэм хэмжээ тогтоох ба онол зүйн эхлэл хоёр нь ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрийн бие даасан шинж биш, харин тэдгээрийг нэгтгэснээр уг төрлийн актуудын нэгэн шинэ чанар буюу *хэм хэмжээний онол зүйн* шинж чанар бүхий эрх зүйн болон хууль зүйн шинжлэх ухааны өвөрмөц эх үүсвэрийг бий болгож байна. Энэ нь ОХУ-ын ҮХШ-ийн практикаар мөн батлагдаж, түүний гаргасан шийдвэрүүд нь шинжлэх ухааны судалгаанд тулгуурлахын хамт хэм хэмжээний онол зүйн шинж чанарыг агуулж байна⁵.

Хэм хэмжээний онол зүйн мөн чанараас хамааран *эдгээр актууд нь эрх зүйн эх сурвалжийн системд хоёрдмол зорилготой* байдаг. Нэг талаас, ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрүүд нь үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалж, нөгөө талаас, эрх зүйн бусад салбарын (тодорхой хэрэгт хэм хэмжээнд хяналт тавих зүйл) эх сурвалж болж, үүний ачаар үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээ болон салбарын хууль тогтоомжийн хэм хэмжээнүүд хоорондоо «барьцалдаж», хэрэг хэлэлцэх явцад үндсэн хуулийн зарчим үнэт зүйлс нь салбарын эрх зүйн харилцаанд нэвтрэн орох, харилцан холбогдох бодит нөхцөл ажиглагдаж байна. Энэ нь эргээд, салбарын хууль тогтоомж төдийгүй нийгмийн холбогдох хүрээний бодит нөхцөл, хууль хэрэглэх практик үндсэн хуульд зохицоход нөлөөлж, ингэснээр үндсэн хуулийн хүрээ хязгаар өргөжиж, салбар эрх зүйн хэм хэмжээ болон хууль хэрэглээний чадамж нь үндсэн хуульт ёсны тогтолцоог

⁵ См.: Постановление КС РФ от 18 июля 2008 г. №10-П // СЗ РФ. 2008. №31. Ст.3763; Постановление КС РФ от 22 июня 2009 г. №10-П // СЗ РФ. 2009. №27. Ст.3383; Определение КС РФ от 6 марта 2008 г. №214-О-П // СЗ РФ. 2008. №18. Ст.2092; Определение КС РФ от 1 апреля 2008 г. №194-О-П // СЗ РФ. 2008. №18. Ст.2093.

баяжуулж өгдөг байна. ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрийн тусламжтайгаар үндсэн хуулийн суурь үндэс (түүний зарчим, үнэт зүйлс)-ийг Үндсэн хуулиас хууль тогтоомжийн бусад салбарт дамжуулан шилжүүлж, цаашилбал төр, түүний байгууллага, албан тушаалтны хууль хэрэглэх үйл ажиллагаа, хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад хэрэгжиж биелэгдэх тухай энд яригдах юм.

Энэ нь үнэндээ, үндсэн хуулийн шүүн таслан ажиллагаа эрх зүйн хэм хэмжээ болон эрх зүйн журмын хууль хэрэглээний бүрэлдэхүүнд нөлөөлөх зөвхөн гаднах хувиралын хэлбэр юм. Бусад илүү төвөгтэй механизм нь зөвхөн шилжүүлэн дамжуулах төдийгүй үндсэн хуулийн эрх зүйн эрч хүчийг түүний хэм хэмжээ тогтоох болон онол зүйн шинж чанаруудтай нэгтгэж, хуулийн шаардлага бүхий ёс зүй-зан суртахууны, соёл судлалын хүчин зүйлсийг нийлүүлсний үндсэн дээр үйлдвэрлэл, дахин үйлдвэрлэл явуулах, ингэснээр үндсэн хуулийн шүүн таслах ажиллагаатай харьцах, орчин үеийн үндсэн хуульт ёсны утга агуулга, гүн гүнзгий шинж чанарт нөлөөлөх бололцоог тодорхойлох ач холбогдолтой юм.

2. Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагаа нь “амьд” (шүүхийн) үндсэн хуульт ёсны эх үүсвэр болох нь.

Орос улсад хэрэгжүүлсэн үндсэн хуулийн хүчирхэг хууль зүйн загвар нь ОХУ-ын ҮХШ-ээс хууль хэрэглэх болон хууль бүтээх хэлбэрийн байгууллагын хувьд оросын үндсэн хуульт ёсыг бодитоор хөгжүүлж баталгаажуулахад идэхтэй нөлөө үзүүлж байна. Энэ утгаар *ОХУ-ын ҮХШ нь нэгэнт бүрэлдэн тогтсон үндсэн хуульт ёсыг хадгалагч төдийгүй түүнийг өөрчлөгч нь юм*. Мөн утгаар *Үндсэн хуулийн шүүх* нь оросын загвар чиг үүргийн хувьд *шүүх гэхээс илүү*, үндсэн хуульт ёыг зөвхөн хамгаалах явдлаар хязгаарлагдахгүй.

Үндсэн хуулийн шүүн таслан ажиллагааны төрийн захирах эрч хүч, түүний хэм хэмжээний илэрхийлэл буюу ОХУ-ын ҮХШ-ийн эрх зүйн байр суурь нь тодорхой

хэрэг маргааныг хянан хэлэлцэж гаргасан шийдвэрт нь тодорхойлогдсон хэм хэмжээ онол зүйн үнэлэлт, дүгнэлт, заалтууд байх ба тэдгээр нь үндсэн хуульт ёсны бүх хэсэг бүлэгт нэвтрэн орж, идэвхтэй нөлөө үзүүлж байна.

Үндсэн хуулийн шүүн таслан ажиллагааны тусламжтайгаар үндсэн хуульт ёс нь өөрийн хөгжлийн түүхийн тодорхой өөрчлөлтүүдийг тусган улам идэвхжиж, үүний үр дүнд одоо байгаа (харилцааны бодит байдал) болон байвал зохих (үндсэн хуулийн хууль зүй) хоёр нь хоорондоо ойртож, *«амьд» үндсэн хуульт ёс* болон хувирч байна. Ийнхүү *үндсэн хуулийн шүүхт ёс* гэсэн улс төр-эрх зүйн цоо шинэ, олон талаараа цорын ганц гэж хэлж болох үзэгдэл бий болж, түүний үндсэн дээр үндсэн хуульт төрт ёсыг байгуулах боломж бүрдэж эхэллээ.

Мэдээж, уг бүлэг ойлголтын онолын үндэслэлийг гаргах янз бүрийн хандлага байх боловч тэр бүхний зайлшгүй гол үндэс нь *үндсэн хуульт ёсны тогтолцоо* гэсэн ойлголт байх ёстой. Түүнд иж бүрэн тохирох тодорхойлолтыг боловсруулах зорилгоор түүний утга агуулга, бүтэц, зарчим, шинж чанарын талаар удаан маргаж болно. Гэхдээ энэ бүхнээс үл хамааран, нийгэм төрд үндсэн хуульт ёс байхгүй бол юу болохыг бид бүгд сайн мэдэж байгаа. Үүнийг хууль зүйн мэдлэгийн түвшинд хүлээж авахаас өмнө Үнэн зөв, Шударга ёсны шаардлагын талаарх итгэл үнэмшил, зан заншил, уламжлал, ёс зүй, зан суртахуун зэргийн дарах хувийн жин асар өндөр юм. Энэ талаар номлогч Павелын хэлсэнчлэн, хэн ч өөрийн амьдралд яах ёстойгоо мэдээгүй гэж өөрийгөө зөвтгөж болохгүй, учир нь ёс зүйн хууль хүн бүрийн зүрхэнд бичигдсэн байдаг ба хүмүүс «хуульгүй байсан ч байгалиас хууль ёсны зүйл үйлдэхээр заягдаж»: «хуулийн үйл хэрэг тэдний зүрхэнд бичигдсэн байдаг⁶» гэжээ.

⁶ Цит. по: Сорокин В.В. Совесть как элемент русского православного правосознания // Государство и право. 2011. № 6. - С. 23. Подробнее см.: Папаян Р.А. Христианские корни современного права. М.: Норма, 2002.

Үндсэн хуульт ёс⁷ гэх ойлголтын тодорхойлолтод олон янзаар хандах боловч түүний хууль зүйн болон улс төр-эрх зүйн бүлэг талаас нь уламжлалт байдлаар судлан шинжлэх нь хангалтгүй юм. Энэ бол эрх зүйн философийн түгээмэл бүлэг зүйлсийн нэг учраас түүнийг зөвхөн хуульчдын золиосонд өгөх ёсгүй. Үндсэн хуульт ёс нь орчин үеийн соёл иргэншлийн нэн чухал (түгээмэл) үнэт зүйлсийн тусгал болж, нийгэм төрийн ардчилсан зохион байгуулалтын зүй тогтол болох *гурвын нэгдэл* буюу үндсэн хуулийн хэмжүүрийн үндэс, үндсэн хуульт үндэсний тогтолцооны нүүр царайг тодорхойлогч *эрх мэдэл, өмчлөл, эрх чөлөө* зэрэгт үндэслэн төвлөрсөн чанартай байдаг. Эдгээрийн хооронд эрх зүйг дээдлэх журмаар тэнцвэрт байдлыг хангах нь суурь үндэс бөгөөд орчин үеийн үндсэн хуульт ёсны агуулгын (хэм хэмжээний, онол зүйн, ертөнцийг үзэх үзлийн г.м.) шинж чанарыг тодорхойлох тул уг бүлэг зүйлийг судлан шинжлэхэд иж бүрнээр, олон үе шаттайгаар хандах шаардлагатай.

Үндсэн хуульт ёсыг гагцхүү төрийн үр дагавар, зөвхөн төрийн хяналт дор байдаг мэтээр үзэж болохгүй, төр нь өөрийн хуулиар өөрийн хүсэмжилсэн үндсэн хуульт ёсыг «үүсгэн байгуулах», «тогтоох», «хуульчлан зарлах» зэргээр бий болгож чадах ч үгүй, тийм боломж ч байхгүй, төр нь үндсэн хуульт ёсыг өөрийн зорилгод нийцсэн чиглэлээр тогтоож хөгжүүлэхийн тулд шаардлагатай хүчин чармайлт гаргах нь мэдээж. *Үндсэн хуульт ёс нь нийгмийн бодит харилцаанаас бүрэлдэн тогтдог журам* бөгөөд шударга ёс, эрх чөлөө, хариуцлагатай байх, дураар авирлаж хүч хэрэглэхийг үл тэвчих зэрэг нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн дээд үнэт зүйлс, ёс зүй-зан суртахууны шаардлагад үндэслэсэн байдаг. Ингэснээр, үндсэн хуульт ёсыг бүрдүүлж буй харилцаа нь хууль зүйн мөн чанарын

⁷ См. об этом: Арутюнян Г.Г. Конституционализм: уроки, вызовы, гарантии. Сб. избр. публ. и выступлений на международ. Форумах, посвящ. дан. проблематике. К.: Логос, 2011; Берман Г.Дж. Западная традиция права: эпоха формирования. - М., 1998; Кравец И.А. Российский конституционализм: проблемы становления, развития и осуществления. - СПб., 2004; Кутафин О.Е. Российский конституционализм. - М., 2008; Шайо А. Самоограничение власти (краткий курс конституционализма). - М., 1999.

төдийгүй зан суртахууны үнэт зүйлсийн шаардлагын дагуу иргэн, албан тушаалтан, төрийн байгууллага, төрөөс дагаж мөрдөх зан үйлийн тодорхой шаардлагууд, хэм хэмжээний загваруудыг өөртөө агуулах чадвартай байна. Үүнийг одоо санал болгож буй үндсэн хуульт ёсны үзэл баримтлалд базсан байдлаар тусгасан ба түүний гол үндсэн мөн чанар нь, нэг талаар, Үндсэн хуулийн агуулгын шинж чанараас, нөгөө талаар, шүүх эрх мэдлийн үндсэн хуулийн зорилго, ялангуяа үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны зорилгоос урган гарч байна⁸.

Үндсэн хуулийн ач холбогдол бүхий асуудлуудыг шийдвэрлэхэд шүүх эрхийн мэдлийн оролцоо шаардлага нь объектив шинжтэй бөгөөд шүүх эрх мэдлийг үндсэн хуульт байгууламжийн үндсэн чанарын нэг хэмээн хүлээн зөвшөөрсөн манай нөхцөлд ОХУ-ын Үндсэн хуулийг дээдлэх, түүний шууд үйлчлэлийг хангах үүрэг түүнд ногдож, үндэсний болон гадны улс орны практикаар батлагдаж байна.

Орос улсын хувьд үндсэн хуулийн, ерөнхий шүүх цаазын, арбитрын зэрэг шүүх эрх мэдлийн бүхий л тогтолцооны тухай яригдах юм. Шүүхийн практик нь үндсэн хуульт ёсны хууль хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд үндсэн хуульт ёсны хэм хэмжээний агуулга, ертөнцийг үзэх үзэл, нийгмийн философийн үндсэн системд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна. Ерөнхий эрх зүйн тогтолцоотой болон Ром-германы (эх газрын) эрх зүйн тогтолцоотой улс оронд шүүх эрх мэдэл нь шүүхэд харъяалах хэргийн хүрээнд нийгмийн харилцааг үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын утга санааг жишиг утгаар ойлгож, ингэснээр түүнийг улам тодорхой болгон хөгжүүлэх; салбар эрх зүйн үндсэн хуулийн ач холбогдол бүхий ерөнхий үндсүүд (зарчмууд)-ийг илрүүлж, тэдгээрийг үндэслэлтэй, ойлгомжтой, тодорхой болгох; эрх зүйн системээс хуулийн шаардлагад нийцэхгүй, тэр тусмаа үндсэн хуульд харш хэм хэмжээний актуудыг шүүхэд

⁸ Подробнее см.: Бондарь Н.С. Судебный конституционализм в России в свете конституционного правосудия. М.: Норма. 2011.

харъяалагдах хэргийн төрлөөр ялгаварлан арилгахад нөлөөлдөг юм. Энэ үүднээс ОХУ-ын Дээд Шүүх, ОХУ-ын Арбитрын Дээд Шүүхээс гаргадаг шүүхийн практикийн асуудлын талаарх тайлбарууд (ОХУ-ын Үндсэн хуулийн 126, 127-р зүйл) чухал ач холбогдолтой бөгөөд хууль тогтоомжийн хэм хэмжээг шүүхээс нэг мөр тайлбарлан, хэрэглэх явдлыг хангаж, эдгээр зорилтыг хэрэгжүүлэх явцад нийтийг зохицуулах шинжтэй эрх зүйн заалтуудыг боловсруулах тохиолдол ч цөөнгүй гардаг. Үүний хамт, ерөнхий шүүх цаазын эсхүл арбитрын шүүхээр тодорхой хэрэг хянан шийдвэрлэх явцад хэрэг шийдвэрлэхэд хэрэглэвэл зохих хууль нь ОХУ-ын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар эргэлзээ төрвөл ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд асуулга явуулах үүрэгтэй байна⁹. Үүнээс үзэхэд, үндсэн хуулийн ач холбогдол бүхий асуудлыг шийдвэрлэхэд үндсэн хуулийн шүүн таслах байгууллага онцгой үүрэг хүлээж, ОХУ-ын Үндсэн хуулийг эрх зүйн талаас нь хамгаалах тусгай хэрэгсэл нь болдог.

Өнөөдрийн байдлаар үндсэн хуулийн хэм хэмжээний хяналт тавих Кельзены (эх газрын) загварыг сонгосон улс орнуудын хувьд үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааг дээрх утгаар ойлгож бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаа. Учир нь, Европын үндсэн хуулийн шүүхүүдийн XIV Конгрессын Бага хурал (Вильнюс хот, 2008 оны 6-р сарын 3-6)-ын Ерөнхий илтгэлд дурдсанаар «үндсэн хуулийн ердийн эрх зүйн актуудын зөрчлийг магадлах эрх үүрэг бүхий үндсэн хуулийн хяналтын байгууллага үгүй бол үндсэн хууль нь *lex imperfecta* мөн. Ердийн хуулийг үндсэн хуульд харшилж буйг тогтоох чадвар бүхий үндсэн хуулийн шүүх байгаа тохиолдолд үндсэн хууль нь *lex perfecta* болно ...Гагцхүү идэвхтэй байр суурьтай үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийг дээдлэх зарчмыг төсөөллөөр бус, бодитоор хэрэгжүүлэх явдлыг хангана ... Үндсэн хуулийг дээдлэх зарчмыг хангах нь үндсэн хуулийн шүүхийн үндсэн гол үүрэг байна. Үндсэн хууль нь эрх зүйн актын хувьд үндсэн хуулийн хяналтаар дамжиж «амьд»

⁹ См.: Постановление КС РФ от 16 июня 1998 года №19-П // СЗ РФ. 1998. №25. Ст.3004.

эрх зүй болон хувирах»¹⁰ ба нэмж хэлэхэд, үндсэн хуульт ёс нь «амьд» үндсэн хуульт ёс болж чадна.

Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны практик нь Үндсэн хуулийн нийгмийн гол утга, хууль зүйн мөн чанарыг бодитой болгож, түүний хууль зүйн дээд хүчин чадал бүхий шууд үйлчлэх эрх зүйн акт бөгөөд нийгмийн зөрчилдөөний үүсэл, тусгал, шийдвэрлэх иж бүрэн хэрэгсэл мөн болохыг харуулдаг. Энэ үүднээс, ОХУ-ын ҮХШ-ийг байгуулсан явдал нь Орос улсад үндсэн хуульт ёсыг тунхаглах бус, харин «амьд», бодит байдлаар тогтоох чухал нөхцлийн нэг гэж үзэх боломжтой боллоо. Ингэснээр, ОХУ-ын ҮХШ нь үндсэн хуулийн бодит ба хууль зүйн салшгүй байдлын баталгаа болж, үндсэн хуулийн орон зайд жинхэнэ байгаа ба байвал зохих хоёрын нэгдлийг хангаж өгдөг.

Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагаа нь үндсэн хуулийн хяналтын тусгай институцээс гадна шүүх эрх мэдлийн институцийн шинжийг агуулж байдаг учир үндсэн хуульт ёсны материаллаг зохион байгуулалт, тусгай зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ОХУ-ын ҮХШ-ийг байгуулсан нь үндсэн хуульт ёсны чанарын цоо шинэ хэлбэр болох үндсэн хуулийн шүүхт ёсыг бүрэлдүүлэхэд шийдвэрлэх алхам болсон. Үүнээс үндэслэн, үндсэн хуулийн шүүхт ёс, түүний үүсч хөгжих явцад хэд хэдэн зүйлийг анхааран үзэх нь чухал юм

Нэгдүгээрт, ОХУ-ын ҮХШ-ийн шийдвэрүүд нь хэм хэмжээ тогтоох онцгой шинжийн актын төрөл болохоос гадна үндсэн хуулийн шүүхт ёс, оросын үндсэн хуульт ёсны бүхий л системийг бүрдүүлэх эрх зүйн хэм хэмжээний үндэс нь болдог. Үүгээр үндсэн хуулийн шүүхт ёсны эрх зүйн хэм хэмжээний бүрэлдэхүүний мөн чанар, зориулалт тодрон гарч, ингэхдээ позитивист болон байгалийн эрх зүйн хандлагыг хослуулан хэрэглэдэг бөгөөд үндсэн

этих ценностей. Вместе с тем при всем том, что имеется немало научных разработок, например, о соотношении права и нравственности, вопрос о конкретных механизмах и самой практике включения духовно-нравственных, социокультурных ценностей в систему конституционализма, в том числе с помощью конституционно-судебного инструментария, остается весьма актуальным. Пока, надо признать, имеют место лишь отдельные и довольно робкие попытки позитивной юридизации нравственных начал, их правового обеспечения как необходимых регуляторов практической жизни.

В-третьих, судебный конституционализм есть материализация конституционно-судебной практики, реального воплощения в жизнь требований верховенства Конституции, ее прямого действия, материализация конституционных ценностей в обществе и государстве. Это, своего рода, *онтологический компонент судебного конституционализма*. Очевидно, что именно на этом уровне, в практической сфере реализации Конституции и законодательства, особенно остро проявляется нравственный кризис современного конституционализма, имея в виду, в частности, что в профессиональном правосознании безраздельно господствует юридический позитивизм. Ему может быть противопоставлена конституционная максима, адресованная всем правоприменителям, включая носителей законодательной, исполнительной, судебной власти: *несправедливое решение не может быть конституционным*.

Наконец, *в-четвертых*, КС РФ – генератор конституционной идеологии, творец новой конституционной культуры, конституционного мировоззрения личности и общества. В этом состоит *идеологический компонент судебного конституционализма*, имея в виду, что категория судебного конституционализма воплощает в себе

характеристики одной из форм *общественного сознания*, которая отражает единство конституционной психологии и конституционной идеологии и, в свою очередь, выступает важным инструментом формирования нового типа юридического видения действительности – *конституционного мировоззрения*. В частности, он организует и структурирует общественное и индивидуальное правосознание, правовую философию.

Творчески-преобразовательная функция конституционного правосудия обеспечивается с помощью различных способов судебного нормоконтроля в рамках определенных Конституцией полномочий КС РФ. Это, прежде всего, *толкование норм Конституции РФ* как форма ее преобразования без изменения буквы правотолковательной нормы. С помощью официального толкования Конституции обеспечивается не только государственно-правовая (конституционная) оценка соответствующих сфер социальной действительности, но и уточняюще-разъясняющее развитие содержания конституционных норм и одновременно этим придаются дополнительные импульсы конституционному обоснованию отраслевого законодательства, конкретизирующего данные конституционные нормы и институты. Очевидно, что соответствующие решения КС РФ должны вытекать не из политической конъюнктуры, а из требований самой Конституции как «метарправового» документа. Толкуя Конституцию, Суд осуществляет по сути нормативно-доктринальную, квазиправотворческую функцию, когда принимаемые им решения становятся в этом случае частью Конституции, сопоставимы с ней по юридической силе.

Преобразование конституционных отношений осуществляется также посредством *разрешения конституционно-правовых споров*. Их разрешение - формулирование итогового вывода о конституционности или неконституционности оспариваемого законоположения - требует выявления смысла и

существа конституционно-правового подхода к данному вопросу, в том числе в системе действующего правового регулирования. Закономерным результатом такой конституционно-судебной деятельности является уяснение и истолкование прямых и обратных связей между положениями Конституции и текущим законодательством, их синхронизация в соответствии с требованиями иерархичности правовой системы, с одной стороны, и обогащение, наращивание нормативного потенциала конституционных принципов и норм - с другой.

Важным способом конституционно-судебного преобразования конституционного регулирования и конституционных отношений является, как отмечалось, *конституционное истолкование правовых норм отраслевого законодательства*. Это особая форма квазиправотворческой деятельности, предполагающая наращивание нормативной энергии положений отраслевых законов за счет конституционных принципов и ценностей, на соответствие которым были подвергнуты проверяемые нормы текущего законодательства.

Выработка КС РФ на основе разрешенных конкретных дел *рекомендаций законодателю по совершенствованию правового регулирования* также является способом развития конституционных институтов российской государственности посредством конституционного правосудия. Это вытекает из самой природы, особенностей юридической силы таких рекомендаций. Рекомендации законодателю, выработанные КС РФ на основе разрешенных конкретных дел, не имея непосредственно обязывающего значения для нормотворческих органов, ориентируют их на последовательную и систематическую реализацию конституционных принципов и норм в текущем законодательстве. Следовательно, непринятие во внимание, а тем более игнорирование законодателем соответствующих рекомендаций может привести к противоречивости и рассогласованности законодательства в его сопоставлении с Конституцией РФ

и тем самым создать угрозу нарушения конституционных прав и свобод человека и гражданина, публичных интересов и ценностей.

Судебный конституционализм обеспечивает, таким образом, последовательную гармонизацию буквы и духа Конституции, приведение ее формально-юридического содержания в соответствие с «социальной нормативностью», в основе которой - реальные отношения политического властвования, экономической и социальной организации общества и государства. Тем самым охрана Конституции, ее стабильность поддерживаются в сочетании с динамизмом конституционной системы как живого организма.

Достижение этих целей обеспечивается, в том числе, посредством *обогащения с помощью практики КС РФ нормативных источников российского конституционализма*. В частности, КС РФ признает существование так называемых *неформальных источников права*, которые существенным образом обогащают нормативно-правовую основу современного конституционализма, придают ему качества судебного конституционализма.

В этом плане КС РФ, *во-первых*, активно оперирует при осуществлении конституционного контроля *общими принципами права и правовыми принципами*, ссылаясь на них как на критерий оценки конституционности норм законов. Эти принципы, по мнению КС РФ, обладают высшей степенью нормативной обобщенности, предопределяют содержание конституционных прав человека, отраслевых прав граждан, носят универсальный характер и оказывают регулирующее воздействие на все сферы общественных отношений; общеобязательность таких принципов состоит как в приоритетности перед иными правовыми установлениями, так и в распространении их действия на все субъекты права. Поэтому действия законодателя, правоприменителя и иных субъектов права

не должны вступать в противоречие не только с *буквой*, но с *духом* Конституции РФ и содержащимися в ней принципами, включая принципы правового государства, справедливости, баланса частных и публичных интересов и т.д.¹¹ *Во-вторых*, КС РФ способствует проникновению в национальную правовую систему России (как страны континентального права) *прецедентных начал*. Так, в постановлении от 21 января 2010 г. № 1-ПКС РФ обосновал по сути прецедентный (нормативно значимый) характер некоторых решений Высшего Арбитражного Суда РФ¹² (а соответственно, и аналогичных решений Верховного Суда РФ, поскольку конституционно-правовой статус этих органов государственной власти в сущности идентичен). Хотя научно-экспертные оценки этого решения КС РФ различны, нельзя не признать: оно, безусловно, придает новый и весьма существенный импульс движению российской правовой системы в сторону развития и усиления в ней прецедентных начал.

В-третьих, внедрение в российскую правовую систему посредством решений КС РФ *норм международного права*. Анализ практики КС РФ свидетельствует о весьма широком применении им различных международных правовых актов. Тем самым Суд придает соответствующим международным документам дополнительную нормативно-доктринальную энергию конституционно-правовых аргументов, упрочивает их значимость в национальной правовой системе и ориентирует как законодательные, так и правоприменительные органы на неукоснительное выполнение ими принятых на себя Российской Федерацией международно-правовых обязательств.

В-четвертых, внедрение в российскую правовую систему *наднациональной судебной практики* и прежде всего практики Европейского Суда по правам человека.

¹¹ См.: Постановление КС РФ от 27 января 1993 года №1-П // СЗ РФ. 1993. №14. Ст.508; Постановление КС РФ от 21 декабря 2005 года №13-П // СЗ РФ. 2006. №3. Ст.336; Определение КС РФ от 27 декабря 2005 года №503-О // СЗ РФ. 2006. №8. Ст.945.

¹² СЗ РФ. 2010. № 6. Ст. 699.

Речь в данном случае идет не только об использовании прецедентной практики Европейского Суда для целей конституционного судопроизводства, но и об обосновании общеправового значения решений органа европейского конвенционного контроля для национальной правовой системы¹³.

Важным инструментом успешного осуществления Конституционным Судом России своих функций является подход, реализуемый на основе сочетания национальных и наднациональных (международных) механизмов защиты ценностей современного конституционализма.

3. Судебный конституционализм в контексте национальной и международной конституционной юрисдикций.

Важно учитывать, что концепция судебного конституционализма находится в известной корреляции с требованиями норм международного права, включая прецедентную практику Европейского Суда по правам человека. В своих решениях ЕСПЧ не раз обращал внимание, например, на то, что существует множество различий, *inter alia*, в историческом развитии, культурных особенностях и политических взглядах среди европейских государств, в силу чего каждая Договаривающаяся Сторона вправе сама формировать свое видение демократии¹⁴. Поэтому принцип учета социально-культурных особенностей не является отрицанием того обстоятельства, что сами по себе социально-культурные факторы испытывают на себе влияние как внутригосударственного, так и наднационального права, имея в виду, в частности, что общепризнанные принципы и нормы международного права и международные

¹³ См.: Постановление КС РФ от 5 февраля 2007 г. № 2-П; Постановление КС РФ от 26 февраля 2010 г. № 4-П.

¹⁴ См.: Постановление Европейского Суда по правам человека по делу «Херст против Соединенного Королевства» от 6 октября 2005 г. // СПС «КонсультантПлюс»; Постановление Европейского Суда по правам человека по делу «Жданок против Латвии» от 16 марта 2006 г. // СПС «КонсультантПлюс»; Постановление Европейского Суда по правам человека по делу «Краснов и Скура-тов против Российской Федерации» от 19 июля 2007 г. // Бюллетень Европейского Суда по правам человека. Российское издание. 2008. № 4. С. 115—132.

договоры Российской Федерации являются составной частью ее правовой системы (ч.4 ст.15 Конституции РФ).

В условиях правовой глобализации взаимное влияние международного и национального права, национальной и международной юрисдикций судебных органов приобретает все более глубокие последствия. В рамках европейского правового пространства это приобретает актуальность, прежде всего, в *аспекте соотношения национальной конституционной и конвенционной юрисдикций.*

При всей широте практической проблематики ЕСПЧ следует признать, что наиболее чувствительный ее сегмент связан с объектами европейского конвенционного контроля (с точки зрения возможности отнесения к ним норм внутригосударственного права), а также последствиями принятия Европейским Судом решений о нарушении Европейской Конвенции и, в частности, значением такого рода решений для национальных систем, в том числе для конституционных судов. Именно на этой основе, посредством унификации нормативных и правоприменительных критериев прав человека для всех стран – членов Совета Европы, становится возможным *формирование пространства европейского конституционализма.*

Это - сложный, весьма противоречивый процесс. В обобщенном виде он может быть представлен в таких аспектах и проявлениях, как: а) институциональном, правотворческом, состоящем в сближении национальных правовых систем Европы; б) правореализационном, где особое значение имеет функционирование наднациональных юрисдикционных органов по защите общепризнанных (европейских) конституционных ценностей (это в первую очередь ЕСПЧ); в) конституционализации общепризнанных принципов и норм международного права и на этой основе – проникновение внутригосударственных юридико-правовых (конституционных) начал в сферу

международных отношений европейских государств; г) в аспекте утверждения новой правовой идеологии, нового типа правосознания и правовой культуры, что проявляется в том числе в унификации правовых ценностей и сближении фундаментальных характеристик национальных правовых культур.

Теория европейского конституционализма пока не выработала универсальных подходов к пробелам формирования единого европейского нормативно-правового конституционного пространства. Оно формируется, в частности, на основе конвенционного регулирования, с одной стороны, и национального конституционного законодательства, с другой, в тесном взаимодействии судебного конвенционного и национального конституционного правосудия. Отсюда ясно, что начала судебного конституционализма приобретают межгосударственный, международно-правовой характер. Соответственно, дальнейшая разработка концепции и конкретных проблем судебного конституционализма – важная задача современной конституционно-правовой науки.

Не будет преувеличением утверждение о том, что обсуждение весьма сходных для наших стран проблем, решаемых национальными средствами конституционного правосудия, является важным вкладом в развитие и укрепление единых для нас подходов к пониманию и судебной защите ценностей современного конституционализма. Новые политические и правовые реалии, углубляющиеся процессы глобализации, наверняка, потребуют от нас еще более тесного сотрудничества. Нет сомнения, что нынешний международный симпозиум, посвященный 20-ой годовщине основания Конституционного Суда Монголии, внесет свой вклад в обсуждение и поиск решений соответствующих задач на основе взаимопонимания между органами конституционной юстиции наших государств.

Доктор В.А.Сивицкий
ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн
Тамгын газрын орлогч дарга

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ ШИНЖ ЧАНАР: ОХУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУРШЛАГА

1. Үндсэн хуулийн шүүн таслах байгууллага «пост социалист» орнуудад байгуулагдсан цагаас хойш энэ байгууллага эрх зүй бүтээх чиг үүрэг гүйцэтгэдэг эсэх нь эрх зүйн онол болон үндсэн хуулийн эрх зүйн салбарт хурц маргаан үүсгэсэн асуудлуудын нэг болж байна. Бидний мэдэж байгаагаар үндсэн хуулийн шүүн таслах мэргэшсэн тусгай байгууллага аль хэдийнээс оршин тогтнож буй бусад орнуудад ч үүнтэй ижил сэдвээр шинжлэх ухааны хэлэлцүүлэг явагдсаар ирсэн. Эрдэмтдийн зарим нь үндсэн хуулийн шүүхийн эрх зүй бүтээх чиг үүргийг хүлээн зөвшөөрдөг бол нөгөө хэсэг нь түүнд шүүмжлэлтэй ханддаг. Миний бодлоор энэ нь мөнхийн бөгөөд үл таслагдах маргаан гэж хэлж болно.

Үндсэн хуулийн шүүн таслах байгууллагын үйл ажиллагаанд хэдийгээр адил зүйлийг харж байгаа боловч өөр өөрөөр үнэлж дүгнэдэг учраас энэ хоёр талын байр суурийг шинжлэх ухааны өвөрмөц итгэл үнэмшил, эрх зүйн үзэл сурталд хамааруулж болох юм. Уг асуудлаар явагдах ямар ч хэлэлцүүлэг энэ маргаанд цэг тавьж чадах нь эргэлзээтэй. Иймээс илтгэлдээ эрх зүй бүтээх үйл явц болон үүнтэй уялдаатай онолын зарим үзэл санаанд тулгуурлан ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны туршлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудлыг хөндөж тавих зорилго тавьсан болно. Үүний зэрэгцээ цаг хязгаартай учраас хэм хэмжээ тогтоох мөн чанар нь онолын үүднээс илүү хүлээн зөвшөөрөгддөг ОХУ-ын Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ, мөн түүнчлэн «ОХУ-ын

Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн байр суурь»-ийн тухай номлол буюу өөрөөр хэлбэл эрх зүйн тодорхой асуудлаар Үндсэн хуулийн шүүхээс хийж буй, шийдвэрт нь тусгалаа олдог харьцангуй бүрэн дүүрэн дүгнэлтийн талаар зөвхөн цухас дурдах боломжтой байна. «Эрх зүйн байр суурь» гэж хэм хэмжээ тогтоосон акт үндсэн хуульд нийцсэн эсэх талаархи хэргийг хэлэлцэх, эсхүл өргөдөл, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх зэрэг тодорхой асуудалтай холбоотойгоор Үндсэн хуульд хийж буй албан ёсны тайлбарыг ойлгох ба зарим тохиолдолд «ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай» Холбооны хуулийн хэм хэмжээг албан ёсоор тайлбарласан тайлбар мөн ийм шинж чанарыг агуулдаг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн (зөвхөн хэргийн талаар гаргаж буй шийдвэрүүдийн ч биш) тогтоох хэсгээр хязгаарлагдахгүй мөн үндэслэх хэсэгт агуулагдаж буй «эрх зүйн байр суурь» нь нийт хууль хэрэглэгчдийн хувьд заавал дагаж мөрдөх шинжтэй нь Үндсэн хуулийн шүүхийн номлолоор хүлээн зөвшөөрөгдсөн нь онцгой ач холбогдолтой юм.

2. Хэргийг хянан хэлэлцээд гаргаж буй шийдвэрийн дүгнэх хэсгийн талаар эхлээд авч үзье. Үндсэн хуулийн шүүхийн практикт хэм хэмжээг бүрэн дүүрэн, эргэлт буцалтгүйгээр үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоосон шийдвэр гаргасан тохиолдол бараг байхгүйд юуны өмнө анхаарлаа хандуулах нь зүйтэй. Ийм хандлага зарчмын хувьд үргэлж байсаар байсан. Харин одоо бол хэм хэмжээг бүрэн хэмжээгээр үндсэн хуулийн биш гэж үзсэн шийдвэрийг ер нь олж харахгүй.

Хэм хэмжээг шалгах явцад түүний бий болгосон эрх зүйн механизм нь үндсэн хуулийн үзэл санааны үүднээс ердийн биш тохиолдолд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн практикт шийдвэрийн дүгнэх хэсгийг томъёолох хоёр хувилбар байдаг.

Эхний хувилбар – хэм хэмжээ зарим хэсгээрээ, зарим утгаар гэх зэргээр үндсэн хуульд нийцэхгүй байгааг хүлээн зөвшөөрнө. Эрх зүйн хэм хэмжээний акт хууль

зүйн хүчин чадлаа алдсаныг хүлээн зөвшөөрсөн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарснаар уг акт хэм хэмжээний эрх зүйн актаас шууд хасагдах ёстой гэсэн хэрэг биш нь мэдээж. Үндсэн хуулийн шүүх тухайн актын үйлчлэх хүрээг тодорхойлох боломжтой. Үүний анхны тодорхой жишээний нэг нь ЗСБНХУ-ын 1989 оны 10-р сарын 9-ний өдрийн «Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх журмын тухай» хуулийн 12-р зүйл үндсэн хуульд нийцсэн эсэхийг хэлэлцээд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс гаргасан тогтоол бөгөөд уг тогтоолын дүгнэх хэсгийн 1-д, дээр дурдсан хуулийн 12-р зүйлийн нэгдүгээр хэсгийн иргэний агаарын тээврийн байгууллага, үйлдвэрийн газарт ажил хаяхыг хориглосон заалт нь үндсэн хуулиар тогтоосон нийгмийн тогтолцоо, ёс суртахууны үндэс, бусдын эрүүл мэнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, улсыг батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангах зорилгоор ОХУ-ын Үндсэн хуулийн 55-р зүйл (3 дахь хэсэг)-ийн дагуу зарим ажилтны ажил хаях эрхийг хязгаарлаж болно гэсэн хүрээнд ОХУ-ын Үндсэн хуульд нийцэж байгааг тодорхойлж өгсөн. Өөрөөр хэлбэл «заасан тэр хэмжээний хүрээнд» гэсэн бүтцийг энд ашигласан байна. Хэм хэмжээ үндсэн хуульд нийцэхгүй байгааг хүлээн зөвшөөрөх хүрээг дээд зэргээр хязгаарлаж өгөх өөр бүтцүүд ч бас бий. Үндсэн хуулийн шүүхэд хэм хэмжээний үйлчлэлийг хадгалах хязгаарыг тодорхойлох боломж байгаа болно.

3. Ихэвчлэн энэ байдалтай холбоотойгоор Үндсэн хуулийн шүүх эрх зүй бүтээх чиг үүрэг гүйцэтгэдэг тухай асуудал яригддаг. Мөн энэ шалтгаанаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн мөн чанарын талаар хууль зүйн бүтээлд сүүлийн үед «ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь шүүхээс илүү том зүйл»¹ гэсэн тод дүрслэл бүхий эргэцүүлэл гарч ирсэн. Энэ бодол санаа Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэж буй чухамхүү эрх зүй бүтээх чиг үүрэг дээр нь тулгуурлаж байна. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн шүүхийн «эрх зүй бүтээх сонгодог биш, онцлог өвөрмөц» байдлыг, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн шүүхийн үйл

¹ Н.С.Бондарь, Судебный конституционализм в России. М., 2011. С. 87, 100.

ажиллагаанд бодитой байр эзэлж байгаа эрх зүй бүтээх явц нь «хэм хэмжээний шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийн онцлог шинж чанартай²» уялдан бий болсныг илүү онцлон тэмдэглэдэг.

Үүнтэй уялдуулан шалгагдаж буй хэм хэмжээ шалгуур болж буй хэм хэмжээтэй зөрчилдсөн тохиолдолд шүүх яаж ажиллавал илүү зөв зохистой вэ? гэсэн асуултыг хэм хэмжээний шүүхийн хяналтыг үзэгдлийнх нь хувьд бүхэлд нь хамруулан хийсвэр-онолын үүднээс авч үзэцгээе. Ажлын чанарыг ямар шалгуураар хэмжих вэ? Энд мэс засал хийж хавдар авч байгаа эмчтэй зүйрлэх санаа өөрийн эрхгүй төрнө: мэс засал хийхэд нэг талаас хавдрын өчүүхэн төдий хэсгийг ч орхихгүй авах ёстойн зэрэгцээ эрхтэний эрүүл хэсгийг хэвийн ажиллаж байхаар хадгалж үлдээх шаардлагатай. Хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх явцад яг ийм байдлаар нарийн хандаж эрх зүйн тогтолцооноос зохицуулалтын дутагдал доголдлыг нь зайлуулах ёстой байдаг. Шүүх байвал зохих зүйлийг нь «дарж хаяад», дутагдал доголдолтой боловч бүхэлдээ эрүүлд тооцогдон эрх зүйн харилцааны оролцогчдод хэрэг болж байгаа тогтолцоог «огтлон авах» боломжгүй юм. Хэм хэмжээг хүчин төгөлдөр бус эсхүл бүхэлдээ үйлчлэх боломжгүй хэмээн ямар нэг орлуулах зүйлгүйгээр шууд хүлээн зөвшөөрөх нь шүүхийн зүгээс хэрэгжүүлэх хэм хэмжээний хяналтын чанарыг жинхэнэ хэрэгтээ хангаж өгөх хэрэгсэл болсон Үндсэн хуулийн шүүхийн «хэм хэмжээг бодитоор бүтээх явцтай» харьцуулахад эрх зүйн тогтолцооны чанар болон цэвэр байдалд илүү их хор уршиг тарина.

Ерөнхийд нь хэлэхэд хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлж буй аливаа шүүх ингэж ажиллах ёстой. Оросын хууль тогтоогч – хяналтын зүйл, хүрээ ба шүүхийн өмнөх шатны зарим онцлог энд хамаарахгүй – Үндсэн хуулийн шүүхийн хэм хэмжээний хяналт ба тухайн орон нутагт үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээний актын хувьд жишээлбэл, дүүргийн шүүхээс хэрэгжүүлэх хэм

² Там же. С. 99 – 100.

хэмжээний хяналтыг адил байдлаар зохицуулж өгсөн нь анхаарал татаж байна.

Тухайлбал, ОХУ-ын ИХШХШТ төрөлжсөн хуулийн 253-р зүйлд заасны дагуу маргаж буй эрх зүйн акт нь холбооны хууль, хууль зүйн хувьд илүү хүчин чадалтай бусад акттай зөрчилдөөгүйг тогтоосноор шүүх уг нэхэмжлэлийг хангахаас татгалзсан шийдвэр гаргана (нэгдүгээр хэсэг); маргаж буй эрх зүйн акт, актын зарим хэсэг холбооны хууль, хууль зүйн хувьд илүү хүчин чадалтай бусад акттай зөрчилдөж байгааг тогтоовол шүүх түүнийг бүхэлд нь, эсхүл тухайн хэсгийг акт батлагдан гарсан өдрөөс, эсхүл шүүхээс тогтоосон өдрөөс эхлэн хүчингүйд тооцно (хоёрдугаар хэсэг); хэм хэмжээний актыг бүхэлд нь эсхүл түүний хэсгийг ийнхүү хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр гарснаар тухайн акт, түүний холбогдох хэсэг, мөн түүнчлэн тэдгээрийг үндэслэн гаргасан болон иш татсан эрх зүйн бусад акт хүчин төгөлдөр бус болно (гуравдугаар хэсэг); эрх зүйн хэм хэмжээний тухайн актын хүчингүй болохыг хүлээн зөвшөөрсөн шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд дахин ийм акт гаргах боломжгүй (дөрөвдүгээр хэсэг). Хэрвээ бид эдгээр хэсгийн заалтыг хуулийн 87, 100 (хэм хэмжээний хяналт тавьснаар Үндсэн хуулийн шүүхээс гаргах шийдвэрийн хувилбаруудыг заасан) болон 79-р (ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлын тухай) зүйлүүдтэй харьцуулан авч үзвэл шүүхийн холбогдох үйл ажиллагааг огт өөрөөр тодорхойлох боломжийг олгосон чанарын, гүнзгий ялгаа эрх зүйн зохицуулалтын түвшинд байхгүй байгааг харж байна.

Үндсэн хуулийн шүүх хэм хэмжээг хүчин төгөлдөр бусад тооцдог, харин ердийн шүүх түүнийг хүчингүй болгодог нь эдгээр шүүхийн хэм хэмжээний хяналт ялгаатай гэдгийг батлах шалтаг биш юм.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүхийн, нутгийн удирдлагын байгууллагууд, үйлдвэр, албан газар,

албан тушаалтан, иргэн, тэдний нэгдэл заавал биелүүлэх талаархи ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 6-р зүйлийн заалт нь Үндсэн хуулийн шүүхийн хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрхийн зохицуулалтын «онцгой ялгаатайг» нь нотлох баримт бас болохгүй. Учир нь «ОХУ-ын шүүхийн байгууллагын тухай» хуулийн 6-р зүйлийн 1 дахь хэсэгт холбооны шүүх, ердийн шүүх болон шүүгчдийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, тогтоол, түүнчлэн захирамж, шаардлага, даалгавар, зарлан дуудах хуудас, бусад баримт бичгийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд, олон нийтийн нэгдлүүд, албан тушаалтнууд, иргэд, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй ба ОХУ-ын нутаг дэвсгэр дээр тэднийг заавал дагаж мөрдөх тухай заасан байдаг.

Гэхдээ амьдрал дээр нэлээд ялгаатай бүтээгдэхүүнүүд гарч ирдэг. Хэрвээ ердийн шүүх аливаа хэм хэмжээ, эсхүл акт бүхэлдээ хууль ёсны болох эсхүл түүнийг зөрчсөн тухай дүгнэлт хийдэг бол Үндсэн хуулийн шүүх тогтоолдоо өөрийн гэсэн бүтцийг ашигладаг нь уг шүүхийн шийдвэрээс түүний онцлог норматив шинжийг олж харах боломжтой болгож байна. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн «онцгой ялгаанаас» болж буй хэрэг биш гэдгийг дахин тэмдэглэж хэлье. Харин Үндсэн хуулийн шүүх бусдаас түрүүлж мэргэшин өөрийн гэсэн нөөцтэй болсноос гадна үйл ажиллагааны ийм аргачлалыг сонгосон зоримог алхам хийсэнд л учир нь байгаа юм.

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнгийн хоёр дахь хувилбар нь хэм хэмжээний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг гаргаж ирэх явдал болно. Хэм хэмжээний тодорхой хэсгийг үндсэн хуульд нийцээгүйг хүлээн зөвшөөрөх болон түүний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг илрүүлэн гаргах хоёрын хооронд зарчмын ялгаа байхгүй нь онол болон Үндсэн хуулийн шүүхийн практикаас харагддаг (үндсэн хуулийн эрх зүйн утга санааг илрүүлэх нь Үндсэн хуулийн шүүхийн төлөв түвшин байдлын илэрхийлэл болох ч). Үндсэн хуулийн шүүхээс удаа дараа

тэмдэглэсэнчлэн, хэм хэмжээний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг илрүүлэн тогтоосон ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор тухайн хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг дүгнэхэд саадгүй болж, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс тогтоосон үндсэн хуулийн эрх зүйн утга санаатай нь зөрчилдсөн байдлаар түүнийг хэрэглэх (мөн үйлчлэлийг нь зогсоох) боломжийг хаана; харин ОХУ-ын Үндсэн хуулийн 125-р зүйл (4 болон 6-р хэсэг) ба «ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай» холбооны хуулийн 79-р зүйлийн гурав дахь хэсгийг зөрчих нь хэм хэмжээг ОХУ-ын Үндсэн хуульд үл нийцсэн өмнөх утгаар нь хэрэглэх боломжийг олгосноор иргэдийн, түүний дотор өргөдөл гаргагчийн үндсэн хуулийн эрх зөрчигдөх үр дагаврыг бий болгоно; ингэснээр хэм хэмжээний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг тогтоож, түүнийг өөр утгаар тайлбарлах, ОХУ-ын Үндсэн хуульд нийцээгүйн улмаас иргэдийн үндсэн хуульд заасан эрхийг зөрчсөн байдлаар хэрэглэх бололцоог хаасан ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр «ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай» холбооны хуулийн 100-р зүйлийн 1 дэх хэсгийн 2,3-р заалтад дурдсан эрх бүхий байгууллага ердийн журмаар өргөдөл гаргагчийн хэргийг дахин хянан хэлэлцэх баталгааг нь хангасан хууль зүйн үр дагавартай болно (Үндсэн хуулийн шүүхийн 2010 оны 1-р сарын 21-ний өдрийн тогтоол N 1-П, 2010 оны 2-р сарын 26-ны өдрийн тогтоол N 4-П, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2008 оны 11-р сарын 11-ний өдрийн магадлал N 556-О-Р).

5. Үндсэн хуулийн шүүхийн тогтоолуудыг авч үзвэл үндсэн хуулийн утга санааг тогтоосон шийдвэрийн тоо багасч, маргаж буй үндэслэл нь үндсэн хуульд нийцээгүй болохыг тогтоосон шийдвэр олширч байна. 2011 онд маргаж буй үндэслэлийн зарим хэсэг эсхүл бүхэлдээ үндсэн хуульд нийцээгүйг тогтоосон шийдвэр 30-аас 16 (талаас илүү нь) болсон бол 2010 онд энэ тоо 22-оос 8 байжээ. Үлдсэн нь үндсэн хуулийн эрх зүйн утгыг тогтоосон шийдвэрүүд байсан болно. Гэхдээ ямар ч тохиолдолд,

Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан хэлэлцэгдсэний дараа тухайн хэм хэмжээ өмнөх байдлаараа – үндсэн хуульд нийцээгүй болохыг хүлээн зөвшөөрөх эсхүл түүний үндсэн хуулийн утга санааг гаргахгүйгээр – хэвээр үлдэх боломж маш бага гэдгийг энэ үзүүлэлт харуулж байна. Энэ нь мөн нэлээд түгээмэл тархсан «актын үндсэн хуульд нийцэх байдлын презумпци» гэсэн номлолд болгоомжтой хандах хэрэгтэйг харуулж байгаа юм.

Үндсэн хуульд нийцэх байдлын презумпцийг, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр батлагдан гарч буй хэм хэмжээний бүх актын заалтууд нь тухайн актыг хуулиар тогтоосон журам, хэлбэрийн дагуу шалгаад эсрэг байдлаар эргэж нотлох хүртэл Үндсэн хуульд нийцсэнд тооцогдох, эрх зүйн зохицуулалтын заавал биелэгдэх шинж, шатлалтай шууд уялдаатай таамаглал хэмээн тодорхойлж болно. Хэм хэмжээний актын үндсэн хуульд нийцэх байдлын презумпцийг заавал дагаж мөрдөх журмыг тогтоож буй хэм хэмжээний тогтолцоо гэсэн эрх зүйн өөрийнх нь тодорхойлолт дээр суурилсан “актын зөв байдал”-ын презумпцийн бүрэлдэхүүн хэсгээс гадна Үндсэн хуулийг дээдлэх зарчмын бүрэлдэхүүн хэсэгт тооцох ёстой. Доод түвшингийн акт дээгүүр хүчин чадал бүхий актад нийцсэнийг хүлээн зөвшөөрөхгүйгээр хуулийн хэм хэмжээ эрх зүйн өдөр тутмын амьдралд эрх зүйн тодорхой харилцаанд орж биеллээ олно гэж тооцож болохгүй.

Бүх төрлийн презумпцийн гол агуулга нь үүнээс эсрэгээр дүгнэлт хийх зарчмын боломжгүй байдалд биш харин зөвхөн тодорхой нөхцөл бүрдсэн үед түүнд хүрэх боломжтойд оршдог. Бидний авч үзэж байгаа тохиолдолд, маргаж буй тодорхой хэм хэмжээний үндсэн хуульд нийцэх байдлын презумпцийг няцаах гол арга хэрэгсэл бол ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх гэдгийг үндсэн хуулийн материйн онцлог өөрөө урьдчилан тогтоож өгсөн бөгөөд уг шүүх тухайн актын үндсэн хууль зөрчсөнийг эсхүл түүний үндсэн хуулийн эрх зүйн утга санаа нь практик дээр хэрэглэгдэж байгаагаас өөр, ялгаатай болохыг тодорхойлох боломжтой.

«ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай» холбооны хуулийн 36-р зүйлд зааснаар жишээлбэл, хууль, хэм хэмжээний бусад акт, төрийн байгууллага хоорондын гэрээ, хүчин төгөлдөр болоогүй байгаа олон улсын гэрээ ОХУ-ын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байх нь хэрэг хянан хэлэлцэх үндэслэл болдог. Хэрвээ хэм хэмжээний үндсэн хуульд нийцсэн эсэх талаар ямар нэг тодорхойгүй асуудал байхгүй бол энэ үндэслэлээр өргөдөл, мэдээллийг хүлээн авахаас татгалзах бөгөөд зөвхөн ийм асуудал байгаа бол түүнийг шалгахаар хүлээн авна. Өөрөөр хэлбэл хянан хэлэлцвэл зохих маргаантай асуудал эсэхийг нь тодорхойлох шүүлтүүр байдаг. Гэвч хэргийг хэлэлцэхээр хүлээн авсны дараа хэм хэмжээ үндсэн хуульд нийцсэн эсхүл нийцээгүйг хүлээн зөвшөөрсөн шийдвэрийн үр дагавар гэсэн өөр асуудал тулгарна. Асуудлыг шийдэх илүү хүмүүнлэг чиглэл нь хэдийгээр гайхмаар ч, хэм хэмжээ үндсэн хуульд нийцээгүйг хүлээн зөвшөөрсөн (эсхүл түүний үндсэн хуулийн утга санааг илрүүлэн тогтоох) шийдвэр гаргах явдал байдаг, учир нь ингэснээр хүний, иргэний эрхийг сэргээн тогтоох боломжийг нэмэгдүүлж, юуны өмнө маргааныг дахин хянан хэлэлцэх үндэслэлийг бий болгоно.

Хэрвээ хэргийг ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээр хянан хэлэлцэхэд хүрсэн, өөрөөр хэлбэл хэм хэмжээ үндсэн хуульд нийцсэн эсэх асуудал тодорхойгүй байна гэж үзсэн тохиолдолд түүнийг үндсэн хууль зөрчөөгүйг батлахын төлөө төрийн машин бүхэлдээ ажиллаж (нарийн ялгаа байж болох ч ийм байдал иргэдийн өргөдлийг хэлэлцэх үед илүү тод ажиглагддаг), харин үндсэн хуульд нийцээгүй, эсхүл түүний үндсэн хуулийн утга санааг илрүүлэх тал дээр төрийн байгууллагаас сул дорой, хууль зүйн хамгаалалтын хувьд хүч багатай өргөдөл гаргагч зогсдог. Иймээс үндсэн хууль зөрчөөгүйг батлах нотолгоо гаргаж ирэхийг, өөрөөр хэлбэл хэргийг хянан хэлэлцэх үед залруулах боломжгүй, үндсэн хуульд нийцсэн эсэх талаархи эргэлзээтэй байдлыг үндсэн хууль

зөрчсөн, эсхүл тухайн хэм хэмжээг практик дээр хэрэглэж буй утга санаа нь үндсэн хуулийн утга санаанд нийцэхгүй байгаа хоёрын аль талд ашигтайгаар авч үзэхийг нотлох шаардлагыг илүү хүчтэй талд тавих нь шударга юм. Үүний зэрэгцээ нотолгооны хэцүү хүнд хэсэг буюу хэргийн нөхцөл байдал, үндэслэл баримтуудыг үнэлж цэгнэх нь Үндсэн хуулийн шүүхийн өөрийнх нь хийх ажил гэдэг нь мэдээж билээ.

Дүгнэж хэлэхэд эрх зүйн актын үндсэн хуульд нийцсэн байдлын презумпци нь бас өөрийн гэсэн «эсрэг тал» буюу бүрэлдэхүүн хэсэгтэй – энэ нь үндсэн хуульд нийцсэн эсэх нь тодорхойгүй шалтгаанаар хэргийг хэлэлцэх үндэслэл болж өгсөн хэм хэмжээний үндсэн хуульд нийцээгүй байдлын презумпци (илүү хөнгөн хувилбар нь хэм хэмжээний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг тодруулах хэрэгцээ шаардлагын презумпци) юм. Презумпцийн зөвхөн ийм «нэгдмэл хослол» иргэдийн эрх, эрх чөлөөг илүү өндөр түвшинд хангаж, хамгаалж чадна.

6. Үндсэн хуулийн шүүхийн тогтоолын хэлбэрийн асуудалд эргэж ороход, «эерэг агуулга бүхий магадлал» гэсэн шийдвэрийн төрөл Үндсэн хуулийн шүүхийн практикт нэг хэсэг байсан. Ийм магадлалаар, зарим тогтоолын нэгэн адил хэм хэмжээний үндсэн хуулийн эрх зүйн утга санааг тогтоож байсан бөгөөд эдгээр нь «О-П» гэсэн тэмдэглэгээтэй байв. Хамгийн сүүлийн О-П 2011 оны нэгдүгээр сарын 27-нд гарсан. Маргаж буй хэм хэмжээний үндсэн хуулийн утга санааг тогтоон үүнээс өөр утгаар хэрэглэх боломжийг нь хааж өгөх «эерэг агуулга бүхий магадлалын» эрх зүйн бүтэц үндсэн хуулийн шүүн таслах байгууллагын хөгжлийн тодорхой шатанд зөв зүйлийн нэг байсныг хэлэх хэрэгтэй. Түүний туслалцаатайгаар өргөдөл, мэдээлэлд дурдсан үндсэн хуулийн тулгамдсан асуудлын талаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх шуурхай арга хэмжээ авч чадаж байсан.

2010 оны 11-р сарын 3-нд батлагдаж, 2011 оны 2-р сарын 9-ний өдрөөс мөрдөгдсөн № 7-ФКЗ «ОХУ-ын

Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» хуулиар мөн хуулийн үндсэн хуулийн процесст хамаарах хэсэгт томоохон өөрчлөлтүүд орсон. Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчлэх эрх зүйн хэд хэдэн моделийг тус хуулиар баталсан нь «эерэг агуулга бүхий магадлалыг» цаашид ашиглах шаардлагагүй болгосон юм. Мөн эдгээр өөрчлөлтөөс хамгийн чухал нь ажиллагааг амаар явуулахгүйгээр хэрэг хянан хэлэлцэх боломжийг шүүхэд олгосон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн шинэ 47.1 болон бусад зүйлийн зохицуулалт болно. Үндсэн хуулийн хяналтын онолд ийм хэлбэрийг бичгээр явуулах ажиллагаа гэж нэрлэх нь цөөнгүй (амаар явагддаг буюу хэргийг хянан шийдвэрлэхдээ оролцогчдыг сонсдог ажиллагаанаас ялгаж).

Ямар тохиолдолд ажиллагааг амаар явуулахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэж болох вэ? Эхний хувилбар – өргөдөл гаргагчийн маргаж буй эрх зүйн хэм хэмжээний актын заалтууд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн өмнө гаргасан хүчин төгөлдөр тогтоолоор Үндсэн хуульд нийцээгүй нь тогтоогдсон хэм хэмжээтэй төсөөтэй байвал. Зарчмын хувьд «төсөөтэй байдал» нь «ижилхэн» гэсэнтэй, өөрөөр хэлбэл тухайн хэм хэмжээтэй «яг ижил байна» гэсэн хэрэг биш. Энд «ойролцоо», «адил» гэсэн үгнүүдийг хэрэглэх нь илүү тохирно. Өөр өөр субъектэд зориулагдсан боловч эрх зүйн нэг хэм хэмжээгээр баталсан журам нь өөр аль нэг хэм хэмжээгээр тогтоосонтой адил байх, эсхүл журам нь адилгүй боловч Үндсэн хуулийн шүүхийн дүгнэж цэгнэх гол цөм буюу түүний үндсэн хуулийн бус (эсхүл үндсэн хуулийн) утга санаа адил байх тохиолдолд эдгээр хэм хэмжээг төсөөтэй гэж хэлж болно. Зарчмын хувьд төсөөтэй – үндсэн хуульд нийцсэн эсхүл түүнийг зөрчсөн – байдлыг ямар ч тохиолдолд тодорхой хэрэгтэй уялдуулан Үндсэн хуулийн шүүх өөрөө тогтооно.

Хоёрдугаар хувилбар – хэрвээ өргөдөл гаргагчийн маргаж буй эрх зүйн хэм хэмжээ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн өмнө гаргасан хүчин төгөлдөр тогтоолоор Үндсэн

хуульд нийцээгүй нь хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд түүнийг шүүх тодорхой хэрэг дээр хэрэглэсэн боловч уг хэм хэмжээг үндсэн хуульд нийцээгүй гэдгийг Үндсэн хуулийн шүүхээс баталгаажуулах нь иргэдийн үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн хууль хэрэглээний практикийн алдааг залруулахад шаардлагатай бол ажиллагааг амаар явуулахгүйгээр хэрэг шийдвэрлэх боломжтой. Аль нэг хэм хэмжээний үндсэн хуульд нийцээгүйг ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс баталгаажуулах боломж нь эдгээр хэм хэмжээ үндсэн хууль зөрчсөнийг хүлээн зөвшөөрч гаргасан өмнөх тогтоолуудын агуулгыг бичгээр явагдах ажиллагааны хүрээнд дахин дахин давтах эцэс төгсгөлгүй байдалд хүргэж болзошгүй гэсэн болгоомжлол мэдээжээр байсан. Хэрвээ ийм байдал үүсвэл хууль хэрэглэн тодорхой хэргийн талаар шийдвэр гаргадаг ердийн шүүхийн хэмжээнд Үндсэн хуулийн шүүх очих юм.

Тулгамдсан энэ асуудлыг шийдэх гол нөхцөл нь хэм хэмжээ үндсэн хуульд нийцээгүйг ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс баталгаажуулах нь хууль хэрэглээний практикт иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгахад шаардлагатайг заасан холбооны хууль тогтоогчийн заалт болно. Иймээс Үндсэн хуулийн шүүх тохиолдол болгонд «хуулбарласан» шийдвэр гаргах үүрэггүй юм. Тухайлбал зарим хэм хэмжээ үндсэн хуульд нийцээгүйг баталгаажуулах шаардлага байхгүйг ердийн журмаар тогтоож болно: учир нь үндсэн хуульд нийцээгүй нь хүлээн зөвшөөрөгдсөн тэр хэм хэмжээгээр эрх зөрчигдөөгүй, эсхүл хуулийг алдаатай хэрэглэсэн нэг удаагийн үйлдлээс болж үндсэн хуульд нийцээгүй байдлаар хэрэглэх явдал тогтсон нь практикаар нотлогдоогүй бол Үндсэн хуулийн шүүх асуудлыг эргэн авч үзэх шаардлагагүй. Ийм тохиолдолд татгалзсан магадлал гаргах ёстой. Тэмдэглэн хэлэхэд «бичгээр явуулах ажиллагааг» хэрэглэх эсэхийг шийдэхэд талуудын хүсэлт нөлөөлөх бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль болон Үндсэн хуулийн шүүхийн дэгийн тухай журмаар талуудын мэтгэлцээнийг хангасан баталгааг нэмж тогтоосон.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэтгэх бас нэг арга нь шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг үндсэн хуулийн процесст хураангуйлах явдал юм. Энэ зарчим одоо зөвхөн амралтын цаг, цаашид хэргийг хэлэлцэхэд бэлтгэхэд оролцогчдод шаардлагатай хугацаа, мөн түүнчлэн шүүх хуралдааныг хэвийн үргэлжлүүлэхэд саад болж буй байдлыг арилгахад зориулагдсанаас бусад цаг хугацаанд хамаарах бөгөөд үлдсэн цагт нь Үндсэн хуулийн шүүхийн шүүх хуралдаан тасралтгүй үргэлжлэх ёстой. Үүнтэй холбоотойгоор нэг хэргийг хэлэлцэж дуусаагүй үед өөр хэрэг хэлэлцэхийг (танхимд болон бүгд хурлаар хэргүүдийг нэгэн зэрэг хэлэлцэхэд хамаарахгүй) хориглосон заалтыг хуулиас хассан. Зарчмыг ийнхүү бага хэмжээгээр засварласан нь түүний мөн чанарт шүүмжлэлтэй хандах шалтаг болохгүй гэж бодож байна. Учир нь энэ зарчмын шүүх хуралдааныг тасралтгүй явуулах, өөрөөр хэлбэл шүүхийн шатанд нотлох баримтуудыг судлан дүгнэх ажиллагааг тасалдуулахгүй явуулах гол агуулга хэвээр үлдсэн болно.

7. Үндсэн хуулийн зарчмуудын тайлбар дээр тулгуурласан онцлог үндэслэл шалтгааныг үндсэн хуулийн шүүхийн байгууллага боловсруулсныг эцэст нь тэмдэглэх хэрэгтэй. Ийм учир шалтгаан нь арга зүй, найруулгаараа ердийн болон арбитрын шүүхүүдийн практикт хэрэглэгддэгээс ихээхэн ялгаатай. Тэрээр эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэхээс гадна ердийн шүүхийн шийдвэрийн шинж чанар болсон дүгнэлт, нотлох баримтуудыг хэлбэрийн талаас нь авч үзэх логик дээр тулгуурлаж, мөрдөгдөж буй хэм хэмжээг чанд баримтласнаар эрх зүйн шийдвэрлэгдэхгүй байдлаас гарах гарцыг эрх зүйн субъект олж чадахгүй байгаа нөхцөлд эрх зүйн хүмүүнлэгийн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг хангаж өгдөг. Иймд үндсэн хуулийн шууд үйлчлэл дээр тулгуурлан эрх зүйн зохицуулалтын одоо байгаа түвшинг тодорхой цаг үед хөгжүүлэх боломж олгож буй арга хэрэгслийн хувьд Үндсэн хуулийн шүүх эрх зүйн тогтолцоонд онцгой ач холбогдолтой юм.

***В.А. Сивицкий, заместитель руководителя
Секретариата Конституционного Суда Российской
Федерации, кандидат юридических наук***

НОРМАТИВНАЯ ПРИРОДА РЕШЕНИЙ ОРГАНА КОНСТИТУЦИОННОГО ПРАВОСУДИЯ: ОПЫТ КОНСТИТУЦИОННОГО СУДА РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

1. Одним из вопросов, вызывающих наиболее яркие юридические споры в сфере теории права и конституционного права фактически все годы с момента создания в «постсоциалистических» странах органов конституционного правосудия, является вопрос о том, осуществляют ли эти органы правотворческую функцию. Сходная тематика научных обсуждений, насколько известно, не обходит и страны, в которых специализированные органы конституционного правосудия существуют уже давно. Одни ученые признают нормотворческую функцию конституционного суда, другие скептически к ней относятся. Как представляется, этот спор вечный и неразрешимый.

Позиция по этому поводу относится скорее к своеобразной научной вере, правовой идеологии, ведь сторонники обеих позиций видят в деятельности органов конституционного правосудия одни и те же явления, только по-разному их оценивают. Вряд ли какая-либо дискуссия по этому вопросу может поставить точку в этом споре. Поэтому цель доклада – рассказать о некоторых аспектах правового регулирования и практики деятельности Конституционного Суда Российской Федерации в аспекте фактического правотворчества и о некоторых связанных с этим доктринальных подходах.

При этом с учетом ограниченности времени приходится только мельком упомянуть компетенцию Конституционного Суда Российской Федерации по официальному толкованию Конституции Российской Федерации.

Федерации, за которым доктрина чаще признает нормативную природу, а также доктрину «правовых позиций Конституционного Суда Российской Федерации» - то есть суждений Конституционного Суда, содержащихся в его решениях и содержащих относительно законченный вывод по той или иной правовой проблеме. Как правило, «правовые позиции» – это каузальное толкование Конституции при рассмотрении дела о проверке конституционности нормативного акта или при рассмотрении вопроса о принятии обращения к рассмотрению; иногда такое значение приобретает каузальная интерпретация норм Федерального конституционного закона «О Конституционном Суде Российской Федерации». Важно то, что за «правовыми позициями» - даже содержащимися не в резолютивной, а в мотивировочной части решений Конституционного Суда (причем не только постановлений по существу дела) - доктриной Конституционного Суда признается обязательность для всех правоприменителей.

2. Мы же все-таки обратимся прежде всего к резолютивным частям итоговых решений при рассмотрении дела по существу. И здесь нужно обратить внимание на почти полное отсутствие в практике Конституционного Суда постановлений, которыми норма признается полностью, без оговорок, неконституционной. В принципе, такая тенденция была всегда. А сейчас вообще фактически не встретишь постановления, где норма признается полностью неконституционной.

В практике Конституционного Суда Российской Федерации есть два варианта формулирования итогового вывода, когда с созданным проверяемой нормой правовым механизмом не все в порядке с конституционной точки зрения.

Первый вариант – признание нормы неконституционной в той или иной части, в том или ином смысле и так далее. Очевидно, что постановление

Конституционного Суда, признающее положение нормативного правового акта утратившим юридическую силу, не всегда означает буквальное исключение этого положения из нормативного правового акта. Конституционный Суд может определить пределы действия этого положения. Характерным - и одним из первых - примером является Постановление Конституционного Суда Российской Федерации по делу о проверке конституционности статьи 12 Закона СССР от 9 октября 1989 года “О порядке разрешения коллективных трудовых споров (конфликтов)”, в пункте 1 резолютивной части которого было определено, что установленный частью первой статьи 12 данного Закона запрет забастовок на предприятиях и организациях гражданской авиации соответствует Конституции Российской Федерации в той мере, в какой право на забастовку отдельных категорий работников может быть ограничено согласно статье 55 (часть 3) Конституции Российской Федерации в целях защиты основ конституционного строя, нравственности, здоровья, прав и законных интересов других лиц, обеспечения обороны страны, безопасности государства. То есть использована конструкция «в той мере, в какой». Также могут быть иные конструкции, максимально ограничивающие пределы признания нормы неконституционной. Фактически, Конституционный Суд имеет возможность определять пределы сохранения действия нормы.

3. Обычно именно в связи с этим и возникает вопрос о выполнении Конституционным Судом правотворческой функции. В том числе и по этой причине родилось одно из ярких, образных, запоминающихся суждений о правовой природе Конституционного Суда Российской Федерации, появившихся в последнее время в юридической литературе: «Конституционный Суд РФ – больше, чем суд»¹. Оно обосновывается именно выполнением Конституционным Судом такой правотворческой

¹ Бондарь Н.С. Судебный конституционализм в России. М., 2011. С. 87, 100.

функции. При этом подчеркивается «специфический, не классически-правотворческий» статус Конституционного Суда, то есть обусловленность фактически имеющего место в деятельности Конституционного Суда правотворчества «специфическими характеристиками конституционно-судебных полномочий по судебному нормоконтролю²».

В этой связи хотелось бы, обратившись в целом к судебному нормоконтролю как явлению, посмотреть, а как, абстрактно-теоретически, наиболее правильно было бы себя вести суду, если он усмотрит противоречие проверяемого акта тому, на соответствие которому проверка осуществляется? Что есть критерий качества работы? И здесь волей-неволей возникает аналогия с хирургом, удаляющим опухоль: он должен сделать так, чтобы, с одной стороны, никаких ее частиц не осталось, а с другой – чтобы здоровая часть органа сохранилась и могла функционировать. Именно так филигранно надо удалять из правовой системы дефекты правового регулирования, осуществляя нормоконтроль. Суд не может «вычеркнуть» лишнее, он не может «удалить» правовой механизм, который в целом можно считать здоровым, который нужен субъектам правоотношений, но в котором есть дефект. А ведь именно линейное признание нормы недействительной или недействующей целиком, без какого-либо замещения в таком случае – куда больший ущерб для чистоты и качества правовой системы, чем такое «фактическое нормотворчество» Конституционного Суда, которое на самом деле – средство обеспечения качественного судебного нормоконтроля.

И, вообще говоря, так должен вести себя любой суд при осуществлении нормоконтроля. И здесь обращает на себя внимание, что, например, российский законодатель, по существу, одинаково – кроме предмета, масштаба и нюансов предварительной стадии – регулирует нормоконтроль, осуществляемый Конституционным

² Там же. С. 99 – 100.

Судом, и нормоконтроль, осуществляемый, например, районным судом относительно муниципального нормативного правового акта.

Так, согласно статье 253 ГПК Российской Федерации суд, признав, что оспариваемый нормативный правовой акт не противоречит федеральному закону или другому нормативному правовому акту, имеющим большую юридическую силу, принимает решение об отказе в удовлетворении соответствующего заявления (часть первая); установив, что оспариваемый нормативный правовой акт или его часть противоречит федеральному закону либо другому нормативному правовому акту, имеющим большую юридическую силу, суд признает нормативный правовой акт недействующим полностью или в части со дня его принятия или иного указанного судом времени (часть вторая); решение суда о признании нормативного правового акта или его части недействующими влечет за собой утрату силы этого нормативного правового акта или его части, а также других нормативных правовых актов, основанных на признанном недействующим нормативном правовом акте или воспроизводящих его содержание (часть третья); решение суда о признании нормативного правового акта недействующим не может быть преодолено повторным принятием такого же акта (часть четвертая). Если мы сопоставим эти положения с положениями статей 87, 100 (отражающими варианты решений Конституционного Суда в результате нормоконтроля) и 79 (о юридической силе решений Конституционного Суда Российской Федерации), мы увидим, что глубокие сущностные – позволяющие кардинально по-другому характеризовать соответствующую судебную деятельность - различия на уровне нормативного правового регулирования отсутствуют.

Не может считаться в этом смысле поводом для утверждения о различиях в природе нормоконтроля то обстоятельство, что Конституционный Суд признает

нормы недействительными, а суды общей юрисдикции – недействующими.

Не может быть весомым аргументом в пользу «особости» правового регулирования полномочий Конституционного Суда при осуществлении нормоконтроля то, что согласно статье 6 Закона о Конституционном Суде решения Конституционного Суда Российской Федерации обязательны на всей территории Российской Федерации для всех представительных, исполнительных и судебных органов государственной власти, органов местного самоуправления, предприятий, учреждений, организаций, должностных лиц, граждан и их объединений. Дело в том, что согласно части 1 статьи 6 Федерального конституционного закона «О судебной системе Российской Федерации» вступившие в законную силу постановления федеральных судов, мировых судей и судов субъектов Российской Федерации, а также их законные распоряжения, требования, поручения, вызовы и другие обращения являются обязательными для всех без исключения органов государственной власти, органов местного самоуправления, общественных объединений, должностных лиц, других физических и юридических лиц и подлежат неукоснительному исполнению на всей территории Российской Федерации.

Но на выходе получаются существенно разные продукты. Если обычный суд просто делает вывод о законности или незаконности той или иной нормы либо акта в целом, то Конституционный Суд в итоговом решении использует конструкции, которые, действительно, позволяют увидеть в решениях Конституционного Суда свойство специфической нормативности. И еще раз подчеркнем, что дело здесь не в «особости» Конституционного Суда. Просто у Конституционного Суда раньше возник ресурс квалификации и решительности для такой методологии деятельности.

4. Второй вариант результата рассмотрения дела по

существо - выявление конституционно-правового смысла нормы. Принципиальной разницы между признанием нормы неконституционной в определенной части и выявлением ее конституционно-правового смысла, как показывает доктрина и практика Конституционного Суда, нет (при том, что последнее является проявлением со стороны Конституционного Суда конституционной сдержанности). Ведь, как неоднократно подчеркивал Конституционный Суд, юридической силой решения Конституционного Суда Российской Федерации, в котором выявляется конституционно-правовой смысл нормы и тем самым устраняется неопределенность в ее интерпретации с точки зрения соответствия Конституции Российской Федерации, обуславливается невозможность применения данной нормы (а значит, прекращение действия) в любом другом истолковании, расходящемся с ее конституционно-правовым смыслом, выявленным Конституционным Судом Российской Федерации; иное - в нарушение статьи 125 (части 4 и 6) Конституции Российской Федерации и части третьей статьи 79 Федерального конституционного закона “О Конституционном Суде Российской Федерации” - означало бы возможность применения нормы в прежнем ее понимании, не соответствующем Конституции Российской Федерации и, следовательно, влекущем нарушение конституционных прав граждан, в том числе заявителя; в силу этого решение Конституционного Суда Российской Федерации, которым выявляется конституционно-правовой смысл нормы и исключается любое иное ее истолкование и применение как не соответствующее Конституции Российской Федерации и, следовательно, нарушающее конституционные права граждан, имеет юридические последствия, предусмотренные пунктами 2 и 3 части первой статьи 100 Федерального конституционного закона “О Конституционном Суде Российской Федерации”, гарантирующей пересмотр дела заявителя компетентным органом в обычном порядке

(Постановления Конституционного Суда Российской Федерации от 21 января 2010 года N 1-П и от 26 февраля 2010 года N 4-П, Определение Конституционного Суда Российской Федерации от 11 ноября 2008 года N 556-О-Р).

5. Отметим, что в составе постановлений Конституционного Суда уменьшилось количество тех, в которых выявляется конституционный смысл, в пользу признающих оспариваемое положение неконституционным. В 2011 году тех, которыми оспариваемые положения частично или полностью признаются неконституционными, было 16 из 30 (больше половины), тогда как в 2010 – 8 из 22. Остальные - постановления с выявлением конституционно-правового смысла. Но в любом случае, эта статистика показывает, что после того, как дело принимается к рассмотрению Конституционным Судом, у нормы немного шансов остаться в прежнем виде – без признания ее неконституционной или без выявления ее конституционного смысла.

Это говорит о том, что надо с осторожностью относиться к такой достаточно распространенной доктрине как «презумпция конституционности акта».

Презумпцию конституционности можно охарактеризовать как непосредственно вытекающее из свойств обязательности и иерархичности правового регулирования предположение о том, что положения всех нормативных правовых актов, принятых на территории Российской Федерации, считаются соответствующими Конституции Российской Федерации до того момента, пока иное не будет установлено в предусмотренной законодательством для проверки соответствующего вида нормативных правовых актов форме. Презумпцию конституционности нормативного акта нужно считать как элементом презумпции «правильности акта», основанной на самой характеристике права как системы норм, устанавливающих обязательные правила поведения, так

и элементом принципа верховенства Конституции. Это, условно, материально-правовая сторона презумпции. Без признания в правовой повседневности того, что нижестоящий акт априори соответствует вышестоящему, нельзя рассчитывать, что норма закона воплотится в конкретных правоотношениях.

Суть любой презумпции не в том, что противоположный утверждению вывод в принципе невозможен, а в том, что он может быть достигнут только при определенных условиях. И в данном случае специфика конституционной материи предопределила, что основным средством опровержения презумпции конституционности применительно к конкретной оспариваемой норме является Конституционный Суд Российской Федерации, который может выявить неконституционность акта или его конституционно-правовой смысл, отличающийся от применяемого на практике.

Согласно статье 36 Федерального конституционного закона «О Конституционном Суде Российской Федерации» основанием к рассмотрению дела является, в частности, обнаружившаяся неопределенность в вопросе о том, соответствует ли Конституции Российской Федерации закон, иной нормативный акт, договор между органами государственной власти, не вступивший в силу международный договор. Соответственно, если отсутствует неопределенность в вопросе о конституционности нормы, в принятии соответствующего обращения к рассмотрению отказывают в связи с тем, что оно не является допустимым, и только если неопределенность имеется – обращение принимается к рассмотрению. То есть имеется определенный фильтр, позволяющий принимать к рассмотрению действительно проблемные вопросы. Но после того, как проблема выявлена и дело принято к рассмотрению, возникает иной аспект проблемы – последствия принятия решения о признании нормы конституционной или неконституционной. Более гуманистически направленным

является, как ни странно, признание нормы именно неконституционной (или выявления ее конституционного смысла), так как это увеличивает шансы восстановления прав человека и гражданина, прежде всего, влечет пересмотр дела заявителя.

При этом, если уж дело дошло до рассмотрения Конституционным Судом Российской Федерации, то есть усмотрена неопределенность в вопросе о конституционности нормы, нужно иметь в виду, что на стороне конституционности выступает, по идее, вся государственная машина (это наиболее явно проявляется по жалобам граждан, хотя могут быть нюансы), а на стороне неконституционности или выявления конституционного смысла – заявитель, который обычно слабее, в том числе в плане юридического обеспечения, чем государственные органы. Соответственно, бремя доказывания конституционности справедливее возложить на более сильную сторону, то есть неустраимые в ходе рассмотрения дела сомнения в конституционности толковать в пользу неконституционности или несоответствия смысла нормы, применяемого на практике, ее конституционному смыслу. При этом, конечно, речь идет не о формальном, а о фактическом бремени доказывания, то есть фактически об оценке ситуации и выстраивании аргументации самим Конституционным Судом.

Итак, презумпция конституционности акта имеет и свою «антитезу» и одновременно составную часть - презумпцию неконституционности нормы, ставшей предметом рассмотрения в связи с выявленной неопределенностью в вопросе о ее конституционности (или – как более мягкий вариант – презумпцию необходимости выявления ее конституционно-правового смысла). Именно такая «двуединая» презумпция обеспечивает наиболее высокий уровень защиты прав и свобод граждан.

6. Возвращаясь к вопросу о формате итоговых решений Конституционного Суда, необходимо отметить, что некоторое время в практике Конституционного Суда был такой тип решений Конституционного Суда Российской Федерации как «определения с позитивным содержанием». В таких определениях, как и в ряде постановлений, выявлялся конституционно-правовой смысл нормы. Такие определения обозначались «О-П». Последнее О-П принято 27 января 2011 года. Надо сказать, что правовая конструкция «определения с позитивным содержанием» - выявлявшего конституционный смысл оспариваемой нормы и, соответственно, исключавшего применение ее в каком-либо другом смысле – на определенном этапе развития конституционного правосудия была вполне оправданной. Благодаря этому удавалось обеспечить оперативное реагирование Конституционного Суда Российской Федерации на конституционную проблему, выявленную в обращениях.

Федеральный конституционный закон от 3 ноября 2010 года № 7-ФКЗ «О внесении изменений в Федеральный конституционный закон «О Конституционном Суде Российской Федерации», вступивший в силу 9 февраля 2011 года, содержит наиболее существенные на сегодняшний день изменения Федерального конституционного закона «О Конституционном Суде Российской Федерации», касающиеся собственно конституционного процесса. Он предусматривает иные правовые модели ускорения рассмотрения дел Конституционным Судом, которые позволили отказаться от использования «определений с позитивным содержанием». А из них самое значимое – возможность рассмотрения дел без проведения слушаний, которое регулируется новой статьей 47.1 Закона о Конституционном Суде и рядом других его статей. В теории конституционного контроля соответствующая форма нередко именуется письменным производством (в отличие от производства устного, то есть от рассмотрения и разрешения дел с проведением их слушания).

Когда применяется разрешение дела без проведения слушания? Первый вариант - если оспариваемые заявителем положения нормативного правового акта аналогичны нормам, ранее признанным не соответствующими Конституции Российской Федерации постановлением Конституционного Суда Российской Федерации, сохраняющим силу. Принципиально, что «аналогичность» - не значит «идентичность», то есть то, что норма - «точно такая же». Скорее, в качестве синонима можно употреблять слова «сходная», «похожая». О том, что одна норма аналогична другой, можно говорить в том случае, если в ней закрепляется, пусть даже к другим субъектам правоотношений, такое же правило, либо даже если правило не совсем такое, но его неконституционный или конституционный смысл, можно сказать, квинтэссенция, основная суть, являющаяся предметом оценки Конституционным Судом, такая же. В принципе, эта аналогичность – как аналогичность по конституционному или неконституционному смыслу - в любом случае будет выявляться применительно к конкретному делу самим Конституционным Судом.

Второй вариант, когда возможно рассмотрение дела без проведения слушания – если оспариваемая заявителем норма, ранее признанная неконституционной постановлением Конституционного Суда Российской Федерации, сохраняющим силу, применена судом в конкретном деле, а подтверждение Конституционным Судом Российской Федерации неконституционности нормы необходимо для устранения фактов нарушений конституционных прав и свобод граждан в правоприменительной практике. Безусловно, возникало опасение, не побуждает ли норма о возможности подтверждения Конституционным Судом Российской Федерации неконституционности тех или иных норм к бесконечному воспроизведению Конституционным Судом в рамках письменного производства содержания уже принятых им постановлений о признании

неконституционными тех или иных правовых норм. Если бы это было так, то фактически делало Конституционный Суд обычным правоприменительным судом, принимающим решение по конкретным делам.

Тем не менее, применительно к данной проблеме ключевым является указание федерального законодателя на то, что подтверждение Конституционным Судом Российской Федерации неконституционности нормы необходимо для устранения фактов нарушений конституционных прав и свобод граждан в правоприменительной практике. В силу этого Конституционный Суд вовсе не обязан в каждом случае принимать «дублирующие» постановления. Так, по общему правилу может быть установлено отсутствие необходимости подтверждать неконституционность тех или иных норм: либо поскольку на самом деле права нарушены не той нормой, которая была признана неконституционной; либо поскольку факт одного ошибочного правоприменения еще сам по себе не обязывает Конституционный Суд возвращаться к этому вопросу, если сохранение неконституционного применения не подтверждено сложившейся практикой. В таком случае должно быть вынесено отказное определение.

Отметим, что на возможность использования «письменного производства» влияет волеизъявление сторон, а в Закон о Конституционном Суде и Регламент Конституционного Суда внесены дополнительные гарантии состязательности сторон.

Еще один из способов ускорения рассмотрения дела - сокращение нормативного объема принципа непрерывности судебного заседания в конституционном процессе. Теперь он, как следует из его буквального наименования, касается только невозможности прерывать заседание Конституционного Суда, за исключением времени, отведенного для отдыха или

необходимого для подготовки участников процесса к дальнейшему разбирательству, а также для устранения обстоятельств, препятствующих нормальному ходу заседания. Соответственно, установленный ранее запрет рассматривать одно дело, не закончив другое (не касающийся, впрочем, параллельного рассмотрения дел в палате и на пленуме) из закона был исключен. Как представляется, такая корректировка принципа не является критичной для его существа. Ведь его ядро – недопустимость прерывания заседания, то есть судебного изучения доказательств, чтобы не нарушить целостность восприятия судьями – сохранилась.

7. В заключение необходимо отметить, что органами конституционного правосудия выработана специфическая аргументация, основывающаяся на интерпретации конституционных принципов. Такая аргументация, по методике и по стилистике, существенно отличается от аргументации, применяемой в практике судов общей юрисдикции и арбитражных судов. Она позволяет обеспечивать развитие правового регулирования, а также реализацию гуманистической функции права в ситуациях, когда на основе формальной логики, свойственной обычным судебным решениям, нельзя найти выход из неразрешимой правовой ситуации, в которой - в строгом соответствии с действующими нормами – оказался субъект права. Поэтому конституционный суд очень важен в правовой системе как инструмент, позволяющий в конкретный момент времени перерастать существующий уровень правового регулирования на основе прямого действия конституции.

Хан Чул Парк
БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч

**ҮНДСЭН ХУУЛИЙН АРДЧИЛЛЫГ ТОГТООХ ЯВДАЛ
БА ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГАРГАХ
АЖИЛЛАГАА, СОЛОНГОС УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУРШЛАГААС**

1. Танилцуулга

Хүндэт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга
Ж. Амарсанаа,

Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүндэт шүүгчид,
Эрхэм төлөөлөгчид, ноёд хатагтай нар аа,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн
ойд зориулсан Олон улсын хуралд оролцож Үндсэн
хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны талаар
танилцуулга хийх болсон явдал нь туйлын таатай бөгөөд
нэр хүндтэй хэрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оны шинэ
Үндсэн хуулийн дагуу анх байгуулагдсанаасаа хойш
Үндсэн хуулийг хамгаалах, ардчиллыг бэхжүүлж эрх
чөлөөг нэмэгдүүлэх ажилд төгсгөлгүй идэвхи чармайлт
гаргаж байгаагаараа ард түмний итгэл хүндэтгэлийг
хүртэж ардчилал болон үндсэн хуульт ёсны эцсийн
баталгаа болсоор байгаа гэдгийг ойлгож байна. Энэ
мөчид би Монгол Улсын Үндсэн хуулийн агуу амжилтанд
гүн хүндэтгэл илэрхийлж байна.

Та бүгдийн мэдэж байгаачлан, орчин үеийн үндсэн
хуульт төрийн байгуулал Үндсэн хуулийн шүүхийн
шийдвэр гаргах ажиллагааг иргэдийн үндсэн эрхийг
хамгаалах болон төрийн эрх мэдлийг хянах хамгийн үр
нөлөөтэй хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрдөг.

Эрх мэдлийн хуваарилалтын уламжлалт онол
нь төлөөллийн ардчиллын хөгжлийн улмаас хянан
тэнцвэржүүлэх чухал үүргээ биелүүлээгүй тохиолдолд

орчин үеийн үндсэн хуульт төрийн байгууллага амьдрал дээрхи эрх мэдлийн хуваарилалтын сонгодог үзэл баримтлалын сул байдлыг засч залруулах зорилгоор төрийн эрх мэдлийг үр дүнтэйгээр хязгаарлах шинэ хэрэгсэл болгон үндсэн хуулийн шүүхийн тогтолцоог нэвтрүүлсэн билээ.

Төрийн эрх мэдлийг хянах явцад хэрэгжүүлэх ёстой үндсэн хуулийн үнэт зүйлсийн тодорхой зүйлийг олж тогтоох явдал нь Үндсэн хуулийн шүүхийн нэг үүрэг болдог бөгөөд өөр нэг үүрэг нь төрийн эрх мэдлийн бүхий л төрөл нь Үндсэн хуулийн шүүхийн хяналтын субъект байх ёстой асуудал юм. Ийм Үндсэн хуулийн шүүхээр дамжуулан үндсэн хуулийн үнэт зүйлс болон хүний эрхийг хамгаалж үндсэн хуулийн ардчилалыг баттай тогтоох боломжтой юм.

Солонгос улсын Үндсэн хуулийн шүүхийн туршлага дээр үндэслэн үндсэн хуулийн ардчиллыг баттай тогтоох үндсэн хуулийн шүүхийн тогтолцооны талаар товч тайлбарлая.

2. Үндсэн хуулийн ардчилал ба Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа

Өнөө үед төрийн болон нийгмийн чухал ойлголт болон үнэт зүйлсийн тогтолцоо нь үндсэн хуулиар хэлбэржиж, түүнд тусгагдсан байдаг. Үндсэн хууль нь эрх зүйн хэм хэмжээ байхаас гадна нийгмийг энх тайвны замаар хөгжүүлж авч явахад шаардлагатай суурь үзэл бодол, зарчмын талаархи ард түмний хүсэл зориг юм. Энэ утгаараа, ардчиллын талаар хэлэлцэх тохиолдолд бид юуны өмнө Үндсэн хуулинд тусгасан ардчиллын үзэл болон төрлийг харгалзан үзэх ёстой.

Орчин үеийн ихэнх либераль ардчилсан төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн хуулийн ардчиллын тогтолцооны дагуу Үндсэн хууль нь эрх мэдлийн хуваарилалт болон хяналт ба тэнцвэрийн үндсэн дээр төрийн эрх мэдэл зөрчигдөхөөс сэргийлэх хэм хэмжээг тогтоодог бөгөөд иргэдийн үндсэн эрхийн баталгааг

бий болгож, хууль тогтоох болоод төрийн бусад бүх эрх мэдлийн хэрэгжилт Үндсэн хуулийн дээд эрх мэдлийн үзэл санааны дагуу Үндсэн хуулинд захирагдсан байх ёстой юм.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь иргэдийн үндсэн эрх төрийн эрх мэдлийн улмаас хохирсон, эсвэл хууль тогтоогчийн баталсан хууль Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдолд уг явдлыг залруулах тогтолцоо болдог. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь хүний эрхийг баталгаажуулж, төрийн эрх мэдлийн хэм хэмжээ болон Үндсэн хуулийн үр нөлөөг хамгаалж, мөн төрийн бүх эрх мэдлийг Үндсэн хуулийн дэг журмын дагуу хэрэгждэг байлгахаар зорьдог явдлаараа Үндсэн хуулийг өндөрт өргөн түүний үнэ цэнийг ойлгуулж байдаг.

Түүнчлэн орчин үеийн намын улс төрийн бодлогын дагуу, хуулийг батлах эсвэл үндэсний бодлогыг нийтийн сайн сайхнаас илүү сонирхогч бүлгүүдийн хэлэлцээрээр шийдэж цөөнхийг гадуурхаж байгаа цагт цөөнхийг хамгаалах үүрэг бүхий Үндсэн хуулийн шүүхийн зохицуулалт парламентаризмын сул талыг арилгаж цөөнхид өөрсдийн нийгмийг дэмжих боломжийг олгодог.

3. Солонгос улсын Үндсэн хуулийн ардчиллыг бий болгоход Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны хуримтлуулсан туршлага

Солонгос улсын үндсэн хуулийн шийдвэр гаргах ажиллагааны үүсэл 1948 онд анхны Бүгд Найрамдах Улсыг байгуулсан явдлаас эхэлдэг боловч тухайн үед үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа дөнгөж нэр төдий байсан. Бие даасан Үндсэн хуулийн шүүх байгуулах санааг 1960 онд анх удаа Солонгос улсад хоёр дахь Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн хамт танилцуулсан боловч 1961 онд болсон төрийн эрхийг цэргийн хүчээр булаан авах үйл явдлын улмаас Үндсэн хуулийн шүүх болоод төрийн бусад бүх байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон. 1962 онд Цэргийн Засгийн Газрын баталсан гурав дахь Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулиар үндсэн

хуулийн хяналтыг хэрэгжүүлэх хараат бус, бие даасан институцийг /байгууллагыг/ байгуулахын оронд хууль Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг шалгах эрхийг ердийн шүүхэд олгосон. Хожим нь буюу 1972 болон 1980 онуудад Үндсэн хуулинд орсон өөрчлөлтөөр Үндсэн хуулийн хороо байгуулагдсан боловч түүний үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах эрх нь хязгаарлагдмал байснаас гадна уг хороо нь нэр төдий оршиж байсан юм.

Үүний дараа ардчиллын төлөөх үндэсний зорилгын хүчинд 1987 онд Үндсэн хуульд дахиж өөрчлөлт орж 1988 оны Есдүгээр сард бие даасан Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан.

Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь аливаа хуулийг Үндсэн Хуульд нийцсэн талаар, Үндсэн хуулийг зөрчсөн гэх гомдол, маргааныг шийдвэрлэх, импичмент болон үндсэн хуулийн бус улс төрийн намыг татан буулгах зэрэг асуудалд шийдвэр гаргах эрхтэй бөгөөд түүний шүүх ажиллагааны хоёр хамгийн чухал хэсэг нь “хуулийг Үндсэн хуульд нийцсэнийг шалгах” болон “Үндсэн хуулийг зөрчсөн талаарх гомдол” байдаг.

Аливаа хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шалгах тогтолцоо, ажиллагаа нь шалгагдаж буй хууль нь ердийн шүүх дээр шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа хэргийг ердийн шүүхийн хүсэлтээр Үндсэн хуулийн шүүх рүү шилжүүлэн шалгуулах урьдчилсан нөхцөл байх ёстой гэсэн нөхцөлийн үндсэн дээр аливаа хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шалгах ажиллагаа юм. Үндсэн хуулийг зөрчсөн талаарх гомдлын систем нь хувь хүмүүст тэдгээрийн үндсэн эрх ердийн шүүхийн шийдвэрээс бусад төрийн байгууллагын үйлдэл эс үйлдлийн улмаас зөрчигдсэн гэж үзэн шууд туслалцаа хайж буй тохиолдолд гарц болж өгдөг. Түүнчлэн Үндсэн хуулийг зөрчсөн талаарх гомдлын систем нь талууд шүүхийн ажиллагаанд хэрэглэхээр тогтсон хуулийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шалгуулахаар гаргасан хүсэлт нь хангагдаагүй тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хандан тухайн

хуулийг Үндсэн Хуульд нийцсэн эсэхийг шалгуулахаар гомдол гаргах байдлаар хэрэгждэг Үндсэн хуулийн шүүхийн тодорхой эрхийг шийдэх баталгаажуулсан өөр механизмаар хангадаг. Энэхүү систем нь иргэдийн үндсэн эрхийг хамгаалах болон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хөгжүүлэх явдалд их хувь нэмэр үзүүлдэг.

Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь байгуулагдсан цагаасаа эхлэн 24 жилийн түүхэндээ 20,000 гаруй хэрэг хүлээн авсан байна. Тэдгээрийн дотор 1050 орчим тохиолдолд шалгагдсан хууль нь Үндсэн хуульд нийцээгүй эсвэл Үндсэн хуулийг зөрчсөн талаарх гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна. Анх байгуулагдсаныхаа дараахан буюу 1989 онд Үндсэн хуулийн шүүх 425 хэргийг бүртгэж авсан боловч уг тоо жилд 1500 гаруй болж нэмэгдсэн.

Энэ хугацаанд Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь төрийн эрх мэдлийн хэрэгжилт болон хүмүүсийн хувийн амьдралыг үндсэн хуулийн онол болон журмын гол субъект болгон манай улсын улс төр, эдийн засаг болон нийгмийн бүх хэсэгт ихээхэн нөлөө үзүүлсээр ирсэн. Үүнтэй холбоотойгоор, би Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрлэсэн зарим чухал шийдвэрийн талаар товч танилцуулъя.

1) Урьдчилан сэргийлж цагдан хорих тухай хуулийн заалтыг хэсэгчлэн хүчингүй болгосон шийдвэр, 1989 оны 7 сарын 14.

- Энэ хэрэгт Нийтийг Хамгаалах тухай хуучин хуулийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд өмнө нь тухайн гэмт хэрэгтэй адил буюу ижил төстэй гэмт хэрэгт хэд хэдэн удаа шийтгэгдэж байсан бол 10 жилийн хугацаатайгаар урьдчилан сэргийлж цагдан хорих тухай заалтыг гэмт хэргийн рецидив шинжийг үл харгалзсан, зохих ёсны процедурын зарчмыг зөрчсөн, түүнчлэн хэмжээнээс хэтэрхий давсан хориглолтын зарчим болон шүүхээр хэргээ хэлэлцүүлэх эрхэд саад учруулсан гэх үндэслэлээр үндсэн хуульд нийцээгүй гэсэн шийдвэр гаргасан.

- Шүүхийн хяналтын явцад Нийтийг Хамгаалах тухай хуучин хуулинд “рецидивизмтэй төстэй байдал”-аас урьдчилан сэргийлж цагдан хорих явдлын бүрэлдэхүүн байхаар өөрчилсөн. Шүүх ийм шийдвэр гаргасны дараа ч Нийтийг Хамгаалах тухай хуулийг үндсэн хуульд нийцсэн эсэх талаар хүчтэй мэтгэлцээн өрнөсөн бөгөөд 2005 оны наймдугаар сард Үндэсний Ассамблей Нийтийг Хамгаалах тухай хуулийг бүхэлд нь хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан.

2) Прокурорын хяналтаас чөлөөлөх тухай прокурорын шийдвэрийг хүчингүй болгосон хэрэг, 1989 оны 10 сарын 27.

- Энэ хэрэгт шүүх цэргийн прокурорын сэжиг бүхий нөхцөл байдал хангалтгүй гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон прокурорын хяналтаас чөлөөлсөн тухай шийдвэрийг хүчингүй болгосон бөгөөд шударга ёс болон сайн сайхан амьдрах эрхийг зөрчсөн хэмээн үзжээ.

- Шүүхийн энэхүү шийдвэр нь прокурорын хяналтаас чөлөөлсөн шударга бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх ёстой гэж үзсэнээр ихээхэн ач холбогдолтой шийдвэр болсон юм.

3) Өмгөөллийн туслалцаа үзүүлэх эрхийг зөрчсөнтэй холбоотой Үндсэн хуулийг зөрчсөн тухай шийдвэр, 1992 оны 1 сарын 28, 2004 оны 9 сарын 23.

- Энэ хэрэгт шүүх засан хүмүүжүүлэх ангийн харгалзагч нар давж заалдахаар хүлээж байсан ялтанг өмгөөлөгчтэйгөө уулзах үед хамт байх боломжийг бий болгосон хуулийн заалтыг хүчингүй болгосон бөгөөд сэжигтний аливаа байцаалтанд өмгөөлөгчийн хамт орох хүсэлтэд прокурорын зүгээс татгалзаж байгаа нь үндсэн хуулиар баталгаажсан өмгөөллийн туслалцаа үзүүлэх эрхийг зөрчиж байна гэж үзсэн.

- Шүүхийн шийдвэрийг үндэслэн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

4) Нийтийн эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс хувийн өмчийн хуулийн этгээдэд хандан гаргасан шударга бус үйлдлийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн шийдвэр, 1993 оны 7 сарын 29.

- Энэ хэрэгт, төрийн байгууллага хувийн өмчийн хуулийн этгээдийг хууль зүйн арга хэрэгслээр бус банкны зааврын дагуу татан буулгаж байгаа нь энэ асуудал засгийн газрын, улс төрийн бодлогын шийдвэртэй холбоотой учраас хувийн хэвшлийн бизнесийн удирдлага руу төрийн зүгээс дур мэдэн оролцох явдлыг хүлээн зөвшөөрч болохгүй гэх үндэслэлээр үндсэн хуульд харшилсан гэж шийдвэрлэсэн.

- Энэхүү шийдвэр нь засгийн газар хувийн хуулийн этгээдийн удирдлага руу дампуурсан байсан ч гэсэн зохих ёсны хууль зүйн үндэслэлгүйгээр оролцож болохгүй гэдгийг тунхагласан юм.

5) Хөдөлгөөнт дүрсийн бичлэгийн урьдчилсан шалгалттай холбоотой Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр, 1999 оны 9 сарын 16, 2001 оны 8 сарын 30.

- Энэ хэрэгт, шүүх үндсэн хуулиар хориглогдсон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтанд үндэслэн аливаа хөдөлгөөнт дүрс бичлэг хийх эсвэл зарах тохиолдолд урьдчилсан шалгалтанд оруулах хязгаар тавих ёстой гэх хуулийн заалтыг үндсэн хуулинд нийцээгүй гэж шийдвэрлэсэн.

- Энэхүү шийдвэр нь кино урлагаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон Солонгос улсын урлаг, соёлд үлэмж хэмжээний хувь нэмэр болсон хэмээн үнэлэгддэг.

6) Ахмад дайчдад олгосон нэмэгдэл оноотой холбоотой Үндсэн хууль зөрчсөн талаарх шийдвэр, 1999 оны 12 сарын 23.

- Энэ хэрэгт эмэгтэйчүүдийн төрийн алба хаах эрх болон тэгш эрхийг зөрчиж байна гэх үндэслэлээр төрийн албан хаагчийн шалгалтанд цэргийн үүргээ гүйцэтгэсэн эрэгтэйчүүдэд шалгалтанд авсан онооны 5% болон 3%-

тай тэнцэх нэмэлт оноог олгож байгаа систем нь үндсэн хуульд нийцээгүй гэж шийдвэрлэсэн.

- Энэ шийдвэрийн нөлөөгөөр нэмэлт онооны системийг устгасан бөгөөд Солонгос улс дахь эмэгтэй төрийн албан хаагчдын хувь нь 1998 оны 29.8%-иас 2008 онд 40.8% болтлоо өссөн байна.

7) Иргэний харъяаллын үндсэн дээр өв залгамжлалыг эрэгтэй талаар тодорхойлохтой холбогдуулан гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийг зөрчсөн шийдвэр болсон тухай, 2000 оны 8 сарын 31.

- Энэ хэрэгт Иргэний Харъяаллын тухай хууль нь эрэгтэйн талаар тодорхойлох системийг хэрэглэж байгаа явдал нь Солонгос эцэгтэй гадаад ээжтэй хүүхдүүдэд Солонгос ээжтэй гадаад аавтай хүүхдүүдээс явгавартай хандаж, энэ нь тэгш байдлын зарчимтай зөрчилдөж байгаа тул тус хуулийн холбогдох заалт нь үндсэн хуульд нийцээгүй байна гэж шийдвэрлэсэн.

- Энэ хэрэг нь Солонгосын нийгэмд гэр бүлийн гадаад гишүүнтэй холбоотойгоор хүйсийн тэгш байдлын асуудалд хандуулах анхаарлыг нэмэгдүүлсэн юм.

8) Үндэсний Ассамблейд Пропорциональ Суудал Хуваарилах Нэг Хүн-Нэг Санал өгөх асуудалтай холбогдуулан гаргасан шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн тухай, 2001 оны 7 сарын 19.

- Энэ хэрэгт, шүүх Нийтийн Сонгуулийн тухай хуулийн нам бүр нэр дэвшиж буй дүүргээсээ авсан саналын хувийн дагуу суудал хуваарилан авдаг нэг хүн-нэг саналын тогтолцоог бий болгосон заалт нь сонгуульд эрх тэгш оролцох зарчим болон шууд сонгуулийн зарчимтай харшилдаж байна гэх үндэслэлээр үндсэн хуульд нийцээгүй хэмээн шийдвэрлэжээ.

- Энэ шийдвэрийн ачаар Нийтийн Сонгуулийн тухай хуульд засвар оруулж сонгогч бүр нэр дэвшигч болон пропорциональ суудалд өөрөөр хэлбэл нийт хоёр санал өгөх боломжтой болсноор үндэсний бодлогын

шийдвэр гаргах үйл явцад иргэдийн үзэл бодол тусгалаа олж чадсан юм.

9) Сонгуультай холбоотойгоор ялгаатай тархалттай хүн амын тойргийг дахин тогтоох тухай хэрэг, 2001 оны 10 сарын 25.

- Энэ хэрэгт шүүх ерөнхий сонгуулийн тойрог дахь хүн амын ялгаатай тархалтын хувь хэмжээ нь үндэсний дундаж хэмжээнээс 50%-иар зөрж байгаа бөгөөд сонгуулийн тойрог хуваарилах явдалд хүн амын тархалтын хувийг тэнцүүлэх зарчим бол хамгийн чухал хүчин зүйл гэж дүгнэсэн.

- Энэхүү шийдвэрийн дараа хүн ам шигүү суурьшсан сонгуулийн тойргийг хувааж, сийрэг хүн амтай тойргийг нэгтгэсэн байна.

10) Гадаадад буй Солонгос үндэстэн хэмээх ангиллаас Хятадад байгаа Солонгос иргэдийг хассан тухай Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр, 2001 оны 11 сарын 20.

- Энэ хэрэгт, Засгийн Газрыг байгуулахаас өмнө нь ихэвчлэн Хятад болон хуучин Зөвлөлт Холбоот Улсад амьдарч байгаад орхигдсон Солонгосын иргэдийг гадаадад байгаа Солонгос иргэд гэх ангиллаас хассан заалтын дагуу Солонгосын засгийн газрыг байгуулахаас өмнө цагаачилсан иргэдэд өргөдөл гаргагчийн адилаар хандаж байгаа нь зохих үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхаж буй явдал бөгөөд тэгш эрхийн зарчимд харшилж байна гэж шүүхээс шийдвэрлэсэн.

- Шүүхийн энэ шийдвэрийн дараа хилийн чанадад амьдарч байгаа 2.5 сая Солонгос үндэстэн Гадаадад байгаа солонгос иргэд гэх ангилалд багтсан бөгөөд Солонгос улс руу орж гарах болон Солонгос улсад хөдөлмөр эрхлэхэд давуу байдал байх эрх олж авсан юм.

11) Гадаадын дипломат төлөөлөгчийн газрын ойролцоо цуглаан хийхийг хориглосон нь үндсэн хуульд нийцээгүй шийдвэр болсон тухай, 2003 оны 10 сарын 30.

- Энэ хэрэгт гадаадын дипломат төлөөлөгчийн газрын ойролцоо 100 метрийн зайд олон нийтийн цуглаан зохион байгуулах явдалд ерөнхий хориг тавьсан Олон нийтийн цуглаан болон жагсаал хийх тухай хуулийн заалт нь цуглаан хийх эрх чөлөөг хэтэрхий их хэмжээгээр хориглож байна гэж шүүхээс шийдвэрлэсэн.

- Энэ хэрэг нь цуглаан хийх эрх чөлөөний ач холбогдлыг (хувь хүний зан төлөвийг чөлөөтэй хөгжүүлэхэд мөн ардчиллын үндсэн бүрэлдэхүүн болдог гэсэн утгаар) болон тайван цуглаан нь байж болох их хэмжээнд хамгаалагдаж байх хэрэгтэй гэдгийг тунхагласан юм.

12) Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах тухай хэрэг, 2004 оны 5 сарын 14.

- Энэ хэрэгт ерөнхийлөгч сонгуулийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тодорхой нэг намыг дэмжиж буйгаа илэрхийлсэн нь төрийн албан хаагчийн төвийг сахих үүргээ зөрчсөн явдал бөгөөд олон нийтэд хүрсэн энэхүү мэдэгдэл нь үндсэн хуулиар ерөнхийлөгчид үүрэг болгосон үндсэн хуулийг дэмжих болон хамгаалах үүргээ зөрчсөн явдал хэмээн шүүхээс үзсэн. Гэвч, шүүх эцэст нь ерөнхийлөгчийн гаргасан зөрчил нь хүнд зөрчлийн хэмжээнд хүрэхгүй гэж үзсэн бөгөөд албан тушаалаас нь огцруулах өргөдлийг хэрэгсэхгүй болгосон байна.

- Энэ нь Солонгос улсын үндсэн хуулийн түүхэн дэх анхны албан тушаалаас нь огцруулах шийдвэр бөгөөд үндсэн хуулийн эрх хэмжээг баталгаажуулж улс төрийн маргааныг шүүхийн аргаар шийдвэрлэх чухал завшаан болсон гэж үнэлэгдсэн юм.

13) Хэвлэлийн эрх чөлөөнд халдсан нь Үндсэн хуулинд нийцээгүй тухай шийдвэр, 2006 оны 6 сарын 29.

- Энэхүү хэрэгт Хэвлэлийн Хөгжлийн Сангийн ашгаас уншигчдын 60 гаруй хувийг эзэлж өндөр бүтээмжтэйгээр зах зээлд давамгайлж буй гурван сонины компанийг хасах хуулийн заалт нь хэвлэлийн эрх чөлөө болон тэгш байдлын зарчмыг зөрчиж байгаа учраас

үндсэн хуульд нийцээгүй хэмээн шүүхээс шийдвэрлэсэн.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрийн эрх мэдлээр хянах явдлыг шүүхээс хүлээн зөвшөөрч болохгүй гэдгийг тунхагласан.

14) Хилийн чанадад байгаа Солонгос иргэдийн улс төрийн эрхийн хязгаарлалттай холбоотойгоор гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй, 2007 оны 6 сарын 28.

- Энэхүү хэрэгт сонгох эрхийг хориглох тохиолдолд туйлын тодорхой бөгөөд тусдаа шалтгаан бүхий онцгой нөхцөл байдал бий болсон байх ёстой гэж шүүх үзсэн бөгөөд гадаад улсад оршин сууж буй Солонгос улсын иргэн, гадаад улсад байнга оршин суудаг Солонгос улсын иргэнийг хассан хуулийн холбогдох заалтыг сонгох эрх болон тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаа учраас үндсэн хуульд нийцээгүй байна гэж шийдвэрлэсэн.

- Энэ шийдвэрээс улбаалан Үндэсний Ассамблей Сонгуулийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 19 - с дээш насны гадаад улсад амьдарч байгаа Солонгос иргэд болон гадаад улсад байнга оршин суудаг Солонгосын иргэдийг Ерөнхийлөгчийн болон пропорциональ төлөөлөгчдийн сонгуульд санал өгөх эрхийг баталгаажуулсан юм.

15) Шөнийн цагаар гадна хуран цугларахыг хориглосон шийдвэрийг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн, 2009 оны 9-р сарын 24.

- Энэ хэрэгт Эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх тухай хуулийн тодорхой тохиолдолд цагдаагийн байгууллагын удирдлага зөвшөөрснөөс гадна нар мандахаас өмнө эсвэл дараа гадна цугларахыг ерөнхийд нь хориглосонтой холбоотой заалт нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүхээс үзсэн. Үүнтэй холбоотойгоор нилээн урт цаг хугацаанд гадна цугларахыг хориглодог байсан нь хэт их хэмжээнд хязгаарлалт тавихыг хориглох зарчмыг зөрчиж хуулийн этгээдүүд хоорондын тэнцвэрт байдлыг алдагдуулж байсан гэж шүүхээс тэмдэглэсэн юм.

- Нийгмийн зарим хэсэг энэ асуудалд анхаарал тавьдаг байсан ч энэхүү шийдвэр гарсанаас хойш цөөн хэдэн тооны хууль бус аюултай цуглаан шөнийн цагаар зохиогдож байсан. Энэхүү шийдвэрийг цуглаан зохион байгуулах эрх чөлөөг баталгаажуулахад хувь нэмэр болсон гэж үнэлдэг юм.

16) Японы цэргийн хүчнийхний үйлчилгээний эмэгтэйчүүд болон цөмийн бөмбөгийн хохирогчдод нөхөн төлбөр өгөх асуудлыг хариуцсан Төрийн байгууллагын захиргааны зөрчлийн талаарх шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй хэрэг, 2011 оны 8-р сарын 30.

- Японы колончлолын үед цэргийн хүчнийхэнд үйлчилж байсан 2,500 эмэгтэйчүүд болон цөмийн бөмбөгийн хохирогчдын үндсэн хуулийн шүүхэд гаргасан гомдлыг хянаж үзээд шүүх хариуцагч (Гадаад хэрэг болон худалдааны яам) япончууд нэр төрийг нь унагаж, үнэлэмжийг нь ноцтойгоор хөндсөн цэргийн хүчнийхэнд үйлчилж байсан эмэгтэйчүүд болон цөмийн бөмбөгийн хохирогчидтой хамтран ажиллаж хамгаалах үүрэгтэй гэж үзсэн. Мөн “Эд хөрөнгө бөгөөд нэхэмжлэх эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх болон БНСУ болон Япон Улс хоорондын Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай гэрээний” 3 дугаар зүйлийн дагуу яам маргаан шийдвэрлэх журмыг баримтлаагүй явдал нь Үндсэн хуулийг зөрчиж гомдол гаргагчдын үндсэн эрхийг хөндсөн байна гэж үзжээ.

- Энэхүү шийдвэр нь Солонгос улс болон Япон улс хоорондын гэрээнд 1965 онд гарын үсэг зурсны дараа нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг засгийн газраас шийдвэрлээгүй явдлыг үндсэн хуулийг зөрчсөн гэж үзээд засгийн газрын харъяа дипломат албад асуудлыг яаралтай шийдвэрлэх даалгавар өгсөн. Шүүхийн шийдвэр гарсны дараа тухайн асуудлыг хэлэлцэх хүсэлт гаргах гэх мэт байдлаар Солонгосын засгийн газар Япон улстай харилцах дипломат харилцаанд илүү хүч чармайлт гаргах болсон.

17) Интернетээр дамжуулан Сонгуулийн компани т үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглох тухай шийдвэрийг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хэрэг, 2011 оны 12-р сарын 29.

- Энэхүү хэрэгт сонгууль болох өдрөөс 180 хоногийн өмнө интернетээр дамжуулан сонгуультай холбоотой улс төрийн итгэл тавих эсвэл компани т ажиллагаа явуулахыг хориглож шийтгэх тухай Төрийн албан хаагчийн сонгуулийн хуулийн заалтуудын үндсэн хуульд нийцэх эсэх асуудлыг хөндсөн байдаг. Интернет нь хамгийн бага үнээр бүгдэд хялбар аргаар хүрэх хэрэгсэл болох учраас улс төрийнх нь кампани т ажлынхаа үнийг нилээн хэмжээгээр бууруулах боломжтой гэж шүүх үзжээ. Газар бүр интернетийн харилцаа холбоо нэвтэрч үе үе давтамжтайгаар сонгууль явагдаж байдаг орчин үед интернетээр дамжуулан улс төрийн илтгэл тавих эрх чөлөө, кампани т ажил явуулах эрхийг сонгуулийн өдрөөс 180 хоногийн өмнөх хүртэл урт хугацаагаар хориглож байгаа явдал нь хэт их хэмжээнд хориг тавих асуудалтай холбоотой хэм хэмжээг зөрчиж улмаар үг хэлэх эрхийг хөндөж байна гэдгийг шүүхийн зүгээс тэмдэглээд тухайн заалтыг хүчингүй болгосон. Интернетийг өргөн хэрэглээдэг мэдээллийн эриний үед нийгэмд үзэл санаагаа интернетээр дамжуулан илэрхийлэх эрх чөлөөг нийтээр хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг тодотгож байгаагаар энэхүү шийдвэр ач холбогдолтой юм.

Ийнхүү өнгөрсөн 24 жилийн хугацаанд Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь Солонгос улсад Үндсэн хуулийн ардчиллыг бэхжүүлэх өөрийн чухал үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд шүүхийн шийдвэрийн практик эрх мэдэл болон төрийн эрх мэдлийн хүчирхийллийг хянаж иргэдийн үндсэн эрхийг бүрэн дүүрэн хамгаалан иргэдийн өдөр тутмын амьдралд амьд зарчим болж байгаа нь үндсэн хуулийг үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хэрэгцээт хэм хэмжээ болгож байна. Түүнчлэн, Солонгос улсын ард иргэд Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд талархаж байдаг. Сүүлийн хэдэн жилийн турш цуглуулсан

санал, үзэл бодолд Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь хамгийн их итгэл үзүүлэхүйц, нөлөө бүхий засгийн газрын институтээр үргэлжлэн тодроод байгаа бөгөөд ард иргэдийн оюун санаанд тэдгээрийн үндсэн эрхийг хамгаалах сүүлийн хамгаалалт гэдгээр бат суусан байна.

4. Солонгосын Үндсэн хуулийн шүүх ажиллагааны цаашдын зорилт

Сүүлийн үед үндсэн хуулийн шүүх ажиллагааг тойрсон орчинд өөрчлөлт орж Солонгосын Үндсэн хуулийн шүүхэд өмнө нь ажиглагдаж байгаагүй шинэ асуудлууд тулгарч байна.

Нэгдүгээрт; Үндэсний бодлогын талаар шийдвэр гаргах гэх мэт улс төр, эдийн засаг эсвэл нийгмийн асуудалтай холбоотой төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэхэд зөрчилдөөн болон үл зөвшилцөл улам их нэмэгдэж байгаа нөхцөлд улс төрийн эсвэл нийгмийн маргаантай асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн зохицуулалтаар шийдвэрлэх хандлага нэмэгдэж байна. Учир нь улс төрийн эсвэл нийгмийн салбарынхан улс төрийн ажиллагаанд зохистой хэлэлцүүлэг, хэлэлцээр хийх замаар үр дүнтэй шийдвэр гаргаж чадахгүй байна.

Үндсэн хууль нь төрийн эсвэл нийгмийн ерөнхий үзэл санаа болон ард түмэн хүлээн авч зөвшөөрөх аргаар бий болсон үнэт зүйлсийг агуулсан дээд хэм хэмжээ юм. Ирээдүйд, Үндсэн хуулийн шүүх нь хүмүүсийн амьдралд үндсэн хуулийн үзэл санаа болон философийг гүн суулгах, нийгэм дэх зөрчилдөөнийг шийдвэрлэх болон нийгмийг үндсэн хуулийн үнэт зүйлс болон хэв журмын үндсэн дээр нэгтгэх зэрэг үйлсэд хичээл зүтгэлээ зориулах ёстой.

Хоёрдугаарт; Өнгөрсөн 50 жилд Солонгос улс эдийн засгийн өсөлт болон ардчилалд харьцангуй богино хугацаанд хүрсэн бөгөөд Үндсэн хуулийн шүүхийг “эрх чөлөөний эрх”-ийг идэвхитэй, эрчимтэй хамгаалж ирснээр Солонгос улсын ардчиллын үйл явцад үнэлэшгүй нэмэр оруулсан гэж өндөрөөр үнэлдэг. Гэхдээ бодит байдалд тулгарч байсан янз бүрийн саад тотгорын улмаас “нийгмийн

эрхийг” баталгаажуулах асуудалд Үндсэн хуулийн шүүх харьцангуй идэвхигүй байсан юм. Үүнтэй холбоотойгоор, миний бодлоор сайн сайхан, баялаг улсыг бий болгохыг зорисон олон улсын хөгжлийн чиг хандлагыг баримтлан “бүгдэд хүртээмжтэй шударга ёс” болон “нийгмийн эрхийг тодорхой болгох” асуудалд илүү анхаарал хандуулах цаг болсон байна.

Мөн 21 дүгээр зуун мэдээллийн шинэ эринд шилжих шилжилтийн зуун байж болзошгүй юм. Энэ үед компьютерийн болон өргөн шугамын өндөр хурдны интернетийн давуу хэрэглээ мөн мэдээллийн холбоо харилцааны хэрэгслийн хөгжил болон SNS үйлчилгээ өргөн тархаж байгаа зэрэг шалтгааны улмаас бидний соёл, нийгэмд олон өөрчлөлт хийгдэж байгааг ажиглаж болно. Энэхүү дэвшилтэт хөгжил биднээс кибер орон зайнд үзэл санаагаа илэрхийлэх эрх чөлөөний асуудал, мөн “мэдэх эрхийг” нэр хүндийн хамгаалалт, хувийн мэдээллийн хамгаалалтын асуудал болон “мартагдах эрх” зэрэг асуудалтай хэрхэн уялдуулан зохицуулах талаар шаардлагатай судалгаа хийж зохих хяналт тавихыг шаардаж болзошгүй юм.

Мөн түүнчлэн Үндсэн хуулийн шүүх төрийн бусад байгууллагуудтай зохих харилцаа тогтоох хэрэг гарч болох юм. Үндсэндээ хууль тогтоох эрх мэдэлтэй холбоотойгоор, хуулийг үндсэн хуульд нийцэж байгаа байдалд хяналт тавьдаг Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоогчийн ардчилсан хууль ёсны эрх мэдлийг бүрэн хэмжээнд хүндэтгэн хууль тогтоох хэр хэмжээг зөвшөөрөх ёстой. Гэхдээ одоогийн байдлаар байгууллага бүрийн гүйцэтгэх үүргийг харилцан хүндэтгэх ёстой гэдгийг шаарддаг. Ердийн шүүхтэй холбоотой харилцааны хувьд Үндсэн хуулийн шүүхийн хяналт тавих эрх мэдэл ердийн шүүхийн хууль тогтоомжийг тайлбарлах эрх мэдэлтэй зөрчилдөж болох боловч эдгээр хоёр байгууллага нь бие биеэ бүрэн хүндэтгэж өөр өөрийнхөө үүргийг биелүүлэх ёстой. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн шүүх ердийн шүүхийн шийдвэрийг өөрийн харъяалалдаа авах мөн

Үндсэн хуулийн шүүхийн гурван шүүгчийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч томилох зэрэг асуудлын хууль ёсны байдлыг нягтлан судлах шаардлагатай юм.

5. Дүгнэлт

Эрхэм төлөөлөгчид, ноёд хатагтай нар аа,

Та бүхний мэдэж байгаачлан, төрийн болон нийгмийн үнэт зүйлсийн талаарх ард түмний зөвшилцлийн үр дүн болох Үндсэн хууль нь амьдралын бүхий л салбарыг бүхэлд нь зохицуулах дээд хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, ертөнцийн үнэт зүйлсийн талаар өөр өөр ойлголт, үзэл бодолтой хүмүүс хамтран амьдарч хамтдаа баялгийг хүртэхийн тулд Үндсэн хуулийн үнэт зүйлс болон журмыг баримтлах шаардлагатай. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь иргэдийн эрх, эрх чөлөө болон үндсэн хуулийн ардчиллын үндэсллийн туйлын хамгаалагчийн үүргийг гүйцэтгэдэг. Бүх иргэд, нийгмийн байгууллагууд болон засгийн газар нь Үндсэн хуулийн үнэт зүйлс болон дэг журмыг дэмждэг улсад үндсэн хуулийн ардчилал гүнзгий үндэслэн үр дүнгээ өгч чадна.

Аливаа Үндсэн хуулийн нэг онцлог нь тодорхой бөгөөд ялгаатай түүхэн үед нь бий болсон хүчин зүйл юм. Гэхдээ энэ нь хүний үндсэн эрхийн хамгаалалт гэх мэт нийтлэг үнэт зүйлсийг агуулж байдаг бөгөөд өнөө үед даяарчлалын улмаас олон улс орон Үндсэн хуулийн нийтлэг шинжтэй байна.

Үүнтэй холбогдуулан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойг тохиолдуулан өнөөдрийн цугларалтыг зохион байгуулж “Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын чиг хандлага” сэдвээр үндсэн хуулийн шүүхийн шийдвэртэй холбоотой туршлага болон мэдээлэл солилцож, Үндсэн хуулийг хөгжүүлэх талаар зөвлөлдөж байгаа явдал нь өндөр ач холбогдол, үнэ цэнэтэй ажил болж байна гэдэгт итгэж байна.

Солонгосын Үндсэн хуулийн шүүх нь энэ жилийн таван сарын сүүлд Азийн Үндсэн хуулийн шүүхүүд болон Адил Институтуудын Анхны Их Хурал болон АҮХШ-

ийн Ази дахь Үндсэн хуулийн шүүхийн талаарх бүсийн форумыг амжилттай зохион байгуулсан. Анхны Их Хурал бол бидний өнгөрсөн гурван жилийн хичээл зүтгэлийн дүгнэлт болсон бөгөөд арван гишүүн улсыг оролцуулан гуч гаруй улс орон, хорь гаруй улсын зочид төлөөлөгчид, ажиглагчид уг үйл явдалд оролцсон билээ. Түүнчлэн 2014 онд 100 гаруй улсын төлөөлөгчид Сөүл хотод хүрэлцэн ирж Үндсэн хуулийн шүүхийн талаарх дэлхийн гуравдугаар их хуралд оролцох юм.

Миний бие дахин өөрсдийн улсын туршлагыг хуваалцах болон Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны талаар эрдэм мэдлэгээ хуваалцах боломж олдоно гэдэгт найдаж байгаа бөгөөд үүнтэй адил олон улсын хамтын үйл ажиллагаа нь удаан хугацаанд Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны хөгжил, түүнчлэн хүн төрөлхтөний аз жаргалд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Эцэст нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга болон энэхүү хуралд оролцох гайхалтай боломжийг надад олгосон зохион байгуулагч нарт өөрийн гүн талархлыг илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Han-Chul Park
Justice, Constitutional Court of Korea

**ESTABLISHMENT OF CONSTITUTIONAL DEMOCRACY AND
CONSTITUTIONAL ADJUDICATION
– FROM THE PERSPECTIVES OF KOREAN EXPERIENCE IN
CONSTITUTIONAL ADJUDICATION**

I. Introduction

¹ Илтгэлд хуулийн заалтуудыг нэмж оруулсны зэрэгцээ бичгийн хэлбэрт оруулан найруулж шаардлагатай тайлбар оруулсан болно.

² Шёнбергер, Кристоф, Карлсруе-гийн тухай, хэвлэсэн: Иештедт, Матиас/Лепсиус, Оливер/Мёллерс, Кристоф/Шёнбергер, Тусгаар тогтносон шүүх, Берлин 2011, Х. 9 (35).

³ Шёнбергер-ийн тайлбарыг үзнэ үү (Тайлбар 2), Х. 27.

II. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ

Дээрхи амжилтууд нь Холбооны Үндсэн хуулийн шүүхэд дэлхийд өөр хаа ч байхгүй өндөр эрх мэдэл, эрх хэмжээ олгогдсонтой салшгүй холбоотой. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс ялгаатай нь Холбооны Үндсэн хуулийн шүүх нь тус бүр 8 шүүгч бүхий ижил тэгш эрхтэй хоёр сенатаас бүрддэг бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллага (ХҮХ-ийн 92-р зүйл) гэдэг утгаараа Бундестаг, Холбооны Засгийн газар гэх мэт төрийн дээд байгууллагуудын хооронд үүссэн маргааныг (ХҮХ-ийн 93-р зүйлийн 1-р хэсгийн 1), түүнчлэн Холбооны улсын хоёр түвшиний бүтэц болох Холбооны улс болон муж улсын хоорондох санал зөрөлдөөнийг шийдвэрлэдэг (ХҮХ-ийн 93-р зүйлийн 1-р хэсгийн 3). Шүүхийн өмнө өдөр тутам тулгардаг гурван төрлийн хэрэг маргаан байдаг. Эдгээр нь

- нэгдүгээрт, хэм хэмжээний хийсвэр хяналт. Хэрэв Холбооны буюу муж улсын эрх зүй Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл Холбооны Засгийн газар, аль нэг муж улсын Засгийн газар эсвэл Бундестагийн бүх гишүүдийн 1/4-ийн санаачлагаар хэм хэмжээний хийсвэр хяналтыг хэрэгжүүлдэг (ХҮХ-ийн 93-р зүйлийн 1-р хэсгийн 2).

- хоёрдугаарт, хэм хэмжээний тодорхой хяналт. Энэ нь аль нэг шүүх тодорхой нэг хэргийг хянан шийдвэрлэх явцдаа тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэж буй Холбооны буюу муж улсын хууль нь Холбооны Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл тус шүүхийн хүсэлтээр хэрэгждэг хяналт юм (ХҮХ-ийн 100-р зүйлийн 1-р хэсэг).

- гуравдугаарт, Үндсэн хууль зөрчсөн асуудлаар гаргасан өргөдөл. Энэхүү өргөдлийг төрийн эрх мэдэл өөрийнх нь үндсэн эрхийг болон үндсэн эрхтэй адилтгах эрхийг (шүүхэд байр сууриа илэрхийлэх гэх мэт) зөрчсөн гэж үзсэн хэн ч гаргах эрхтэй (ХҮХ-ийн 93-р зүйлийн 1-р хэсгийн 4а).

III. Үндсэн хууль зөрчсөн асуудлаар гаргасан өргөдөл ба түүний нөлөө

Маргааны эдгээр төрлүүдээс хамгийн сүүлд дурдсан төрөл нь хэдийгээр олон нийтийг хамарсан биш, тодорхой нэг этгээдэд хамаарах хэдий ч Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 60 жилийн түүхэнд нийт 188 187 удаа шийдвэрлэгдсэн⁴ гэдэг утгаараа хоорондоо хамгийн ойр зайтай, хамгийн олон удаа шийдвэрлэгдсэн, цаашид ч олон тоогоор шийдвэрлэгдэх магадлалтай маргааны төрөлд тооцогддог. Энэ нь эрх зүйн энэ институтын боломж болон Тулгуур хуульд заасан үндсэн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй нь холбоотой.

Үүнд заасны дагуу хүн бүр Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргах эрхтэй. Нас, иргэний харъяаллыг үүнд харгалзахгүй. Мөн хэрэв ХБНГУ-д буюу Европын Холбооны аль нэг гишүүн оронд байрлалтай бөгөөд тухайн өргөдөлд дурдсан үндсэн эрх өөрт нь хамааралтай бол хувьцаат компани гэх мэт хувийн эрх зүйн хуулийн этгээд ч тус шүүхэд хандах эрхтэй (ХҮХ-ийн 19-р зүйлийн 3-р хэсэг). Тэр ч бүү хэл төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид, жишээ нь Холбооны улс, муж улсууд болон тэдгээрийн захиргааны байгууллагууд шүүх процессийг эрх зүйт төрийн зарчмын дагуу шударга явуулахын төлөө, үндсэн эрхтэй адилтгах эрхийг зөрчсөн үндэслэлээр өргөдөл гаргах эрхтэй.

Үндсэн хуулийн маргаанд ялалт байгуулах хамгийн чухал нөхцөл нь Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхийг заавал хамгаалах журам юм. Үндсэн хуулийн эхлэл хэсэгт байх хамгийн гол гол хэм хэмжээнүүдийн нэгд хүний үндсэн эрхийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүхий л байгууллага заавал хамгаалах ёстой байхаар заасан (ХҮХ-ийн 1-р зүйлийн 3-р хэсэг). Өмнө нь зөвхөн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага үндсэн эрхийг

⁴ Энэхүү тоонд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хамгаалахад чиглэсэн (ХҮХ-ийн 28-р зүйлийн 2-р хэсэг) орон нутгийн удирдлагатай холбоотой өргөдөлүүд (ХҮХ-ийн 93-р зүйлийн 1-р хэсгийн 4б) багтсан болно. Эдгээр өргөдлүүд нь тус шүүхийн статистикт тусдаа тоологддоггүй (2011 оны статистик, Х.1). Гэвч тооны хувьд ч, ач холбогдлоороо ч Үндсэн хууль зөрчсөн өргөдлөөс доогуур түвшинд байдаг.

хамгаалах үүрэгтэй байсан бол өнөө үед хууль тогтоох эрх мэдэл ч өөрөө тэдгээрийг үндсэн хуулийн хүрээнд сахин хамгаалах үүрэгтэй болсон байна. Сахих, хамгаалах гэдэг үгс зөвхөн цаасан дээр үлдэх бус, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн өмнөх шатны Үндсэн хуулийн процессийн үеэр ч мөн хэрэгждэг. “Шийдвэрийг хянуулах үндсэн хуулийн өргөдөл” гэж нэрлэгддэг өргөдөлийн тусламжтайгаар иргэд захиргааны байгууллага эсхүл шүүх шийдвэрээ Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний үндсэн эрхийг зөрчсөн хууль, эрх зүйн актад түшиглэж гаргасан гэсэн үндэслэлээр захиргааны акт, ерөнхий харъяаллын шүүхийн шийдвэрийн эсрэг өргөдөл гаргах боломжтой. Олон нийтийг хамарсан асуудлаар иргэд шууд тухайн хууль бус эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн өргөдөл гаргаж болно. Үндсэн хуулийн шүүхэд гаргасан өргөдөл амжилт олсон тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн захиргааны байгууллагын буюу шүүхийн шийдвэр хүчингүй болж хуулиуд илт хууль бус эсхүл Үндсэн хуульд харшилсан гэж тодорхойлогдоно.

IV. Эрх зүйт төрийн зарчмуудыг тодорхой болгох

Ийм боломж нь Үндсэн хуулийг өөрчлөх эрх мэдэл бүхий хууль тогтоогч нар өөрсдөө ч хөндөж үл болох эрх зүйт төрийн хөдлөшгүй зарчмуудыг (ХҮХ-ийн 20-р зүйлийн 3-р хэсгийг 79-р зүйлийн 3-р хэсэгтэй холбож ойлгох) тогтворжуулан хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ ч утгаараа үндсэн хууль зөрсөн асуудлаар гаргаж буй өргөдөлийг эрх зүйт төрийн титэм гэж германд нэрлэдэг нь санамсаргүй хэрэг биш. Эрүүгийн эрх зүйд үйлчилдэг буцаан хэрэглэхийг хориглох заалт (ХҮХ-ийн 103-р зүйлийн 2-р хэсэг), эрх зүйн ойлгомжтой байх зарчим, зөвхөн хуульд тодорхой заасан тохиолдолд ял оноох зарчим, бүх шатны шүүх хүний эрхийг үр нөлөөтэйгээр хамгаалах зарчим (ХҮХ-ийн 19-р зүйлийн 4-р хэсэг), шүүгч эд хөрөнгө, хувь хүний хувьд хараат бус байх зарчим (ХҮХ-ийн 97-р зүйлийн 1 болон 2-р хэсэг) зэрэг нь Үндсэн

хуулийн шүүхээс маргаан шийдвэрлэх бүртээ байнга тодотгож байдаг эрх зүйт төрийн зарчмыг бүрдүүлэгч чухал элементүүд юм.

Шүүхийн практик ч мөн адил Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрх, эрх чөлөөний агуулга, хамрах хүрээнд багтана. 1957 онд Холбооны Үндсэн хуулийн шүүх хувь хүний чөлөөтэй хөгжих эрх (ХҮХ-ийн 2-р зүйлийн 1-р хэсэг) хэмээх үндсэн эрхийн ойлголтыг үйл ажиллагаа явуулах эрх чөлөө хэмээн дэлгэрүүлэн тайлбарласнаар үндсэн эрхийн хамгаалалтанд багтах хувь хүний бүхий л үйл ажиллагаанд төрийн эрх мэдэл саад учруулах боломжгүй болсон⁵. Энэ мөчөөс хойш хүний бүхий л үйл ажиллагаа үндсэн эрхийн хамгаалалтанд багтсан юм.

Гэвч орчин үеийн техникийн дэвшил, түүнийг даган бий болсон хүний эрх чөлөөний эсрэг шинэ аюул заналууд нь Холбооны Үндсэн хуулийн шүүхээс үндсэн эрхийг дээрхи аюул заналын онцлогт тохируулан улам нарийвчлан тодорхойлох шаардлагыг бий болгосон. Үүний эхний алхам болгож хүний чөлөөтэйгээр хөгжих эрх (ХҮХ-ийн 2-р зүйлийн 1-р хэсэг) болон хүний үнэлэмжийн баталгаа (ХҮХ-ийн 1-р зүйлийн 1-р хэсэг) хоёрын нийлбэрээс хувь хүний нийтлэг эрхийг бий болгов. Энэ нь хүний хувийн орон зай болон түүний үндэс суурийг хамгаалах үүрэгтэй байна. Үүнийг ямар нэг төгс жагсаалт гарган тодорхойлох боломж байхгүй хэмжээн шүүх үзсэн байна⁶. Энэхүү эрхийг нарийвчлан тодруулах үүднээс цахим мэдээлэлд халдах магадлал, эрсдлийг харгалзаж үзээд хувь хүн өөрийн хувийн мэдээллийг гагцхүү өөрөө мэдэж захиран зарцуулах эрхтэй гэдэг үндсэн эрхийг бий болгосон. Ингэснээр хувь хүний мэдээлэл хязгаарлалтгүйгээр цацагдах, хадгалагдах, ашиглагдах, дамжуулагдахаас хамгаалагдах, өөрийн хувийн мэдээллийг өгөх эсэхээ тухайн хувь хүн өөрөө мэдэж шийдэх эрхийг баталгаажуулсан⁷. Эцэст нь Холбооны

⁵ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 6-р боть, Х. 32.

⁶ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 54-р боть, Х. 148.

⁷ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 65-р боть, Х. 1.

Үндсэн хуулийн шүүх одоогоос 4 жилийн өмнө виртуаль ертөнцөд зориулж компьютерийн үндсэн эрх гэж олонтаа дурдагдах болсон эрх чөлөөний эрхийг бий болгосон. Энэ эрх мөн л хувь хүний үндсэн эрхээс үүдэлтэй бөгөөд давхар зорилгыг агуулсан. Нэг талаас интернэт мэтийн мэдээллийн технологийн системийн хэрэглэгчийн уг системд үлдээсэн мэдээллийн аюулгүй байдлыг баталгаажуулах, нөгөө талаас системийн халдашгүй байдлыг хамгаалж бусад этгээд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх зорилготой⁸.

Холбооны Үндсэн хуулийн шүүх бас л нэлээд эрт буюу 1958 онд үндсэн эрхүүд нь иргэд гагцхүү төрийн эрх мэдлийн шийдвэрийн эсрэг өргөдөл гарган хамгаалагдах ёстой эрх төдийгүй объектив үнэт зүйлийг агуулсан журам бөгөөд Үндсэн хуулийн хэмжээний суурь шийдвэр гэдэг утгаараа эрх зүйн бүхий л системд тусгагдах ёстой гэж шийдвэрлэсэнээр үндсэн эрхтэй холбоотой бас нэгэн дэвшлийг хийсэн. Жишээ нь үндсэн эрхийн хамгаалалт нь иргэний эрх зүйн түрээслэгч, түрээслүүлэгч нарын хоорондын харилцаанд ч тусгалаа олох ёстой гэж үзсэн⁹. Энэ нь ялангуяа Үндсэн хуулийн шүүхээс төрөлжсөн шүүхийн шийдвэрийн эсрэг гаргасан өргөдөлийг хянан хэлэлцэх үед ихээхэн практик ач холбогдолтой байдаг.

Дээр дурдсан шийдвэрүүд нь төр иргэн, иргэд хоорондын харилцаанд үндсэн эрхийг илүү нарийвчлан тодорхой болгох алхамууд байсан бол Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүн таслах ажиллагааны дараагийн сул цэг нь эрх зүйт төрийн харьцангуй байх зарчмыг хөгжүүлэх, ялгаж салгах явцад бий болсон үндсэн эрхийг хязгаарлах үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн боломжийг хэмжих хэмжүүр бий болгох асуудал зүй ёсоор орж байна. Дээрхи зарчим ёсоор үндсэн эрхийг хязгаарлахын тулд заавал хууль ёсны зорилготой байх, уг зорилгыг биелүүлэхэд дээрхи хязгаарлалтыг хийх боломжтой бөгөөд шаардлагатай, ижил үр дүн үзүүлэх

⁸ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 120-р боть, Х. 274.

⁹ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 7-р боть, Х. 198.

илүү хөнгөн арга хэрэгслээр түүнийг орлуулах боломжгүй байх нөхцлийг бий болгосон. Мөн үндсэн эрхийг ийнхүү хязгаарласнаар олон нийтэд бий болох давуу тал нь үндсэн эрхийг хязгаарлахад үүсэх сөрөг талтай зохистой харьцаанд оршиж байх ёстой гэсэн нөхцөл байдаг¹⁰.

V. Ардчиллын зарчмыг бэхжүүлэх

Ийнхүү нэг талаас эрх зүйт төрийн зарчмууд биелэгдэх үндэс суурь тавигдсан бол нөгөө талаас ардчиллын зарчмыг бүрэлдүүлж бэхжүүлэхэд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх үүрэг түүнээс багагүй ач холбогдолтой. Германд холбооны түвшинд төлөөллийн ардчилал (ХҮХ-ийн 20-р зүйлийн 2-р хэсэг) үйлчилдэг бөгөөд иргэдийн ардчилсан бие даасан шийдвэрийн үндсэн дээр бүх нийтийн, шууд, чөлөөт, тэгш, нууц сонгууль явуулах замаар тодорхой хугацаагаар сонгосон парламент болох Бундестагаар (ХҮХ-ийн 38-р зүйлийн 1-р хэсгийн 1, 39-р зүйлийн 1-р хэсэг) нийгмийн хамтын амьдралын үндсэн асуудлуудыг олон нийтийн хяналтан дор нээлттэйгээр хэлэлцэж олонхийн саналаар шийдвэр гаргах замаар хэрэгждэг. Өөрөөр хэлбэл ХБНГУ-ын бүхий л чухал асуудлыг шийдэхэд иргэд шууд оролцдоггүй, харин бүх асуудал иргэдийг төлөөлөхөөр сонгогдсон Бундестагийн гишүүдээр дамжиж шийдвэрлэгддэг. Ийнхүү парламентийн гаргах шийдвэрт нөлөөлөх иргэдийн нөлөөллийг тэднээс сонгогдсон төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлж байгаа тохиолдолд сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх, ийнхүү дагаж мөрдөж байгаад нь иргэд итгэлтэй байх нь нэн чухал суурь асуудал юм¹¹. Ийм ч учраас Холбооны Үндсэн хуулийн шүүх үүнийг удаа дараа баталгаажуулж сонгуулийн тэгш эрх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэхэд иргэдэд ижил тэгш хандах¹², улс төрийн сонгуульд өрсөлдөж байгаа талуудад ижил тэгш боломж олгох¹³ зэрэг зарчмуудыг тогтвортойгоор бэхжүүлж ирсэн.

¹⁰ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 67-р боть, X. 157-той харьцуулах.

¹¹ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 123-р боть, X. 39-тай харьцуулах.

¹² Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 121-р боть, X. 266.

¹³ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 111-р боть, X. 382.

Саяхныг болтол тус шүүх холбооны болон муж улсуудын парламентууд, ялангуяа Бундестаг ардчиллын зарчмын дагуух үндсэн үүргээ хариуцлагатай хэрэгжүүлж байгаа эсэх, хөнгөн хуумгай хандахгүй байгаа эсэхэд хяналт тавьж ирсэн. Үндсэн эрхийн хэрэгжилт гэх мэт нийтэд чухал ач холбогдолтой асуудлуудыг хууль тогтоох байгууллага гүйцэтгэх эрх мэдэлд даатгалгүйгээр өөрөө хариуцан шийдвэрлэх ёстой¹⁴. Улс орныг батлан хамгаалахаас бусад зорилгоор Холбооны батлан хамгаалах хүчнийг гадаадад ажиллуулахдаа заавал Бундестагаас урьдчилж зөвшөөрөл авдаг¹⁵. ХБНГУ Европын Холбооны гишүүн байх эсэх асуудал ч гэсэн Холбооны Үндсэн хуулийн шүүхээс удаа дараа тэмдэглэж байсанчлан эдүгээ үйлчилж буй Холбооны Үндсэн хуулийн эрх зүйн дагуу ард түмний төлөөлөл болсон Бундестаг улс төрийн онц өндөр ач холбогдолтой үүрэг хариуцлага, бүрэн эрхээ хадгалахын сацуу түүний өмнө улс төрийн хариуцлага хүлээж буй Холбооны Засгийн газар Европын түвшинд асуудал шийдэхэд өөрийн зүгээс тодорхой нөлөө үзүүлж чадна гэж үзсэн тохиолдолд л хэрэгжих боломжтой юм¹⁶.

Эдгээр ардчилсан институциональ хамгаалалтуудыг үндсэн эрхийн баталгаа нөхөн бүрэлдүүлдэг бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүхээс хувь иргэний өргөдлийг шийдвэрлэдэг нь иргэд гагцхүү сонгуулийн өдөр л улс төрийн шийдвэр гаргагчдад нөлөөлөх боломжтой байх гажуудлаас сэргийлдэг. Үүнд харилцааны үндсэн эрхүүд болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэл мэдээлэл, телевиз, радио, кино, мэдээллийн эрх чөлөө (ХҮХ-ийн 5-р зүйлийн 1-р хэсэг) зэрэг үндсэн эрхүүд тэргүүлэх ач холбогдолтой бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүх эдгээр үндсэн эрхүүд нь ХБНГУ-ынх шиг эрх чөлөөт, ардчилсан улс төрийн тогтолцоог цогцлох “үндсийн үндэс” гэж үздэг¹⁷. Учир нь тэдгээрийн

¹⁴ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 83-р боть, X. 130.

¹⁵ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 90-р боть, X. 286.

¹⁶ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 89-р боть, X. 155; 123-р боть, X. 267.

¹⁷ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 20-р боть, X. 56; 27-р боть, X. 88.

тусламжтайгаар сонгуулиас үл хамааран улс төрийн хүсэл зорилгыг бүрдүүлэхэд иргэдийн оролцоо баталгааждаг бөгөөд олон нийтийн санаа бодлыг бий болгох процесс нь парламентийн гаргаж буй шийдвэрт тогтвортой нөлөө үзүүлэх боломжийг бий болгодог. Холбооны Үндсэн хуулийн шүүхээс адил хэмжээгээр анхаарч хамгаалдаг жагсаал цуглаан хийх үндсэн эрх (ХҮХ-ийн 8-р зүйлийн 1-р хэсэг)¹⁸ нь олон нийтээрээ хамтран нэгдмэл нэг үзэл бодолтой байгаагаа ил тодоор, итгэл төрүүлэхүйцээр илэрхийлэх боломжийг олгодог.

VI. Дүгнэлт, баярын мэндчилгээ

Гаргасан бүхийл шийдвэрүүдийнхээ ачаар Холбооны Үндсэн хуулийн шүүх тус улсад эрх зүйт төр, ардчиллын өнцгөөс харвал урьд өмнө хэзээ ч байгаагүй өндөр дээд хэмжээний Үндсэн хуульт ёсны уур амьсгалыг бүрдүүлж чадсан. Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд болон шүүгч нарт тус шүүх үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн халуун мэндийг хүргэхийн ялдамд улс орныхоо хувьд эрхэм чухал ажил албандаа өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөж, ялангуяа Монгол улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-д заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг Монголын ард түмний сайн сайхны төлөө тогтвортойгоор хэрэгжүүлж ажиллахыг ерөөж байна. Анхаарал хандуулж тэвчээртэйгээр сонссонд тань гүнээ талархъя.

¹⁸ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд, 69-р боть, Х. 315; 104-р боть, Х. 104-тэй харьцуулах.

*Dr. Dieter Hömig,
Bundesverfassungsrichter a.D.¹*

DAS BUNDESVERFASSUNGSGERICHT ALS GARANT VON RECHTSSTAATLICHKEIT UND DEMOKRATIE IN DEUTSCHLAND

Sehr geehrter Herr Präsident des Verfassungsgerichts der Mongolei, liebe Kollegen, meine sehr verehrten Damen und Herren!

I. Einleitung

Jubiläen wie dasjenige des Verfassungsgerichts der Mongolei, dem die heutige Veranstaltung gewidmet ist, sind natürlich ein Grund zum Feiern. Sie sind vor allem aber auch Anlass, zurückzublicken auf das, was in den Jahren des eigenen Bestehens erreicht worden ist. In Deutschland war ein solcher Anlass 2011 gegeben, als das mit dem mongolischen Verfassungsgericht durch enge Kontakte verbundene Bundesverfassungsgericht 60 Jahre alt wurde. Es hat dabei viel Lob und Anerkennung erfahren. Das Gericht habe, so ist aus diesem Anlass geschrieben worden, vor allem mit seiner Rechtsprechung zu den Grund- und Freiheitsrechten der deutschen Verfassung, des Grundgesetzes für die Bundesrepublik Deutschland (im Folgenden: GG), und durch die Aktivierung dieser Rechte schrittweise zu einer „Liberalisierung des deutschen Rechts und der deutschen Gesellschaft“ beigetragen.² Und es habe sich auch erfolgreich als Geburtshelfer der modernen deutschen Demokratie betätigt und bewährt.³

II. Macht- und Kompetenzfülle des Bundesverfassungsgerichts

Beides wäre ohne die wohl weltweit einzigartige Macht- und Kompetenzfülle des Bundesverfassungsgerichts nicht möglich gewesen. Das – anders als das Verfassungsgericht

¹ Der Vortrag ist nachträglich um die Angabe einschlägiger Verfassungsnormen und um einige um der wissenschaftlichen Redlichkeit willen notwendige Fußnoten ergänzt worden.

² Schönberger, Christoph, Anmerkungen zu Karlsruhe, in: Jestaedt, Matthias/Lepsius, Oliver/Möllers, Chris-toph/Schönberger, Das entgrenzte Gericht, Berlin 2011, S. 9 (35).

³ Vgl. Schönberger (Fußn. 2), S. 27.

der Mongolei – aus zwei gleichberechtigten Senaten mit jeweils acht Richtern zusammengesetzte Gericht hat als Organ der rechtsprechenden Gewalt (Art. 92 GG) sowohl über Konflikte zwischen den obersten Staatsorganen, etwa Bundestag und Bundesregierung, zu entscheiden (Art. 93 Abs. 1 Nr. 1 GG) als auch Meinungsverschiedenheiten zwischen dem Bund und den Bundesländern der föderal in zwei Ebenen gegliederten Bundesrepublik auszuräumen (Art. 93 Abs. 1 Nr. 3 GG). Im Verfassungsalltag am wichtigsten sind freilich drei Verfahrensarten, in denen geprüft wird, ob Recht im Rang unterhalb der Verfassung mit dieser in Einklang steht. Es sind dies

- erstens die abstrakte Normenkontrolle, die von der Bundesregierung, jeder Landesregierung oder einem Viertel der Mitglieder des Bundestags veranlasst werden kann, wenn Meinungsverschiedenheiten oder Zweifel über die Vereinbarkeit von Bundes- oder Landesrecht mit dem Grundgesetz bestehen (Art. 93 Abs. 1 Nr. 2 GG),

- zweitens die konkrete, durch ein konkretes Gerichtsverfahren ausgelöste Normenkontrolle auf Vorlage eines Fachgerichts, wenn dieses davon überzeugt ist, dass ein Bundes- oder Landesgesetz, auf dessen Gültigkeit es bei seiner Entscheidung ankommt, gegen das Grundgesetz verstößt (Art. 100 Abs. 1 GG), und schließlich

- drittens die Verfassungsbeschwerde, die als Individualbeschwerde jedermann mit der Behauptung erheben kann, durch die öffentliche Gewalt in einem seiner Grundrechte oder in einem diesen gleichgestellten Recht wie dem Recht auf Gehör vor Gericht verletzt zu sein (Art. 93 Abs. 1 Nr. 4a GG).

III. Die Individualverfassungsbeschwerde und ihre Wirkungen

Von diesen Verfahrensarten ist die zuletzt genannte Verfassungsbeschwerde diejenige, die, obwohl nicht als Popularklage, sondern als Betroffenenrechtsbehelf konzipiert, mit 188.187

Eingängen⁴ in 60 Jahren mit Abstand am häufigsten in Anspruch genommen wurde und weiterhin in Anspruch genommen wird. Das liegt im Wesentlichen an der rechtlichen Ausgestaltung dieses Rechtsinstituts und an den Rahmenbedingungen des Grundrechtsschutzes im Grundgesetz.

Danach kann jede natürliche Person Individualverfassungsbeschwerde beim Bundesverfassungsgericht einlegen; auf Alter und Staatsangehörigkeit kommt es im Ergebnis nicht an. Auch juristische Personen des Privatrechts, beispielsweise Aktiengesellschaften, sind beschwerdeberechtigt, sofern sie ihren Sitz in Deutschland oder in einem anderen Mitgliedstaat der Europäischen Union haben und das geltend gemachte Grundrecht seinem Wesen nach auf sie anwendbar ist (Art. 19 Abs. 3 GG). Selbst staatliche Hoheitsträger wie der Bund, die Länder und ihre Behörden können sich mit der Individualverfassungsbeschwerde auf grundrechtsähnliche Rechte berufen, soweit es sich bei diesen um prozessuale Schutzrechte wie das Recht auf ein willkürfreies, faires rechtsstaatliches Gerichtsverfahren handelt.

Wesentlich für den Siegeszug der Verfassungsbeschwerde ist darüber hinaus die durch das Grundgesetz vorgegebene umfassende Grundrechtsbindung. Gleich am Anfang des Verfassungstextes wird in einer der wichtigsten Verfassungsnormen festgelegt, dass die Grundrechte Gesetzgebung, vollziehende Gewalt und Rechtsprechung als unmittelbar geltendes Recht binden (Art. 1 Abs. 3 GG). Nicht mehr wie früher nur Exekutive und Judikative sind danach an die Grundrechte gebunden. Auch der Gesetzgeber selbst muss sie jetzt von Verfassungs wegen achten und wahren. Und beides steht nicht nur auf dem Papier, kann vielmehr im Verfassungsprozess vor dem Bundesverfassungsgericht auch durchgesetzt werden. Mit der so genannten Urteilsverfassungsbeschwerde kann der Bürger Behördenakte und Entscheidungen der allgemein zuständigen Gerichte angreifen und auch

⁴ Diese Zahl umfasst auch die der Verteidigung der kommunalen Selbstverwaltung (Art. 28 Abs. 2 GG) dienende Kommunalverfassungsbeschwerde nach Art. 93 Abs. 1 Nr. 4b GG, die in den Statistiken des Bundesverfassungsgerichts nicht gesondert ausgewiesen wird (vgl. Jahresstatistik 2011, S. 1), aber an Häufigkeit und Bedeutung deutlich hinter der Individualverfassungsbeschwerde zurückbleibt.

geltend machen, dass Gesetze und andere Rechtsnormen, die von den Behörden und Gerichten diesen Entscheidungen zugrunde gelegt wurden, den Grundrechten der Verfassung widersprechen. In Fällen von allgemeiner Bedeutung kann er mit der so genannten Rechtssatzverfassungsbeschwerde sogar unmittelbar gegen Rechtsnormen vorgehen. Hat die Verfassungsbeschwerde Erfolg, werden verfassungswidrige Behörden- und Gerichtsentscheidungen aufgehoben, also kassiert, und gegen die Verfassung verstoßende Gesetze für nichtig oder mit dem Grundgesetz unvereinbar erklärt.

IV. Konkretisierung des Rechtsstaatsprinzips

Schon diese Möglichkeiten und Konsequenzen tragen wesentlich zur Stabilisierung des im Kern selbst für den verfassungsändernden Gesetzgeber unantastbaren Rechtsstaatsprinzips (Art. 20 Abs. 3 in Verbindung mit Art. 79 Abs. 3 GG) bei. Mit Recht wird die Verfassungsbeschwerde deshalb in Deutschland oft als Krönung des Rechtsstaats bezeichnet. Rechtssicherheit, beispielsweise dank des für Strafgesetze geltenden absoluten Rückwirkungsverbots (Art. 103 Abs. 2 GG), Rechtsklarheit, Gesetzesbestimmtheit, effektiver Rechtsschutz durch alle Gerichte (Art. 19 Abs. 4 GG) sowie sachliche und persönliche Unabhängigkeit sämtlicher Richter (Art. 97 Abs. 1 und 2 GG) sind weitere Bausteine des durch das Bundesverfassungsgericht in ständiger Rechtsprechung konkretisierten Rechtsstaatsprinzips.

Dazu kommt die Judikatur des Gerichts zu Inhalt und Reichweite der im Grundgesetz garantierten Grundrechte und Freiheiten. Bahnrechend war insoweit schon 1957 die Ausweitung des Schutzzumfangs der Grundrechte, als das Gericht das Grundrecht auf freie Entfaltung der Persönlichkeit (Art. 2 Abs. 1 GG) als Handlungsfreiheit im umfassenden Sinne interpretierte, auf die sich der Einzelne bei Eingriffen der öffentlichen Gewalt in seine Freiheit immer dann berufen kann, wenn für den durch den Eingriff betroffenen Lebensbereich spezieller Grundrechtsschutz nicht gewährleistet ist.⁵ Seitdem ist kein menschliches Verhalten mehr denkbar, das nicht grundrechtlich geschützt wäre.

⁵ BVerfGE 6, 32 = Entscheidungen des Bundesverfassungsgerichts Band 6, S. 32.

Allerdings haben moderne technische Entwicklungen und die mit ihnen zwangsläufig verbundenen Gefahren für die menschliche Freiheit das Bundesverfassungsgericht später immer wieder veranlasst, aus den vorhandenen Grundrechten neue, auf diese Gefahren ausgerichtete Grundrechtsausprägungen abzuleiten. Als Erstes ist so aus der Kombination von freier Persönlichkeitsentfaltung (Art. 2 Abs. 1 GG) und Menschenwürdegarantie (Art. 1 Abs. 1 GG) das allgemeine Persönlichkeitsrecht entstanden, dessen Aufgabe es ist, die engere persönliche Lebenssphäre und die Erhaltung ihrer Grundbedingungen zu schützen, die sich nach Meinung des Gerichts durch die überkommenen Freiheitsgarantien nicht abschließend erfassen lassen.⁶ Als Konkretisierung dieses Rechts ist sodann unter dem Eindruck der Möglichkeiten und Gefahren der elektronischen Datenverarbeitung das Grundrecht auf informationelle Selbstbestimmung entwickelt worden, das den Einzelnen gegen die unbegrenzte Erhebung, Speicherung, Verwendung und Weitergabe seiner persönlichen Daten schützen soll und ihm garantiert, grundsätzlich selbst über deren Preisgabe und Verwendung zu entscheiden.⁷ Schließlich hat das Bundesverfassungsgericht im Zeitalter des Internets vor vier Jahren der virtuellen Welt ein vielfach als Computergrundrecht bezeichnetes Freiheitsrecht geschenkt. Auch dieses Recht ist aus dem allgemeinen Persönlichkeitsrecht hervorgegangen, und es dient einem doppelten Zweck. Einerseits soll die Vertraulichkeit von Daten, die der Nutzer informationstechnischer Systeme wie des Internets auf diesen Systemen hinterlässt, garantiert werden, andererseits sollen die Integrität solcher Systeme geschützt und Manipulationen an ihnen sowie unberechtigte Zugriffe auf sie abgewehrt werden können.⁸

Ein weiterer Meilenstein in der Grundrechtsjudikatur des Bundesverfassungsgerichts ist ebenfalls schon früh gesetzt worden, als das Gericht 1958 entschied, dass die Grundrechte nicht nur Abwehrrechte sind, mit denen sich der Bürger gegen ungerechtfertigte staatliche Hoheitsakte zur Wehr setzen

⁶ BVerfGE 54, 148.

⁷ BVerfGE 65, 1.

⁸ BVerfGE 120, 274.

kann, sondern auch eine objektive Wertordnung verkörpern, die als Grundentscheidung der Verfassung auf die gesamte Rechtsordnung ausstrahlt, auch soweit diese – wie im Zivilrecht – die Rechtsbeziehungen zwischen Privaten, etwa dem Vermieter und Mieter einer Wohnung, regelt.⁹ Das ist vor allem dort von großer praktischer Bedeutung, wo das Bundesverfassungsgericht im Verfahren der Urteilsverfassungsbeschwerde die Entscheidungen der Fachgerichte überprüft.

Ging es in all diesen Fällen um die Reichweite und Verfeinerung der Grundrechte im Verhältnis des Staates zu seinen Bürgern und im Verhältnis der Bürger untereinander, so betraf die nächste Weichenstellung in der Rechtsprechung des Bundesverfassungsgerichts mit der Entwicklung und Ausdifferenzierung des rechtsstaatlichen Verhältnismäßigkeitsgrundsatzes die Bildung von Maßstäben für nach der Verfassung mögliche Grundrechtsbeschränkungen. Immer darf eine solche Beschränkung nach diesem Grundsatz nur vorgenommen werden, wenn sie einem legitimen Ziel dienen soll und zur Erreichung dieses Zieles geeignet und erforderlich ist, also nicht durch ein gleich wirksames, aber weniger belastendes Mittel ersetzt werden kann. Schließlich muss die Grundrechtsbeeinträchtigung in einem angemessenen Verhältnis zu Gewicht und Bedeutung des betroffenen Grundrechts und zu den der Allgemeinheit aus der Beschränkung erwachsenden Vorteilen stehen.¹⁰

V. Festigung des Demokratieprinzips

Sind auf diese Weise die Grundlagen für ein hohes Maß an Rechtsstaatlichkeit gelegt worden, so sind Ausgestaltung und Festigung des Demokratieprinzips durch das Bundesverfassungsgericht nicht minder bedeutsam. Die Demokratie ist in Deutschland auf der Ebene des Bundes eine repräsentative Demokratie (Art. 20 Abs. 2 GG), getragen vom Deutschen Bundestag als einem Parlament, das vom Volk in demokratischer Selbstbestimmung, in allgemeinen, unmittelbaren, freien, gleichen und geheimen Wahlen, auf Zeit

⁹ BVerfGE 7, 198.

¹⁰ Vgl. BVerfGE 67, 157.

gewählt wird (Art. 38 Abs. 1 Satz 1, Art. 39 Abs. 1 GG) und im Streit um die beste Lösung über Grundsatzfragen des gesellschaftlichen Zusammenlebens in öffentlicher Debatte und damit für jeden kontrollierbar nach dem Mehrheitsprinzip entscheidet. Alle für Deutschland wichtigen Entscheidungen werden also nicht von den Bürgern unmittelbar, sondern ausnahmslos von den Abgeordneten des Bundestages als den Vertretern des ganzen Volkes getroffen. Ist der Einfluss des Bürgers auf die Beschlüsse des Parlaments auf diese Weise mediatisiert, sind die Beachtung der genannten Wahlrechtsgrundsätze und das Vertrauen der Bürger in ihre Beachtung für die Funktionsfähigkeit der mittelbaren Demokratie in Deutschland existentiell.¹¹ Das Bundesverfassungsgericht hat sie deshalb auch immer wieder bekräftigt und vor allem die Wahlrechtsgleichheit mit der Gleichbehandlung aller Staatsbürger bei der Ausübung des Wahlrechts¹² und die Chancengleichheit der Wahlbewerber im politischen Wettbewerb um Mandate¹³ nachhaltig gestärkt.

Bis in die jüngste Zeit hat das Gericht auch dafür gesorgt, dass die Parlamente des Bundes und der Länder, vor allem aber der Deutsche Bundestag, ihre vom Demokratieprinzip geforderten Hauptfunktionen verantwortungsbewusst wahrnehmen und nicht leichtfertig preisgeben. Entscheidungen über Angelegenheiten, die für die Gemeinschaft, zumal im Bereich der Grundrechtsausübung, wesentlich sind, sind vom Gesetzgeber selbst zu fällen und dürfen nicht dem Handeln und der Entscheidungsmacht der Exekutive überlassen werden.¹⁴ Der Auslandseinsatz der Bundeswehr, also der deutschen Streitkräfte, ist auch außerhalb des Verteidigungsfalls nur erlaubt, wenn ihm der Bundestag – grundsätzlich vor dem Beginn der Auslandsverwendung – zustimmt.¹⁵ Und die Mitgliedschaft Deutschlands in der Europäischen Union ist, wie das Bundesverfassungsgericht inzwischen mehrfach betont hat, nach geltendem Verfassungsrecht nur möglich, wenn der das Volk

¹¹ Vgl. BVerfGE 123, 39.

¹² BVerfGE 121, 266.

¹³ BVerfGE 111, 382.

¹⁴ BVerfGE 83, 130.

¹⁵ BVerfGE 90, 286.

repräsentierende Bundestag eigene Aufgaben und Befugnisse von substantiellem politischem Gewicht behält und die ihm politisch verantwortliche Bundesregierung maßgeblichen Einfluss auf die auf europäischer Ebene zu treffenden Entscheidungen nehmen kann.¹⁶

Ergänzt werden diese institutionellen demokratischen Sicherungen durch grundrechtliche Gewährleistungen, die das demokratische Prinzip nach der Rechtsprechung des Bundesverfassungsgerichts auch individuell stützen und vermeiden, dass der Bürger in Deutschland nur am jeweiligen Wahltag Einfluss auf die politischen Entscheidungsträger ausüben kann. Im Vordergrund stehen dabei die Kommunikationsgrundrechte der Meinungs-, Presse-, Rundfunk-, Fernseh-, Film- und Informationsfreiheit (Art. 5 Abs. 1 GG), die nach dem Verständnis des Bundesverfassungsgerichts für eine freiheitliche demokratische Staatsordnung wie diejenige der Bundesrepublik Deutschland „schlechthin konstituierend“ sind,¹⁷ weil sie allen dort lebenden Menschen das Recht auf Teilhabe an der politischen Willensbildung auch unabhängig von Wahlen garantieren und damit im Prozess der öffentlichen Meinungsbildung die Möglichkeit bieten, permanent auf die in den Parlamenten fallenden Entscheidungen einzuwirken. Die vom Bundesverfassungsgericht gleichermaßen gewürdigten Grundrechte der Versammlungs- und Demonstrationsfreiheit (Art. 8 Abs. 1 GG)¹⁸ treten als Instrumente kollektiver Meinungskundgabe zur Sichtbarmachung gemeinsamer Überzeugungen verstärkend hinzu.

VI. Schluss und Gratulation

Das Bundesverfassungsgericht hat nach allem mit seiner Rechtsprechung in Deutschland ein Verfassungsklima geschaffen, wie es dies vorher – und darauf bin ich stolz - unter Aspekten der Rechtsstaatlichkeit und der Demokratie noch nie gegeben hat. Ich wünsche dem Verfassungsgericht der Mongolei und seinen Richtern zum 20. Geburtstag des Gerichts – ganz

¹⁶ BVerfGE 89, 155; 123, 267.

¹⁷ BVerfGE 20, 56; 27, 88.

¹⁸ Vgl. BVerfGE 69, 315; 104, 104.

im Sinne dieser Judikatur – weiterhin Durchsetzungskraft und viel Erfolg bei der Fortsetzung ihrer für ihren Staat so wichtigen Arbeit, vor allem aber wünsche ich dem Gericht, dass es Art. 1 Abs. 2 der mongolischen Verfassung, der die Grundprinzipien der staatlichen Tätigkeit in Ihrem Lande bestimmt, zum Wohle des Volkes der Mongolei auch künftig dauerhaft mit Leben erfüllt. Für Ihre Aufmerksamkeit und für Ihre Geduld danke ich Ihnen sehr herzlich!

*Доктор, профессор Енгин Илдирим,
БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч*

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ БА АРДЧИЛАЛ: ТҮРКИЙН ИРЭЭДҮЙ

Сүүлийн хэдэн арван жилд бид дэлхий даяар шүүх эрх мэдэл өргөжин нэмэгдэж байгааг ажиглаж байна. Үндсэн Хуулийн шүүх нь хууль тогтоох байгууллага буюу ардчилсан ёсны дагуу сонгогдсон хууль тогтоогчдын гаргасан хууль тогтоомжийг үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоох эрх мэдэлтэй болсон. Үндсэн хуулийн шүүх орчин үеийн ардчилсан нийгэмд чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч түүний эрх мэдлийн тухай асуудлыг улс төрийн болон философийн онолын зүгээс авч үзвэл тун маргаантай хэвээр байна. Ардчилал болон ардчилсан засаглалыг хөгжүүлэх явдалд түүний гүйцэтгэх үүргийг яавч үл тоомсорлож бологүй билээ.

Үндсэн хуулийн шүүх нийгэмд ардчилалын үүрэг гүйцэтгэгч болох асуудал нь маргаантай асуудал юм. Үндсэн Хуульд ёсыг хатуу баримтлагчид үндсэн хуулийн шүүхгүйгээр үндсэн эрхийг тийнхүү сайн хамгаалж чадахгүй бөгөөд үндсэн хуулийн хамгаалалтгүйгээр хувь хүний эрхүүд ардчилсан дийлэнх олонхийн зүгээс тогтмол зөрчигдөж байх болно гэдгийг онцолж байдаг.

Үндсэн хуульд ёсыг хатуу баримтлагчдийн эсрэг үзэлтнүүд нь шууд сонгогдсон парламентаас шууд бус байдлаар сонгосон шүүгчид рүү шийдвэр гаргах ажиллагааг шилжүүлж буй явдал ардчилалыг дордуулж байна гэж үзэж байгаа юм (Strauss 1999).

Төр нь улс төрийн суурь эрхүүд болон иргэний эрх чөлөөг үл зөрчинө хэмээн тунхаглан зааж өгснөөр Үндсэн Хуулийн шүүх ардчилалын хөгжилд ихээхэн хувь нэмэр болж байдаг. Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтын арга болох шүүхэд тулгуурласан үндсэн

хуулийн шүүхийн хяналтыг үндсэн хуульт ёсны хөгжлийн нэг чухал амжилт гэж үздэг. Шүүх эрх мэдлийн талаарх хоёр төрлийн ном зохиолууд байна. Нэгдүгээрт, шүүх өргөн хэмжээний улс төрийн үүргийг гүйцэтгэх болсон байдлыг “эрхийн хувьсгал”-н илэрхийлэл хэмээн үзэх санаа бүхий ном зохиолуудын зэрэгцээ *гүйцэтгэх эрх мэдлийн ажиллагаанд хэтэрхий их шүүхийн хяналт тавих байдлыг* (judicialization) нийгэмд давамгайлж буй элитүүд өөрийн давуу эрхээ гарч ирж буй сөрөг элитүүдээс хамгаалах гэсэн санаатай оролдлогын нэг илэрхийлэл хэмээн үзэх санаа бүхий ном зохиолууд байна (Shambayati and Kirdis 2009: 761). Шүүх эрх мэдлийн идэвхитэй байдлыг шүүмжлэгчдийн ихэнх нь шүүх болон шүүгчдийг хэтэрхий идэвхи гаргаж, ёс суртахууны болон улс төрийн шийдвэр гаргах явдалд хэтэрхий орооцолдож улмаар эрх мэдлийн хуваарилалт болон ардчилсан засаглалын зарчмуудыг үл тоомсорлох байдал гаргаж байна гэж шүүмжилж байна. Шүүх болон шүүгчдийг эх сурвалж эсвэл муу муухай зүйлийн уурхай хэмээн дүрслэх явдал нь буруу зүйл юм. Шүүх нь улс төр, байгууллага болон үзэл санааны хоосон орон зайд үйл ажиллагаагаа явуулдаггүй. Шүүх эрх мэдэл нь улс төрөөс үүдэлтэй бүрддэг. Шүүх эрх мэдлийн үндсэн хуульт ёс буюу шүүхийн хяналтаар дамжин өргөжиж буй явдал нь нийгмийн, соёлын, улс төрийн болон эдийн засгийн тодорхой тэмцлийг тусад нь бий болгодоггүй.

Үндсэн хуулийн шүүх нь өөрийн эрх мэдлийг зөв ашиглаж чадаж байвал мөн ардчилалын төлөө үйл ажиллагаагаа явуулж байвал ардчилсан засаглалд эерэг үүрэг гүйцэтгэж чадах юм. Өөрийн эрх мэдлийг зөв ашиглаж чадахгүй байгаа шүүх нь ардчилалд хор учруулах байдлаар төрийн бусад салбарын зардлаар өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглаж байгаа шүүхийн адил хор уршигтай байдаг юм. Байгууллагын хувьд Үндсэн Хуулийн шүүх нь хүчтэй эрх мэдэлтэй, нээлттэй, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны байдалтай байгаа тохиолдолд ардчилалын чанарыг сайжруулах боломжтой юм. Янз бүрийн улс төрийн шүүх болон иргэд Үндсэн хуулийн

шүүхэд хандах боломж улам өргөн болж байгаа байдал шүүхийн бат бөх байр суурийг шууд нэмэгдүүлж байгаа юм.

Үндсэн хуулийг төрийн тусгай бодлогыг үр дүнтэй явуулах хэрэгсэл гэхээс илүү ерөнхийд нь шударга ёсны байдал болон шударгаар шүүх ажиллагаа явуулах байдалд хүргэх хэрэгсэл гэж үзэх шаардлагатай юм. Үндсэн хуульт ардчилсан нийгэмд “эрхийн ухамсар” хэмээх ойлголтыг хөгжүүлэх ерөнхий бөгөөд чухал хандлага бий болоод байгаа. Тодорхой нөхцөл байдалд шүүх өөрийгөө улс төрөөс дээгүүр байр сууринд тавих боломжтой болж улмаар энэ нь нийгэмд таалагдахгүй шийдвэр гаргахыг шүүхэд зөвшөөрдөг. Ёс суртахууны эрх буюу эрх мэдэл гэдэгт хүмүүс өөрсдөө хатуу эсэргүүцэж байгаа шүүхийн шийдвэрээ хүлээж авахыг ойлгоно. Учир нь хүмүүс шүүхийг тийм шийдвэр гаргах эрх бүхий байгууллага гэж үздэг (Lutz :128).

Хэдийгээр дэлхий нийтэд шүүх эрх мэдлийн нөлөө нэмэгдэж эрхийн төлөө өөрчлөлтүүд хийгдэж байгаа боловч Туркийн Үндсэн хуулийн шүүх иргэдийн эрх чөлөөний талаарх хориглосон үзэл бодлоо /хандлага/ өөрчилж, шинэчлэгдсэн юм. (Belge. 2006: 653).

Турк улсад 1960-аад он хүртэл үндсэн хуулийн хяналтын систем байгаагүй. Туркийн Үндсэн хуулийн шүүхийг 1960 оны 5 дугаар сарын 27-ны цэргийн эргэлтийн дараа боловсруулсан Үндсэн хуулиар байгуулсан юм. 1961 оны Үндсэн хууль нь хууль тогтоогч нарын гаргасан эрх зүйн актыг хянах зорилгоор энэхүү байгууллагыг бий болгосон. Үндсэн хуулийн шүүхийг байгуулах гол шалтгаан нь Турк улсын Үндсэн хуулийг хэд хэдэн удаа зөрчих, ялангуяа 1950-аас 1960 оны хооронд, мөн үндсэн хуулийн хяналт байхгүй учраас эдгээр зөрчилд шийтгэл ногдуулаагүй бөгөөд улмаар цэргийн бослогыг зөвтгөх үндэслэл болсон зэрэг явдал байсан юм.

1961 оны Үндсэн хуулийг үндэслэгчид хууль тогтоомжуудын үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах

үүрэгтэй үндсэн хуулийн шүүхийн шаардлага байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Шүүхийн бүтэц, бүрэлдэхүүн болон зохион байгуулалт мөн шүүгчдийг сонгох арга болон үндсэн хуульд нийцсэн байдлыг хянах асуудлын талаарх маргаан хэлэлцүүлэгээс гадна үндсэн хуулийн шударга ёсыг баримтлах шаардлага байна гэсэн нийтлэг үзэл санаа байсан юм.

Турк улсын Үндсэн хуулийн шүүх 1962 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 1980 оны цэргийн эргэлтийн дараа 1982 онд шинэ Үндсэн хууль батлагдсан. 1961 оны Үндсэн хуулиар байгуулсан үндсэн хуулийн хяналтын систем цөөн тооны өөрчлөлттэйгээр 1982 оны Үндсэн хуульд хадгалагдан үлдсэн юм. Тиймээс Үндсэн хууль шүүх эрх мэдэлд чухал эрх мэдлийг хадгалуулсан. Үндсэн хуулийн шүүхийн бүтэц болон үүрэгтэй холбоотой аливаа өөрчлөлт хийх тохиолдолд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай юм. Үндсэн хуулийн шүүхийн гол үүрэг нь хууль тогтоомж болон Үндсэн хуульд заасан бусад хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах явдал юм.

Турк улсын Үндсэн хуулийн шүүхийн эрх мэдэл ардчилсан хууль ёсноос бус харин түүнийг үүсгэн байгуулагчид үзүүлж буй итгэлээс үүсэлтэй, тиймээс ч Үндсэн хуулийн шүүх нь эрх, эрх чөлөөний шүүх гэхээс илүү төрийн хамгаалагч болж байгаа юм.

1962 онд байгуулагдснаас хойш 1999 он хүртэл Туркийн Үндсэн хуулийн шүүх хянаж үзсэн хууль тогтоомжуудын талаас их хувийг нь хүчингүй болгож байсан. Туркийн Үндсэн хуулийн шүүхээс үзэл санааны хувьд хийсэн хяналт 1962 он болон 1982 оны хооронд 65%, 1982-1983 онуудад 82% байсан бол ижил ажиллагааны хувь Франц улсад 1981-2000 онуудад 54%, 1991-2000 онуудад Герман улсад 53%, харин Испани улсад 1981-1990 онуудад 52% байжээ (Stone Sweet quoted in Beige 2006: 665). Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн шүүх 46 жилийн түүхэндээ улс төрийн намыг татан буулгахтай

холбоотой 47хэргийг хянаж хэлэлцсэн. Эдгээр 47 хэргээс зөвхөн 6 хэргийг 1961 оноос 1982 оны хооронд шийдвэрлэсэн байхад 1982 оны цэргийн эргэлтийн дараа 41 нэхэмжлэлийн шаардлагаар улс төрийн 33 намыг татан буулгасан шийдвэр гарч байсан.

Үндсэн хуулийн шүүх нь Турк улсын улс төрийн амьдрал болон хууль зүйн тогтолцоонд гол бөгөөд маргаантай байр суурийг эзэлдэг. Түүний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар ялгаатай үзэл бодол илэрхийлдэг. Зарим нь түүний Үндсэн хуулийн суурь үнэт зүйлсийг хянах үүргийг магтдаг бол бусад нь үйл ажиллагааг нь хурц шүүмжилдэг. Шүүмжлэгчид Үндсэн хуулийн шүүхийг улс төрийн салбарын хүрээг тодорхойлох гэсэн оролдлогыг шүүмжлэхдээ энэ үүргийг улс төрийн намууд гүйцэтгэнэ гэж маргадаг.

Шүүхийн үүрэг нь түүний түүхэн хөгжлийн турш бүгд найрамдах засаглал тогтсоноос хойш тогтоосон дэглэм болон байгууллыг хамгаалах зорилгыг баримталсан байнгын бөгөөд нэг хэвийн үүрэг байсан. Энэхүү үүрэг нь түүний хууль тогтоомж болон практик үйл ажиллагаатай төгс нийцдэг. Олон хэрэгт урьдчилан тогтоосон дэглэмд аюул заналхийлж байна уу, энэхүү аюулыг зохицуулахад ямар үйл ажиллагаа хамгийн сайн ажиллагаа болох вэ гэдгийг харгалзан үзсэн байдаг. Олон хэрэгт үзэгдэхүйц/мэдэгдэхүйц идэвхитэй байдаг хүчтэй улс төрийн хүчин байдаг боловч хүний эрхийг хөндсөн зэрэг зарим маргаантай тохиолдолд шүүх дуу хоолойгоо илэрхийлдэггүй (Belge 2006). Өөрөөр хэлбэл, төрийн ашиг сонирхолд заналхийлж буй тохиолдолд чимээгүй байх байр суурьтай байж зөвхөн сонголтоор улс төрийн идэвхи гаргадаг. Туркийн Үндсэн хуулийн шүүх нь төрийн ашиг сонирхлыг анхааран “үзэл санаанд тулгуурласан” аргыг баримталдаг гэж үздэг.

1990-ээд оны туршид Туркийн Үндсэн хуулийн шүүх Турк улсын ардчилалыг эрх чөлөөтэй болгох чиг шугамыг баримталж байсан. Энэ үе нь Зүүн Европ болон Өмнөд

Африкийн улс орнууд ардчилал руу амжилттай шилжиж байсан үе юм. Туркийн Үндсэн хуулийн шүүх улс төрийн салбарт “хасагдсан” буюу хүлээн зөвшөөрөгдөөгүй хүмүүсийг оруулах гэж оролдож байсан улс төрийн намуудыг хүчингүй болгож байснаараа илүү олон ургалч ардчиллыг хөгжих замд саад учруулж байсан. Авторитар шинжтэй Туркийн Үндсэн хууль Туркийн Үндсэн хуулийн шүүхийн үзэл санаанд тулгуурласан арга барилаас салахад нь саад болж байсан нь үнэн юм. Хэдий тийм боловч, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Үндсэн хуулийн заалтууд нь тодорхой бус, ерөнхий байдлаар тодорхойлогдсон байсан бөгөөд Туркийн Үндсэн хуулийн шүүх тэрхүү заалтуудыг өөрийн үзэмжээр ардчилсан байдлаар тайлбарлах эрхтэй байсан бас үнэн юм.

Саяхан явагдсан үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх олон нийтийн санал асуулгын явцад Туркийн Үндсэн хуульд үндсэн эрх нь зөрчигдсөн хүмүүс тодорхой нөхцөлд хууль тогтоомжид заасан хэрэгслээр дамжуулан “үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол” гаргах журмыг оруулсан юм. Үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол гаргах систем 2012 оны 9 дүгээр сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол гаргах систем нь эрхийн зөрчлийн талаар гомдол гаргах арга болох бөгөөд хуулийн үндсэн хуульд нийцсэн эсэхийг эсвэл захиргааны актын хууль бус байдлыг хянах ажиллагаа, мөн шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хянах ажиллагаанаас ялгаатай юм. Европын Хүний Эрхийн Конвенцийн хүрээнд Үндсэн хуульд заасан аль нэг эрх, эрх чөлөө нь төрийн эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс зөрчигдсөн гэж гомдол гаргаж буй хувь хүмүүс шүүхийн хамгаалалтын хэрэгслийг хэрэглэж үр дүнд хүрээгүй тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй юм. Үндсэн хуулийн зөрчлийн талаарх өргөдлийг хүлээж авах, урьдчилан хянах комиссыг байгуулах бөгөөд эрх мэдлийг нь тодорхойлох мөн танхимын шийдвэр зэрэг асуудалтай холбоотой зарчим болон журмыг

хуулиар зохицуулдаг. Зарчмын хувьд Үндсэн хуулийн зөрчлийн талаарх өргөдлийг хүлээж авах үйл ажиллагаа нь хүмүүсийн эрх захиргааны эсвэл шүүхийн шийдвэрийн улмаас зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх хэрэгслээр хангаж үндсэн эрхийг хамгаалах үр дүнтэй хамгаалалт болж байдаг. Энэ нь Турк улсад Үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол гаргах системийг нэвтрүүлэх гол үндэслэл юм. Турк улсад энэхүү систем нь Европын Хүний эрхийн шүүхэд хувь хүн өргөдөл гаргах ажиллагаатай төстэй дотоодын хэрэгжилт болно гэж хүлээгдэж байсан. Үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол гаргах систем нь төрийн зүгээс үндсэн эрхийг зөрчсөн бодит явдлын үндсэн дээр зөрчлийг тодорхойлж арилгах шаардлагатай арга хэмжээг авах аргаар хангаж өгдөг. Уг системийг санаачлагчдын хүлээлтийн дагуу “Үндсэн хуулийн зөрчлийн талаарх гомдол гаргах системийг нэвтрүүлэх нь Туркийн эсрэг Европын Хүний эрхийн шүүхэд гаргадаг гомдлын тоог бууруулахад хүргэнэ” гэсэн найдвар байсан. Тиймээс, шинэ зохицуулалтын зорилго нь үндсэн эрхийг хамгаалах дотоодын хамгаалалтын хэрэгслийг бий болгох явдал байсан юм.

Гадаад дахь өөрчлөлтүүд Туркийн Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэрт, ялангуяа маргаантай бөгөөд нилээн ноцтой хэргүүдтэй холбоотой, их үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Тухайлбал, Европын байгууллагууд шүүхийн шийдвэр, үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байсан. Турк болон Европын Холбоо хоорондын хоёр талын харилцааны товчхон судалгаагаар ЕХ манай улсад ардчилсан өөрчлөлтүүдийг шинэчлэх үйл ажиллагааг 1990-ээд оноос санаачлан явуулж байсан. Энэхүү хүч чармайлт нь ЕХ-ны үзэж буйгаар Турк улс ЕХ-ны бүрэн гишүүн болох асуудалд маш их ач холбогдол өгч байгаа учраас тухайн улсын байгууллагууд нь хүний суурь эрхүүдийн цаашдын ардчилал, хөгжилд тавигддаг шаардлагыг хангах ёстой гэдэг асуудлаас улбаатай юм.

Туркийн урт хугацаанд явуулж буй баруунжих бодлогод гол байр суурийг эзэлдэг ЕХ дахь бүрэн

гишүүнчлэлийн асуудалд ЕХ Турк улсаас ардчилсан хөгжлийг баримтлахыг шаарддаг. Нөгөө талаас ЕХ-оос ногдуулж буй энэхүү үүргийг Туркийн хамгийн хуучинсаг үзэлтэй байгууллагууд, Үндсэн хуулийн шүүх ч хүлээн зөвшөөрдөг. Энэ байдал нь ЕХ болон бусад байгууллагуудаас Турк улсад ардчиллыг хөгжүүлэхэд илүү үндэслэлтэй болон шийдвэрлэх алхам хийхэд нь түлхэц болно.

Гэвч Туркийн Үндсэн хуулийн шүүх ардчилал болон эрх зүйт төрийг тогтоох асуудалд яаж, хэр хол явахыг харж ажиглах л үлдэж байна. Шүүх эсвэл үндсэн хуулийн зөвлөл эсвэл дээд шүүхийн хэрэглэсэн үндсэн хуулийн шүүх ажиллагаа нь Үндсэн хуулийг хүндэтгэн үзэх, хүний эрхийг хамгаалах үүргээ зөвхөн түүнийг хянаж буй эрх мэдэл болон үйл ажиллагаагаас хараат бус байгаа тохиолдолд хэрэгжүүлж чадна. Үндсэн хуулийн шүүх нь байгууллагын нөхцөл байдал шүүх буюу түүний үйл ажиллагааг дэмжиж, шүүх нь ардчилалд ээлтэй чиг баримжааг баримталж байгаа тохиолдолд ардчилал болон эрх зүйт төрийг хөгцүүлэх явцад нэмэр болж чаддаг.

Ишлэл:

Belge, Ceren (2006). “Friends of the Court: The Republican Alliance and Selective Activism of the Constitutional Court of Turkey”, *Law & Society review*, vol 40 no 3. ss: 653-691.

Lutz, Donald. S. (2000). “Thinking about constitutionalism at the start of the Twenty-First Century”. *Publius*, vol. 30. number 4. pp. 115-135.

Shambavati, Hootani and Esen Kirdis (2009). “In Pursuit of Contemporary civilizations’: Judicial Empowerment in Turkey”. *Political research Quarterly*, vol 62 no 4. dec. ss: 767-780.

Strauss, David. A. (1999). “What is Constitutional Theory”. *California Law Review*, pp: 581-592. vol. 87. number 3.

*Prof. Dr. Engin Yildirim,
Judge of the Constitutional
Court of Turkey*

CONSTITUTIONAL COURTS AND DEMOCRATIZATION: A TURKISH PERSPECTIVE

In recent decades, we have been witnessing global expansion of judicial power as all over the world Constitutional Courts have been given the power to declare acts of the executive or laws enacted by the democratically elected legislature unconstitutional. Constitutional Courts are important actors in modern democracies. Although their legitimacy is still controversial in political theory and philosophy, their major role in democratization and furthering democratic governance cannot be ignored. Whether or not constitutional courts are democratic actors is a controversial issue. Proponents of a strong constitutionalism stress that without constitutional courts, fundamental rights would not be as well protected and that without constitutional protection, these individual rights would be regularly flouted by democratic majorities. The opponents of strong constitutionalism on the other hand refer to the fact that the shift of decision-making procedures from directly elected parliaments to indirectly elected judges is weakening democracy (Strauss 1999). Constitutional courts play an important role in democratization by contributing that the state does not infringe on basic political rights and civil liberties. Court-based constitutional review as a way of controlling executive and legislative action is generally viewed to be one of the most important developments in constitutionalism.

The literature on judicial empowerment is divided into two basic categories: those seeing the expanded political role of the courts as the manifestation of a “rights revolution” and those that see judicialization as part of a conscious attempt by the dominant elite to safeguard their privileges against

emerging counter elite (Shambayati and Kirdis 2009: 768). Most critics of judicial activism often blame courts and judges for being hyperactive, excessively entangled with moral and political decision making and subsequently disregarding fundamental separation of power and democratic governance principles. Portraying courts and judges as the source of evil is misguided. Courts do not operate in a political, institutional and ideological vacuum. Judicial power is politically constructed. Its expansion through constitutionalization or judicial review does not develop separately from the concrete social cultural political and economic struggles

A constitutional court can play a positive role in democratic governance if it makes use of its powers and if it acts in a way that is functional for democracy. A court that does not make use of its powers is as detrimental as a court that exceeds its powers at the expense of the other branches of the government in a way that is harmful to democracy. In terms of institutional design, constitutional courts can increase the quality of democracy if they hold strong powers, if access to the courts is open and if the courts possess high popular legitimacy. An extension of the access to constitutional courts to various political courts and individual citizens contributes directly to the strong position of the Court.

Constitutions need to be viewed more as instruments for achieving general fairness and justice than as instruments for efficiently pursuing specific public policies. There has been a general and significant move in constitutional democracies toward “rights consciousness”. Under certain circumstances courts achieve a moral authority that places them above politics and allows them to make unpopular decisions. The moral authority or legitimacy means that people accept judicial decisions even those they bitterly oppose, because they view courts as appropriate institutions for making such decisions (Lutz 2000. 128).

Although we have witnessed a global expansion of judicial power and court-led rights revolutions, the Turkish Constitutional Court (TCC) became renowned for its restrictive take on civil liberties. Some high courts have been more activist than others in protecting and expanding civil rights and liberties (Beige. 2006; 653).

Turkey did not have a system of constitutional review until 1960; Turkish constitutional court was created by the constitution drafted after the military coup on May 27. 1960. The 1961 Constitution created this institution for constitutional review of legal actions by the legislature. The general reasoning behind the establishment of a constitutional court had been the fact that Turkey experienced a series of violations of its constitution, especially between 1950 and 1960 and that, in the absence of constitutional review, all these violations remained unsanctioned and thus provided a justificatory ground for the military coup.

The founders of the 1961 Constitution agreed on the necessity of a constitutional court to review the constitutionality of laws. Despite the debates over the structure, composition, function and organization of the Court, methods of selecting its judges and over the review of constitutionality, there was widespread conviction on the need for constitutional justice. The Turkish Constitutional Court began to carry out its activities in 1962. After the 1980 coup, a new constitution was adopted in 1982. The system of constitutional review established by the 1961 Constitution was preserved in the 1982 constitution with a few changes. Hence, the Constitution vested in significant powers to the judiciary. Any amendment with regard to the structure and duties of the Constitutional Court requires an amendment in the Constitution. The main function of the Constitutional Court has been to review the constitutionality of laws and other norms stated in the Constitution.

The power of the TCC derived not from its democratic legitimacy, but from its allegiances with the power centers of

the establishment, making it more of a guardian of the state than a constitutional court of rights and liberties.

From its establishment in 1962 until 1999, the CCT struck down more than half of the statutes referred to it (Beige 2006: 654). Nullification is considered the highest form of activism by most commentators (Smithey and Ishiyama quoted in Beige 2006: 665 para note 21). The CCT's annulment rates in abstract review was 65% between 1962 and 1982 and 82% between 1983 and 1999, while these rates were 54% between 1981 and 2000 in France, 53 percent between 1991 and 2000 in Germany), and 52 percent between 1981 and 1990 in Spain (Stone Sweet quoted in Beige 2006: 665). In addition to these activities, the constitutional court has reviewed 47 party closure cases during its 46-year long history. Only 6 out of these 47 were concluded during the period between 1961 and 1982 whereas closure of 33 political parties was requested in 41 lawsuits filed after the 1982 military coup.

The Constitutional Court occupies a central and controversial place in Turkish politics and legal system. Its role and functions have attracted different reactions and responses. While some praise the court for its service as a watchdog overseeing the fundamental values of the constitution, some others harshly criticize its actions. Critics mostly make reference to its attempts of shaping the political sphere, arguing this is a role that should be played by political parties.

The court's roles throughout its history point to a regular and consistent pattern, fostered by the motive to protect the regime and institutional setting created after the introduction of the republican order. This role is perfectly embedded in its legal and institutional setting. In many cases, it considered whether the predefined regime is under threat and what would be the best action to deal with this threat. Despite a strong political actor that features visible activism in many cases, the court remains silent even in some contentious occasions including cases referring to human rights violations

(Belge 2006). In other words, the court is politically active only selectively, suggesting that it appears to remain indifferent if the prerogatives of the state are at stake. It is suggested that the TCC was pursuing an ‘ideology-based’ approach putting emphasis on the interests of the state as it perceives them.

The CCT was standing in the way of liberalization of Turkish democracy during the 1990s. New courts in Eastern Europe and South Africa have been celebrated for their positive contribution to democratic transitions. The CCT stood as an obstacle to a more pluralistic democracy by closing down political parties that attempted to bring excluded identities into the political sphere. It is true that the authoritarian nature of Turkey’s constitution impedes TCC in departing from its ideology based approach. However, it is also true that the provisions of the Constitution with respect to the protection of rights and liberties are formulated in a vague and general way and the TCC has the discretion to interpret them in a democratic way.

In a recent referendum on constitutional amendments, Turkish Constitution now includes the procedure of “constitutional complaint” to be lodged under certain circumstances by individuals whose fundamental rights have been violated by means of legislative acts. The new constitutional complaint system is going to be come into effect in September 2012.

A constitutional complaint is a way to claim rights and is different from the examination of the unconstitutionality of law’s or of the illegality of administrative acts, or the cassation and review of judgments. All individuals, claiming that one of their constitutional rights and freedoms in the scope of the European Convention on Human Rights has been violated by public power, are entitled to apply to the Constitutional Court on condition that they have exhausted legal remedies. The principles and procedures on admissibility of applications of constitutional complaints, on establishment and competence of pre-review commissions and on judgments of the Chambers shall be regulated by law.

The function of constitutional complaint is in principle the effective protection of fundamental rights by giving remedy to the individuals in case of violation of their rights by administrative or judicial decisions. This is the main justification for introducing constitutional complaint in Turkey. Constitutional complaint system in Turkey is expected to be a domestic implementation similar to that of an individual application brought before the EC HR. From this aspect, it provides a way to determine violations by the state of fundamental rights and freedoms on a factual basis and to take the necessary measures to redress violations. But besides this justification in principle, there is a more practical consideration in this case. According the expectations of the drafters - as formulated in the reasoning - “The introduction of constitutional complaint will result in a considerable decrease in the number of files against Turkey brought before the European Court of Human Rights”. Thus the aim of the new regulation is to provide domestic remedy for the violation of fundamental rights.

External dynamics has also begun to play a remarkable role in the Final judgments delivered by the TCC. especially with respect to controversial and crucial cases. Particularly, the European institutions have a visible influence on the court’s actions and decisions. A brief survey of bilateral relations between Turkey and the EU reveals that the latter has acted eagerly since early 1990s to revive a wave of democratic transformation in the country . This eagerness is especially due to the EU actors’ awareness suggesting that Turkey places so great importance upon full membership in the EU that its institutions will comply with demands for further democratization and expansion of the sphere of fundamental rights.

Considering that full membership is central to fulfillment of its longstanding policy of Westernization, the EU often uses this as a carrot vis-a-vis Turkey to keep democratic progress on track. On the other side of the coin, there is recognition of this role of the EU by Turkey’s institutions, even the most conservative ones including the Constitutional Court.

This allows the external actors including the EU to exert greater pressure for more radical and determinative steps towards further democratization in Turkey.

It still, however, remains to be seen whether and in how far the TCC contributes to successful processes of democratization or the establishment of the rule of law. Constitutional justice applied by a court or a constitutional council or a specialized supreme court can only carry out its function of safeguarding the respect for the constitution and protecting human rights if it is genuinely independent from power, the activates from which it controls. Constitutional courts can indeed contribute to democracy and the rule of law. if the institutional circumstances support the work of the courts and if the courts show a democracy - friendly orientation.

References

Belge, Ceren (2006). “Friends of the Court: The Republican Alliance and Selective Activism of the Constitutional Court of Turkey”, *Law & Society review*, vol 40 no 3. ss: 653-691.

Lutz, Donald. S. (2000). “Thinking about constitutionalism at the start of the Twenty-First Century”. *Publius*, vol. 30. number 4. pp. 115-135.

Shambavati, Hootani and Esen Kirdis (2009). “In Pursuit of Contemporary civilizations’: Judicial Empowerment in Turkey”. *Political research Quarterly*, vol 62 no 4. dec. ss: 767-780.

Strauss. David. A. (1999). “What is Constitutional Theory”. *California Law Review*, pp: 581-592. vol. 87. number 3.

**Хууль зүйн шинжлэх ухааны
доктор, профессор Ч. Энхбаатар,
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг,
Удирдлагын академийн Захиргааны сургуулийн
захирал, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан,
Цэцийн зөвлөх**

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ БА УЛС ТӨР

Шүүх эрх мэдэл хүчээ авах хандлага нь ХХ зууны сүүлчийн хагасаас дэлхийн дахинаа ажиглагдах болсон. Үүнд *нэгд*, дэлхийн бараг орон бүр эдүгээ шүүхийн хяналтын дээд хэлбэр болсон үндсэн хуулийн хяналтын байгууллагыг ямар нэгэн хэлбэрээр тогтоосон, *хоёрдугаарт*, төрийн эрх мэдлийг хуваарилах онол шинэ үндсэн хуулиудын үндсэн үзэл баримтлал болсноор төрийн дээд байгууллагуудын хоорондын тэнцвэрт байдал тогтсон, *гуравдугаарт*, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх үүргийг үндсэн хуулиар ардчилсан төрд оногдуулсан нь төр иргэдтэй үргэлж бяр амтагдах байр сууринаас хандах явдал эцэс болсон зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн юм.¹

Ардчилсан хөгжлийн замыг сонгоод төдийлөн удаагүй байгаа орнуудын ихэнх нь үндсэн хуулийн хяналтыг ямар нэг байдлаар практикт нэвтрүүлсэн нь даяарчлалын үеийн энэхүү хандлага тэдгээр орныг тойроогүйг нотолж байна. Судалгаанаас харвал эдгээр орнууд голчлон үндсэн хуулийн хяналтыг төрөлжсөн шүүх хэрэгжүүлдэг төвлөрсөн хяналтын загварыг сонгожээ. Тухайлбал өмнө нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан ихэнх улс,² түүнчлэн хуучин социалист байсан орнууд

¹ Энэ үйл явц ялангуяа Зөвлөлт Холбоот Улс тэргүүтэй социалист систем нурснаар улам түргэссэн.

² ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан хуучин 15 холбооны бүгд найрамдах улсаас гагцхүү Туркмен улс үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагыг одоо хэр нь тогтоогоогүй байгаа. Эдүгээ 11 тусгаар тогтносон улс үндсэн хуулийн шүүхтэй, Казахстан улс үндсэн хуулийн зөвлөлтэй бөгөөд харин Эстони, Киргиз улс америкийн

нь үндсэн хуулийн хяналтыг үндсэн хуулийн шүүхийн хэлбэрээр тогтоосны зэрэгцээ³ Азийн олон орон ч дэлхий нийтийн жишгийг дагасан юм. Эдгээр шүүхийн шийдвэрүүд улс төрчид, эрдэмтэд, түмэн олны анхаарлыг татах тусмаа тэдгээрийн ач холбогдол улам нэмэгдсээр иржээ. Үндсэн хуулийн шүүхүүд дотор Европт Унгарын Үндсэн хуулийн шүүх, Азид Өмнөд Солонгосын Үндсэн хуулийн шүүх, Африкт Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх зэрэг шүүхүүд ихээхэн идэвхтэй үйл ажиллагааг явуулж байна.

Үндсэн хуулийн хяналт эдүгээ ийнхүү өргөн тархаж буйн нэгэн үр дагавар нь үндсэн хуулийн шүүхийн шүүгчид улс төрийн өнгө аястай шийдвэр гаргах үйл явцад татагдан орж байгаа явдал юм. Энэ нь үндсэн хуулийн шүүхүүд хууль дээдлэх ёсонд суурилсан ардчилсан дэглэмийг хамгаалах зорилгоор өргөн эрх хэмжээгээр хангагдсан байдгийн дотор зөвхөн үндсэн хуулийн шүүхүүд нь үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр төрийн дээд байгууллагуудаас, тухайлбал парламентаас батлан гаргасан шийдвэрийг хүчингүй болгох замаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хязгаарлах бүрэн эрхтэй⁴ учраас эдгээр шүүхүүдийн шийдвэрлэж байгаа асуудлууд дан ганц эрх зүйн чанартай биш,⁵ хэлэлцэж буй маргааны дотор улс төрийн шинж чанартай эрх

жишгээр Дээд шүүхдээ үндсэн хуулийн хяналтын танхимыг байгуулсан билээ. Армэн (Үндсэн хуулийн 196–р зүйл), Азербайжан (Үндсэн хуулийн 130–р зүйл), Беларусь (Үндсэн хуулийн 125–р зүйл), Гүрж (Үндсэн хуулийн 88–р зүйл), Казахстан (Үндсэн хуулийн 7а–р зүйл), Литва (Үндсэн хуулийн 102–р зүйл), Молдав (Үндсэн хуулийн 133–р зүйл), Орос Улс (Үндсэн хуулийн 125–р зүйл), Тажикистан (Үндсэн хуулийн 89–р зүйл), Украин (Үндсэн хуулийн 147–р зүйл) ба Узбекистан (Үндсэн хуулийн 107–р зүйл)-ны Үндсэн хуулиудын холбогдох зүйл, заалтыг үзнэ үү.

³ Албани (1992 оны Тулгуур хуулийн 7561), Болгар (Үндсэн хуулийн 147–р зүйл), Хорват (Үндсэн хуулийн 122–р зүйл), Польш улс (Үндсэн хуулийн 188–р зүйл), Румын (Үндсэн хуулийн 140–р зүйл), Чех Улс (Үндсэн хуулийн 84–р зүйл), Словак Улс (Үндсэн хуулийн 124 9с–р зүйл), Словени (Үндсэн хуулийн 160–р зүйл), Унгар (Үндсэн хуулийн 32а–р зүйл), Монгол Улс (Үндсэн хуулийн 68–р зүйл)

⁴ Үүнийг үндсэн хуулийн эрдэмтэн судлаачид сөрөг хууль тогтоох ажиллагаа гэж нэрлэж ирсэн юм. Учир нь нэгэнт батлагдсан хуулийг хүчингүй болгох нь хууль тогтоох ажиллагааны нэгэн бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг.

⁵ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн шүүх (зохиогчийн бичсэн “Төрийн ерөнхий онол”, УБ., 1998 он нэг сэдэвт бүтээлийн 20-р бүлэг. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл)”, 2007 он, 147 дахь талаас үзнэ үү.

зүйн маргаан цөөнгүй тохиолдож байгаатай⁶ холбоотой. Үүний гол үндэслэл нь төрийн аливаа байгууллагын үйл ажиллагаа, үүний дотор улс төрийн шийдвэр гаргах үйл явц нь Үндсэн хуулиар баталгаажуулсан ардчилсан зарчмын дагуу явагдах учиртайд оршино. Гагцхүү эрх баригчид энэхүү жанжин шугамаас хазайж хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан буюу Үндсэн хуулинд заасан журмыг гажуудуулсан, эсхүл үндсэн хуулийн заалтыг зөрчсөн шийдвэр гаргаснаас үндсэн маргааныг үндсэн хуулийн шүүх авч шийдвэрлэнэ.

Нөгөөтэйгүүр Үндсэн хуулийн шүүхүүд нь тухайн улсын хамгийн дээд хууль болох Үндсэн хуулийг хамгаалдгаараа үргэлж түмэн олны хараанд байдаг бөгөөд түүний шийдвэрүүд нь дуулиан тарих нь цөөнгүй. Улс төрийн институцүүд хоорондоо зөрчилдөж, хэл амаа олохоо больсноос болж улс төрийн гүн хямрал үүсэх, энэ нь нийгэмд нөлөөлж гудамжинд халих аюул нүүрлэх тохиолдолд энэхүү сөргөлдөөнийг эрх зүйн маргаан болгон хувиргаж намжаадгаараа үндсэн хуулийн шүүхүүд нийгэмд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг.⁷ Товчоор хэлбэл, үндсэн хуулийн хяналтын үндсэн зорилго нь улс төрийн өнгө аястай үндсэн хуулийн маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх, ингэснээр улс төрийн үйл явцыг үргэлж хуулийн хүрээнд байлгахад оршино. Учир нь хэрэв улс төрийн үйл явц хуулийн гольдрилоос халих юм бол үндсэн хуулийн хяналт учир утгаа алдана.

Үндсэн хуулийн шүүхүүдийн өсөн нэмэгдэж буй үүрэг ролийг шүүмжлэгчид нь ардчилсан журмаар сонгогдоогүй

⁶ Тухайлбал, Сонгуулийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль зэрэг олон хуулийн талаар гарч байгаа эрх зүйн маргаан нь цаанаа улс төрийн үр дагаврыг хадгалж байдаг учраас түүгээр гарсан Цэцийн шийдвэрийн үр нөлөө нь ч улс төрийн шинж чанартай байдаг. Н.Жанцан. Үндсэн хуулийн цэц ба үндсэн хуулийн үзэл санаа. “Шинэ толь” сэтгүүл, 2000 он, №31. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл)”, 2007 он, 153 дахь талаас үзнэ үү.

⁷ Дээрхи нөхцөл байдлын улмаас, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд үндсэн хуулийн хяналтын байгууллагыг Үндсэн хуулийн шүүх бус Үндсэн хуулийн цэц гэж нэрлэсэн, Цэцтэй холбоотой заалтуудыг “Шүүх эрх мэдэл” гэсэн дэд бүлэгт бус Үндсэн хуулийн тусгай бүлгээр зохицуулснаас үүдэн нэгэн үе Үндсэн хуулийн цэц шүүх мөн эсэх тухай маргаан өрнөсөн боловч эдүгээ улс төрч, судлаачдын дийлэнх нь Цэц бол шүүх гэдэг дээр санал нэгдсэн билээ.

шүүгчид ард түмний төлөөлөл болсон байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох нь ардчилсан зарчимд үл нийцэх тул үндсэн хуулийн хяналт нь шүүхийн мөн чанар, нийгмийн үүрэгт харшилна гэж үздэг боловч нэгэнт Үндсэн хууль өөрөө ард түмний бүтээл бөгөөд үндсэн хуулийн шүүгч нарт өөрийгөө хамгаалах бүрэн эрхийг хариуцуулсан тул үүнд нэг их маргаад байх зүйл байхгүй. Хуулийн энэ зохицуулалт нь шүүх эрх мэдэл улс төртэй хутгалдан сүлбэлдэх үр дагаварт хүргэнэ гэсэн үг биш. Хэдийгээр үндсэн хуулийн шүүхүүдийн зарим бүрэн эрх улс төрийн шинжтэй боловч эдгээр шүүхүүд нь улс төрийн бус, шүүхийн байгууллага гэдэг нь маргаангүй.⁸ Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг үндсэн хуулийн шүүхүүд улс төрийн үйл ажиллагааны зарим үр дүнд нөлөөлөх боломжтой байдаг нь түүний хамгаалалтын гол объект болох үндсэн хууль нь өөрөө мөн чанарын хувьд дээд хууль төдийгүй улс төрийн хүчнүүдийн зөвшилцлийн үр дүн байж, улс төрийн тоглоомын дүрмийг тогтоодгоороо улс төрийн баримт бичиг⁹ байдгаар тайлбарлагдана.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа ч улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас зарчмын ялгаатай. *Нэгд*, үндсэн хуулийн шүүхүүд өөрсдөө хэрэг, маргаан үүсгэдэггүй бөгөөд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь гагцхүү хуулиар зохицуулагдана. Үндсэн хуулийн шүүгчид маргагч талуудын гаргаж буй үндэслэлүүдийг хооронд нь харьцуулан дэнсэлсний үндсэн дээр дотоод итгэлдээ тулгуурлан хуульд суурилсан шийдвэр гаргах, шийдвэрийнхээ үндэслэлийг шийдвэртээ тусгах мэргэжлийн зохих бэлтгэлтэй байдаг. *Хоёрдугаарт*, шийдвэрлэж буй хэрэг, маргааны үр дүнд үндсэн хуулийн

⁸ Үндсэн хуулийн шүүхүүд тухайн орны шүүхийн тогтолцооноос ангид байж болох боловч тэдгээр нь шүүхүүд, тийм ч учраас шүүхийн хувьд эцсийн шийдвэр гаргах учиртай. Азийн ихэнх үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь эцсийн шийдвэр байдаг. Харин Монголын хувьд байдал арай өөр. Үндсэн хуулийн цэц үндсэн хууль зөрчигдсөн тухай шийдвэрээ Улсын Их Хуралд хүргүүлэх бөгөөд Их Хурал уг шийдвэрийг зөвшөөрч буюу эс зөвшөөрч болно. Хэрэв зөвшөөрвөл асуудалгүй, харин эс зөвшөөрсөн тохиолдолд Үндсэн хуулийн цэц их суудлаараа тухайн маргааныг дахин хянан шийдвэрлэж дийлэнх олонхийн саналаар эцсийн шийдвэрийг гаргана.

⁹ Үндсэн хуулиар улс төрийн харилцаа, улс төрийн тогтолцоо, төрийн улс төрийн бодлогын үндэс, хүний улс төрийн эрх, эрх чөлөөг бэхжүүлдэг.

шүүгчид ямар нэгэн хувийн ашиг сонирхолгүй байдаг. Хэрэв улс төрчид бизнесийн ертөнц буюу сонирхогч бүлгүүд, түүнчлэн байгаль хамгаалах зэрэг тодорхой зорилго бүхий хөдөлгөөнүүдтэй ямар нэг байдлаар холбоо сүлбээтэй байх нь ердийн зүйл бол шүүгчид аливаа ашиг сонирхлын зөрчилгүй байх нь хуулиар тэд нарын хувьд тогтоосон зарчимч шаардлага юм. Энэ нь үндсэн хуулийн шүүгчид бусад шүүгчдийн нэгэн адил хараат бус байж, хэрэг маргааныг голч шударгаар шийдвэрлэхийн баталгаа болдог.

Үндсэн хуулийн шүүхүүдийн гүйцэтгэж буй хоёрдмол үүрэг нь түүний бүрэн эрхээр илэрч байна. Тухайлбал, үндсэн хуулийн шүүхүүд нь хууль, бусад шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргаан, төрийн байгууллагын хоорон дахь эрх мэдэл булаацалдсан маргаан, төрийн дээд албан тушаалтан үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан, үйл ажиллагаагаараа үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр улс төрийн намуудыг татан буулгах эсэх тухай маргаан зэрэг яах аргагүй улс төрийн шинжтэй маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй.

Үндсэн хуулийн шүүхүүдийн бүрэн эрхийг улс орнууд өөр өөрөөр тогтоосон байдаг. Ихэнх шүүхүүд мөрөөр хэрэгжүүлэх хяналтыг сонгожээ.¹⁰

Энэхүү хяналтыг:

1. олон улсын гэрээ хэлэлцээрийн тухайд (Монгол Улс)
2. парламентаас баталсан хуулийн тухайд (Индонез, Тажикистан, Монгол Улс, Узбекистан зэрэг улс);
3. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн тухайд (Монгол Улс, Тажик Улс);
4. Төрийн тэргүүний зарлигийн тухайд) (Монгол Улс, Тажик Улс) тус тус хэрэгжүүлдэг юм.

¹⁰ Зөвхөн нэг тохиолдолд Азийн үндсэн хуулийн шүүх урьдчилсан хяналтыг хэрэгжүүлнэ. Тажик Улсын Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлийн дагуу тус улсын үндсэн хуулийн шүүх нь "...хараахан хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээ Үндсэн хуулинд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина" гэж заажээ.

Узбекистаны үндсэн хуулийн шүүхүүдийн бүрэн эрхэд үндсэн хуулийг тайлбарлах эрх багтдаг бол Индонезийн үндсэн хуулийн шүүх хуульд албан ёсны тайлбар өгөх бүрэн эрхтэй.

Үндсэн хуулийн шүүхүүдийн нэгэн чухал чиг үүрэг нь төрийн байгууллагуудын хооронд үүссэн эрх мэдэл булаацалдсантай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд оршино. Эдгээр маргааныг төрийн дээд байгууллагуудын хоорон дахь маргаан (Өмнөд Солонгос, Таджикистан зэрэг улс); төрийн төв болон бүс нутгийн буюу орон нутгийн нэгжүүдийн хоорон дахь маргаан (Өмнөд Солонгос, Таджикистан); орон нутгийн нэгжүүдийн хоорон дахь маргаан (Өмнөд Солонгос, Таджикистан); шүүх болон төрийн бусад байгууллагын хоорон дахь маргаан (Таиланд) гэсэн дөрвөн төрөлд хувааж болох юм.

Бодлого, үйл ажиллагаа нь үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр улс төрийн намыг тараах бүрэн эрхийг Өмнөд Солонгосын¹¹ болон Индонезийн үндсэн хуулийн шүүхүүд эдэлдэг.

Бүс нутгийн хэд хэдэн үндсэн хуулийн шүүх бүх нийтийн санал асуулга, сонгуулийг үндсэн хууль болон сонгуулийн тухай хуультай хэр нийцэж байгаад хяналт тавих бүрэн эрхтэй (Таиланд ба Индонез).

Зарим үндсэн хуулийн шүүхүүд нь иргэдийн өргөдөл, түүнтэй адилтгах эрх зүйн хэрэгслийг хэрэглэх замаар хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг хангадаг (Өмнөд Солонгос, Тажикистан).

Төрийн дээд албан тушаалтнуудтай холбоотой асуудлыг импичментын¹² журмаар шийдвэрлэх эрх нь үндсэн хуулийн шүүхүүдийн онцгой эрх юм. Бүс нутгийн шүүхүүдээс ерөнхийлөгчийг үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр хариуцлагад татах бүрэн эрхийг Индонез, Өмнөд Солонгос, Монгол Улсын үндсэн хуулийн шүүхүүд

¹¹ Солонгос Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 3 дахь хэсгийн 2-р зүйл.

¹² Төрийн дээд албан тушаалтныг хууль зүйн хариуцлагад татаж, хэргийг нь шүүхийн журмаар хянан шийдвэрлэх агуулга бүхий цогц ойлголт. Импичментын журмыг анх АНУ-ын Үндсэн хууль улс төрийн практикт нэвтрүүлсэн юм.

эдэлнэ. Түүнчлэн зарим үндсэн хуулийн шүүхүүд ерөнхий сайд, парламентын гишүүдийн тухайд ч ийм эрхийг хэрэгжүүлнэ.

Импичменттэй ойролцоо бүрэн эрх нь дээд албан тушаалтан мэдлэг, мэргэжил, ёс зүй, ур чадварын хувьд албан тушаалдаа тэнцэх эсэхийг шийдвэрлэх асуудал юм. Тухайлбал, Тайландын Үндсэн хуулийн шүүх нь Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Сенатын гишүүн, сайд, сонгуулийн хорооны гишүүд болон улс төрийн аливаа албан тушаалтан ажилдаа тэнцэж буй эсэх талаар шийдвэр гаргах эрхтэй. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Засгийн газрын ерөнхий сайд, гишүүд, Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор үйл ажиллагаагаараа Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргана.¹³

Үндсэн хуулийн шүүхүүдийн нэг онцлог нь түүнд хандах эрх бүхий этгээдийг ихэнх төлөв албан тушаалтнуудаар хязгаарласан явдал юм. Үүний шалтгаан нь хууль, төрийн байгууллагын бусад шийдвэр чухал ач холбогдолтой байдаг тул тэдгээрийг үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгохыг шаардах эрхийг нээлттэй болгох юм бол хуулийн тогтолцоо тогтворгүй болох аюултай. Узбекистанд үндсэн хуулийг зөрчсөн актын тухай өргөдлийг Олис Мажлис (парламент), улсын ерөнхийлөгч, Олис Мажлисын спикер, Каракапакстаны Дээд Зөвлөл, Дээд Шүүхийн болон Арбитрын Дээд шүүхийн ерөнхий шүүгчид, ерөнхий прокурор гаргах эрхтэй.¹⁴

Бусад орны хандлага нь илүү нээлттэй. Тажик Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн дагуу үндсэн хуулийн шүүхэд Ерөнхийлөгч, Мажлиси Олис (парламент), парламентын байнгын хороод, засгийн газар, парламентын гишүүд, Дээд шүүх, Арбитрын Дээд шүүх, Уулын Бадахшаны өөртөө засах район, ерөнхий

¹³ Үндсэн хуулийн шүүхүүд үндсэн хууль, холбогдох бусад хуулиар оногдуулсан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

¹⁴ Узбекистан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 19-р зүйл.

прокурор, яамд, төрийн бусад агентлагууд, иргэд хандах эрхтэй. Тайланд улс ч олон байгууллага, албан тушаалтанд үндсэн хуулийн шүүхэд хандах эрх олгосны¹⁵ дээр иргэд ердийн шүүхүүд, омбудсманаар дамжуулан үндсэн хуулийн шүүхэд шууд бус хандах эрхтэй байдаг.

Үндсэн хуулийн шүүхүүдийн гүйцэтгэж буй үүргийн хоёрдмол шинжийг илтгэсэн өөр нэг онцлог нь үндсэн хуулийн шүүгчдийг томилох, эсхүл сонгох журам байдаг. Эдгээр журам нь үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн хараат бус байдлыг хангахад чиглэгддэг. Бусад орны нэгэн адил үндсэн хуулийн шүүхийн гишүүдийг Азийн ихэнх оронд улс төрийн аргаар томилдог. Үндсэн хуулийн шүүгчдийг томилох, сонгоход үзүүлэх төрийн байгууллагуудын нөлөө орон бүрт харилцан адилгүй байдаг боловч гол төлөв хэд хэдэн төрийн байгууллага, дээд албан тушаалтан томилгооны үйл явцад оролцдог онцлогтой. Аль ч улсад парламент үндсэн хуулийн шүүхийн гишүүдийг томилох буюу сонгоход оролцдог юм. Хэрэв Узбекистан, Тажикистанд төрийн тэргүүний санал болгосноор парламент дангаараа үндсэн хуулийн шүүгчдийг томилдог бол бүс нутгийн бусад оронд шүүгчдийг томилох, сонгох үйл явцад парламентаас гадна төрийн тэргүүн, төрийн өөр байгууллага тус тус оролцдог. Тухайлбал, Монгол Улс, Өмнөд Солонгост Ерөнхийлөгч, парламент, Дээд шүүх гурав, гурван хүний нэрийг дэвшүүлж¹⁶ Монголд Улсын Их Хурал,¹⁷ Өмнөд Солонгост Ерөнхийлөгч тэдгээрийг албан тушаалд томилно.¹⁸

Үндсэн хуулийн шүүхийн даргыг томилох журам гишүүдийг томилох журмаас ялгаатай байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Зарим оронд шүүхийн дарга, орлогч даргыг парламент (Тажикистан, Узбекистан) буюу төрийн тэргүүн (Өмнөд Солонгос) томилдог бол Монгол Улсад Үндсэн хуулийн цэцийн гишүүд даргаа дотроосоо сонгодог.¹⁹

¹⁵ Тайландын Үндсэн хуулийн 47,63,96,118,142,177,180,198,219,262-264,266,295-р зүйлүүд.

¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3-р зүйлийн 1-5 дахь заалтууд, Солонгос Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 6|1|-р зүйл.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3-р зүйлийн 1 дэх заалт.

¹⁸ Солонгос Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6|1|-р зүйл.

¹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6-р зүйлийн 1-6 дахь заалтууд.

Гишүүд даргаа өөрсдөө сонгодог нь тус байгууллагын хараат бус байдлын шаардлагад бүрэн нийцсэн, хамгийн ардчилсан журамд тооцогддог юм. Даргын бүрэн эрхийн хугацаа ихэвчлэн гишүүдийнхээс богино байдаг (Монгол Улс, Өмнөд Солонгос Улсад гишүүдийнх 6 жил байхад даргынх 3 жил байдаг, энэ нь гишүүд дотроос сэлгээ хийх бололцоо олгодог). Гэхдээ дарга нэг удаа улиран сонгогдох боломжтой.

Нэгэнт үндсэн хуулийн шүүхүүд хууль, улс төрийн зааг дээр үйл ажиллагаагаа явуулдаг тул гишүүдийн бүрэн эрхийн хугацааг тогтоохдоо удаан хугацааны томилгоо нь үндсэн хуулийн хяналтыг хэт улс төржих магадлалтай болгох аюултай бол хэтэрхий богино хугацаа нь шүүхийн залгамж чанар, тогтвортой байдал, нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй гэсэн үндэслэлийг анхааралдаа авсан нь харагддаг. Азийн аль ч улс үндсэн хуулийн шүүгчдийг бүх насаар нь томилж буюу сонгодоггүй. Үндсэн хуулийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа нь таван жилээс (Узбекистан, Тажикистан) арван жилийн²⁰ хооронд хэлбэлздэг бөгөөд дундаж нь зургаан жил байна.

Гэхдээ ийм жижиг бүлгийн гарт асар их эрх мэдэл төвлөрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Европын орнуудад үндсэн хуулийн шүүгчдийг улиран сонгодоггүй тогтсон парктикаас²¹ ялгаатай нь Таиландаас бусад Азийн орнуудад үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг улируулахыг зөвшөөрдөг. Тэр бүү хэл улиран сонгогдох давтамжийг хязгаарлаагүй нь үнэн хэрэгтээ тэд бүх насаараа сонгогдох боломж нээлттэй байна гэсэн үг.

Тэдний бүрэн эрх нь үндсэн хууль буюу бусад хуулиар тогтоосон насны хязгаарт хүрснээр дуусгавар болно: 60 (Тажикистан), 65 (Өмнөд Солонгос). Гэтэл

²⁰ Киргизийн 2010 оны Үндсэн хуулиар Үндсэн хуулийн шүүхийг татан буулгаж, оронд нь Дээд шүүхэд үндсэн хуулийн танхимыг байгуулах хүртэл Киргизийн 1993 оны Үндсэн хуулиар Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа эхэлж 15 жил байснаа 2003 оны Үндсэн хуулиар 10 жил болж хорогдож, улмаар уг албыг хаших хугацааг 70 насаар хязгаарлаж байсан билээ.

²¹ Европын хоёр орон л үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг улируулан сонгохыг зөвшөөрдөг. Унгар шүүгчдийг нэг удаа улируулан сонгохыг зөвшөөрдөг бол Чех Улс энэ талаар ямар нэг хязгаар тогтоогоогүй нь хэдэн ч удаа дахин сонгогдож болно гэсэн үг.

Дорнод Европын үндсэн хуулийн шүүхүүд тэдгээрийг томилсон байгууллагаас хараат бусаар ажиллаж чадаж байгааг²² тэдгээрийг зөвхөн нэг бүрэн эрхээр томилдгоор тайлбарладаг.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд ажил мэргэжлийн өндөр шаардлага тавьдаг. Тэд олон жилийн ажлын туршлагатай байх шаардлагатай: Тажикистан улсад 10-аас доошгүй жил хуулийн салбарт ажилласан байхыг шаарддаг. Шүүгчээр томилогдох насны доод хязгаар нь Тажикистанд 30 нас, Өмнөд Солонгос Улс, Монголд 40 нас байна. Үүний зэрэгцээ Монгол Улс, Узбекистан, Тайландаас бусад Азийн ихэнх орон үндсэн хуулийн шүүхийг хуульчдаар бүрдүүлдэг. Харин дурьдсан гурван орон улс төрийн өндөр мэргэшилтэй хүнийг үндсэн хуулийн шүүхэд томилох буюу сонгохыг зөвшөөрдөг юм.

Үндсэн хуулийн мөн чанар, үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх болон түүний бүрэлдэхүүнд тавих шаардлага зэргээс үзвэл үндсэн хуулийн шүүх улс төрөөс бүрэн ангид байх боломжгүй нь ойлгомжтой. Хэдий тийм боловч үндсэн хуулийн шүүхүүдийг шүүх хэвээр байлгадаг нэг том хүчин зүйл бол шүүх бие даасан байх, шүүгч хараат бус байх зарчим хэлбэрэлтгүй хэрэгжиж байгаа явдал юм. Монголчууд бид Үндсэн хуулийн цэцийн дээр хөх тэнгэр л байдаг гэж хэлэх дуртай бол бусад оронд ч үндсэн хуулийн шүүхүүд хэний ч нөлөөнд үл автан үйл ажиллагаагаа явуулах бүхий л бололцоогоор хангагдсан байдаг. Аливаа үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах цорын ганц хэмжүүр нь тухайн улсын үндсэн хууль юм.²³ Үндсэн хуулийн гишүүдийн бүрэн эрхийн баталгааг ч үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон байдаг.

Бүс нутгийн үндсэн хуулийн шүүхүүд оршин тогтнох хугацаандаа улс төрийн үр дагавартай, дотооддоо дуулиан тарьсан төдийгүй гадаадын улс төрч, судлаачдын анхаарлыг ихээхэн татсан, нэг ёсны жишиг [прецедент]

²² Орос, Унгарын үндсэн хуулийн шүүхүүд жинхэнэ утгаар хараат бус байж эрх баригчдын эсрэг зоримог шийдвэр гаргаж байсан.

²³ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн шүүхийн болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим. “Газар, удирдлага, эрх зүй” (хамтын бүтээл), 2006 он. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл)”, 2007 он, 367 дахь талаас үзнэ үү.

болсон олон шийдвэрүүдийг гаргасан байдаг. Энэ бүх шийдвэрт нарийвчилсан дүн шинжилгээ хийх цаг хугацааны боломж байхгүй тул зарим нэгийг тоочсоноор хязгаарлая. Нутагтаа төдийгүй дэлхий дахинаа ихээхэн анхаарал татсан шийдвэрүүд дотор Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчийг импичментын журмаар хариуцлагад татах тухай Өмнөд Солонгосын үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, Коммунист намын гишүүдийн иргэний эрхийн тухай Индонезийн үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, Сонгуулийн комиссын шийдвэрийн тухай Казахстаны үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, Онц байдлын тухай Өмнөд Солонгосын үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, Цэргийг Ирак руу илгээх тухай маргаанаар гаргасан Өмнөд Солонгос Улсын үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, мөн улс орондоо хурц хямрал нүүрлэх үед Тайландын, Орос Улсын болон Киргиз Улсын үндсэн хуулийн шүүхийн баримталсан байр суурь зэргийг нэрлэж болно.

Зарим тохиолдолд үндсэн хуулийн шүүхүүд зарчимч байр суурийнхаа золиос болж байсан гашуун бөгөөд сургамжтай түүх байдгийг дурьдахад илүүдэхгүй болов уу. Оросын Үндсэн хуулийн шүүх ерөнхийлөгчийн эсрэг гаргасан шийдвэрүүдээсээ болж жил гаруйн хугацаанд үйл ажиллагаагаа явуулах бололцоогүй байдалд орсон бол парламентыг тараах, ард түмний хуралдайгаар шинэ үндсэн хууль батлах, улмаар үндсэн хуулийн шүүхийг тарааж оронд нь үндсэн хуулийн зөвлөлийг байгуулах үйл явцын эхлэлийг Казахстаны үндсэн хуулийн шүүх сонгуулийн зарим тойргийн дүнг хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгосон шийдвэр гаргаснаараа тавьсан билээ. Хоёр жилийн өмнө Киргиз Улсад өрнөсөн өнгөт хувьсгалын явцад 1993 оны Үндсэн хуулийг хамгаалах үүргээ хэрэгжүүлэхийн оронд төрийн эрх мэдлийг тэнцвэртэй байлгах, бие биенээ харилцан хянах, тогтоон барих механизмын үйлчлэлд сөрөг нөлөө үзүүлсэн, нэг хүний засаглалыг тогтоон бэхжүүлэхэд хүчин зүтгэсэн гэсэн үндэслэлээр Азидаа хамгийн анхны болох Киргиз Улсын Үндсэн хуулийн шүүхийг тус улсын Түр засгийн газрын 2010 оны 4-р сарын 2 дугаар захирамжаар

тарааж, улмаар мөн оны 6-р сард Киргиз Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэх үүргийг Дээд шүүхийн бүрэлдэхүүнд байгуулагдсан үндсэн хуулийн танхимд шилжүүлсэн юм.²⁴

Дүгнэлт

Үндсэн хуулийн шүүхийн нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг роль нь Үндсэн хуулиас түүнд итгэн олгосон бүрэн эрхийн логик үр дүн билээ. Үндсэн хуулийн шүүхүүд үйл ажиллагаагаараа ардчилсан нийгэмд үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлээд зогсохгүй төрийн институцүүд нэг нэгнээсээ харилцан хамааралтай, тэнцвэртэй, тогтвортой байхын зайлшгүй урьдчилсан нөхцлийг хангадаг юм.

Хууль, улс төрийн торгон зааг дээр ажилладаг үндсэн хуулийн шүүхүүдийн хувьд төрийн бусад институцийг хүндэтгэх, үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх явцдаа бусад байгууллагыг орлохгүй байх, хууль тогтоогчийн үүргээс аль болох зайлсхийх, улс төрчдөөс үргэлж зай барих, улс төрийн байгууллагын өмнөөс улс төр амтагдсан шийдвэр гаргахгүй байх үндсэн үүргээ ягштал хэрэгжүүлэх нь улс төр лүү хэт татагдан орохоос зайлсхийх, хараат бус байдал, голч шударга байдлыг хангах, Үндсэн хуулийн манаачийн үүрэгтээ чин үнэнч байх цорын ганц зам мөн.

Үндсэн хуулийн шүүхэд шууд буюу шууд бус дарамт шахалт ирж буй аливаа тохиолдолд бүх зүйл үндсэн хуулийн шүүгчдийн шударга, чин зоригтой байр суурь, ул суурьтай, тэгш, голч хандлага, Үндсэн хуулиа дээдлэх хүсэл тэмүүллээс шалтгаалах нь дамжиггүй.

Үндсэн хуулийн шүүхүүдийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, нэр хүнд, хараат бус байдал нь гагцхүү хүмүүсийн итгэл дээр суурилсан олон түмний дэмжлэгээр хангагдана. Чухамхүү улс төрөөс ангид баймааж үндсэн хуулийн шүүхүүд түмэн олны итгэл дэмжлэгийг хүлээх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

²⁴ Венецийн комисс энэ шийдвэрийг хурц шүүмжилсэн юм. Киргиз Улсын Үндсэн хуулийн төслийн талаарх 2010 оны 6-р сарын 8-ны өдрийн 582 дахь дүгнэлтийг үзнэ үү | Венецийн комиссын 2010 оны 6-р сарын 4-ний өдрийн 83 дахь удаагийн чуулганаар батлав|.